



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЭРДЭМ
СҮРГАЛТ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН



БОЛОВСРОЛЫН САЛБАРТ КОРОНАВИРУСТ ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ҮР ДҮН,
НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЭРДЭМ

СҮРГАЛТ СИДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ КОРОНАВИРУСТ ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

**ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ҮР ДҮН, НӨЛӨӨЛӨГЧ
ХҮЧИН ЗҮЙЛС**

Улаанбаатар хот
2020 он

ННА 74
ДАА 370
Ө-741

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ КОРОНАВИРУСТ ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

**ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖ, ҮР ДҮН, НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС**

Багийн ахлагч:

Б.ӨЛЗИЙСАЙХАН, хуульч, Хууль зүйн ухааны доктор

Багийн гишүүд:

Г.ТҮВШИНЖАРГАЛ, хуульч, Байгаль орчны шинжлэх ухааны магистр

В.ЧИМГЭЭ, хуульч, Хууль зүйн магистр

© Нээлттэй Нийгэм Форум

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9645-9-7

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	6
УДИРТГАЛ	7

НЭГ. ШИНЭ КОРОНОВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АЛСЫН ЗАЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

1.1 Цэцэрлэг, ЕБС-ийн болон онцлог хэрэгцээт бүлгүүдэд зориулсан теле-хичээл	11
1.2 Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад чиглэсэн боловсролын үйлчилгээ	19
1.3 Цар тахалтай тэмцэх арга хэмжээ ба 2019, 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалт	29
1.4 Их, дээд сургууль, коллежийн цахим сургалт	37

ХОЁР. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮР НӨЛӨӨ

2.1. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдахаас өмнө төрөөс боловсролын салбарт батлан хэрэгжүүлсэн эрх зүйн баримт бичиг	44
2.2 Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт боловсролын салбарт	53

ГУРАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗАЙНААС ХҮРГЭХЭД ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖИЙН НӨЛӨӨЛӨЛ

3.1 Цахилгаан эрчим хүчний дэд бүтэц боловсролын үйлчилгээнд нөлөөлөх нь	62
Цахилгаан эрчим хүчний хүртээмж	62
Цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай байдал	66
Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ	67
3.2 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц боловсролын үйлчилгээнд нөлөөлөх нь	72
Харилцаа холбооны салбарын өнөөгийн нөхцөл байдал	73
Интернэтийн хүртээмж	74
Интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж	81
Телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж	87
Гар утасны хэрэглээ боловсролын үйлчилгээнд нөлөөлөх нь	89

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Теле-хичээл хүргэхэд оролцсон хүний нөөц.....	12
Хүснэгт 2. Телевизээр цацсан теле-хичээлийн тоо, агуулгын түвшин, чиглэл	15
Хүснэгт 3. Суралцагчдын теле-хичээлд хамрагдалтын мэдээ	16
Хүснэгт 4. Судалгаанд оролцогч хүүхдүүдийн тухай ерөнхий мэдээлэл:.....	20
Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлийн төрөл	20
Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ багштай нь уулзсан байдал	22
Хүснэгт 7. 2019, 2020 оны ЭЕШ-ын дүнгийн харьцуулалт, газарзүйн байршлаар (төвийн болон баруун бүс).....	30
Хүснэгт 8. 2019, 2020 оны ЭЕШ-ын дүнгийн харьцуулалт, газарзүйн байршлаар (зүүн болон хангайн бүс, Улаанбаатар).....	32
Хүснэгт 9. 2019, 2020 оны ЭЕШ-ын дүнгийн харьцуулалт, сургуулийн байршлаар (нийслэл, аймаг, сум, баг)	33
Хүснэгт 10. 2019, 2020 оны ЭЕШ-ын дүнгийн харьцуулалт, сургуулийн өмчийн хэлбэрээр (төрийн болон төрийн бус өмчийн)	35
Хүснэгт 11. Өрхийн тоо, сууцны төрөл, цахилгааны эх үүсвэр, хот, орон нутагт (дүнд эзлэх хувиар, 2020 он)	64
Хүснэгт 12. Монгол Улсын цахилгаан хангамжийн найдвартай байдлын үзүүлэлт	66
Хүснэгт 13. Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн зарим үзүүлэлт боловсролд нөлөөлөх таамаг (чанарын үр дүн)	69
Хүснэгт 14. Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн зарим үзүүлэлт боловсролд нөлөөлөх таамаг (тоон үр дүн).....	70
Хүснэгт 15. Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид болон кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо	73
Хүснэгт 16. Интернет хэрэглээний 2018 болон 2019 оны статистик үзүүлэлт.....	76
Хүснэгт 17. Интернет хэрэглэгчийн тоо, жилээр.....	77
Хүснэгт 18. Суурин интернеттэй, интернетгүй өрхийн тоо, эзлэх хувь	78
Хүснэгт 19. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо.....	79
Хүснэгт 20. Суурин болон хөдөлгөөнт интернет ашиглах боломж, өрхийн төрлөөр ...	81
Хүснэгт 21. Интернетийн үйлчилгээ, компьютерын тоо, 2018 болон 2019 он.....	82
Хүснэгт 22. 1,000 хүнд ногдох компьютерын улсын дүн, оноор.....	82
Хүснэгт 23. Компьютерын тоо, жилээр.....	83
Хүснэгт 24. Нийслэлийн компьютертой өрхийн тоо, эзлэх хувь, 2018 он.....	84
Хүснэгт 25. Ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургууль, коллежид суралцагчид (бүс, аймаг, нийслэлээр, 2019 он)	86
Хүснэгт 26. Телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж (аймаг, нийслэл, 2019 он)	88
Хүснэгт 27. Гар утас хэрэглэдэг хүн ам (насны бүлэг, хүйс, хувиар, 2010, 2020 он)	90
Хүснэгт 28. Монгол Улсын гар утас хэрэглэгчийн тоо, 2020 он (ойролцоо дүнгээр)....	91
Хүснэгт 29. Боловсролын үйлчилгээнд цахилгаан эрчим хүчний болон мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц нөлөөлөх байдал.....	99

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	2020 оны 2-5 дугаар саруудад бэлтгэн телевизээр нэвтрүүлсэн хичээлийн цагийн тоо	14
График 2.	2020 оны 2-5 дугаар сард бэлтгэсэн хичээлийн тоо	14
График 3.	Суралцагчийн теле-хичээлд хамрагдалтын мэдээ	18
График 4.	2020 оны ЭЕШ-ын улсын хэмжээний үзүүлэлт, сургуулийн өмчийн хэлбэрээр	36
График 5.	Цахилгааны үүсгүүртэй малчин өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувь, 2019 он	65
График 6.	Зургаа болон түүнээс дээш настай хүн амд интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь, хот, орон нутгаар, 2010, 2020 он	75
График 7.	Зургаа болон түүнээс дээш настай хүн амын интернэтийн хэрэглээ, нас, хүйсийн суварга, 2010 болон 2020 он	76
График 8.	МУБИС-ын БТС-ийн оюутнуудын мэдээлэл харилцааны технологийн олдоц	86
График 9.	Зургаа болон түүнээс дээш настай хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь (хот, орон нутгаар, 2010 болон 2020 он)	93
График 10.	Сургуулийн орчин дахь ухаалаг утасны хэрэглээ	94

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Нэг хүнд ногдох дотоодын эрчим хүчний хэрэглээ (ГЖ/хүн), 2005-2016...67
Зураг 2.	Судалгааны өмнөх 3 сард компьютер, гар утас, интернэт хэрэглэсэн 15-19 насны залуучуудын тоон мэдээлэл (хувь, хүйсээр, 2018 он).....73

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

А.О.Д	Анхны онооны дундаж
АУНС	Алтай-Улиастайн нэгдсэн сүлжээ
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
МИДСК	Монголын их, дээд сургуулийн консерциум
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УОК	Улсын онцгой комисс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
Х.О.Д	Хэмжээст онооны дундаж
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ХХЗХ	Харилцаа, холбооны зохицуулах хороо
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
CAIDI	Нэг хэрэглэгчид оногдох дундаж тасалдлын хугацаа
DVD	Digital Versatile Disc буюу тоон горим бүхий пянз
Gbps	Нэг секундэд нэг гигабит буюу 1000 Mbps
IPTV/АйПиТиВи	Телевизийн олон сувгийн үйлчилгээний төрөл
LTE сүлжээ	Long Term Evolution нь гар утасны 4G сүлжээний стандарт
SAIFI	System Average Interruption Frequency Index буюу системийн тасалдлын дундаж тохиолдол

УДИРТГАЛ

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал манай улсын боловсролын салбарт шинэ сорилт бий болгож буй энэ цаг үед Улсын Их Хурал (УИХ)-аас 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталж, үйлчлэх хугацааг нь сунгах боломжтойгоор зохицуулсан билээ. Мөн Монгол Улсын Засгийн газар (ЗГ)-аас 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолыг баталж, эмнэлгийн салбарын бэлэн байдлыг хангах, хилээ түр хугацаагаар хаах, сургууль, цэцэрлэгийн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлыг судалж, шийдэх үүргийг салбарын сайд нарт өгчээ.

Дээрх чиг үүргийн дагуу Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд (БСШУС)-ын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/43 дугаар тушаалаар өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, хүүхэд харах төв, ерөнхий боловсролын сургууль (ЕБС), коллеж, их, дээд сургуулийг 2020 оны 1 дүгээр сарын 27-оос 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл танхимын хичээлийг түр хаах шийдвэр гаргасан. Энэ хугацаанд сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчмыг хангах сургалтын хөтөлбөр, агуулгын залгамж холбоог хангасан теле болон цахим хичээл бэлтгэж хэрэгжүүлснээр тухайн хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг дуусгасан байна.

“Эрдэм” сургалт судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилготой дээрх хууль батлахаас өмнөх болон баталснаас хойш ЗГ, Улсын онцгой комисс (УОК), боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гаргасан шийдвэр, зөвлөмж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эрчим хүч, мэдээлэл харилцаа холбоо, зам тээвэр зэрэг дэд бүтцийн хүртээмжтэй уялдуулан судлав. Уг судалгаа нь холбогдох байгууллагуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүртээмж, үр нөлөөний талаар мэдээлэх зорилготой хөндлөнгийн мониторингийн үр дүн юм.

Мониторингийн аргачлал

Зорилт

Уг мониторингийн хүрээнд судалгааны баг нь дэлхий дахинд нүүрлэсэн шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлыг Монгол Улсад тархахаас сэргийлэх зорилгоор нэвтрүүлсэн бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь боловсролын салбарт хэрхэн нөлөөлж буйг судалж, цаашид боловсролын үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг сайжруулахад анхаарах асуудлуудыг тодорхойлохыг зорилоо. Мониторингийг 3 сарын хугацаанд ажиглалт хийж хэрэгжүүлээ.

Үе шат

Мониторингийн ажлыг 3 үе шаттай зохион байгуулсан бөгөөд үүнд:

1. Судалгааны эхний шатанд зайн сургалтын нөхцөл байдлыг тоймлон зураглах зорилгоор салбарын яам, агентлаг, холбогдох бусад байгууллагаас мэдээлэл цуглуулав. Сургуулийн өмнөх ба бага, дунд боловсролын теле болон бусад хэлбэрийн сургалт; их, дээд сургууль, коллежийн цахим сургалтын тухай мэдээллийг зохион байгуулсан байгууллагаас авч, телевизээр цацагдсан теле-хичээлийн мэдээ, теле-хичээлд хамрагдсан байдал зэрэг нэмэлт мэдээлэлтэй нэгтгэн боловсруулав. Мөн ерөнхий боловсролын сургалт алсын зайн хэлбэрт шилжсэн явдал нь сурагчдын сурлагын амжилтад нөлөөлж буй эсэхийг тодорхойлох үүднээс Элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын энэ жилийн онооны тархцыг судалсан юм. Эцэст нь, 2019-2020 оны хичээлийн жилд тэгш хамруулан сургах боловсролын бодлого орон даяар албан ёсоор хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор алсын зайны сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад боловсролын үйлчилгээг үр дүнтэй хүргэж чадсан эсэхийг тодруулах зорилгоор ганцаарчилсан ярилцлагууд хийж нөхцөл байдлыг судаллаа.
2. Мониторингийн хоёрдох шатанд шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг хаах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр УИХ, УОК, ЗГ, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ) болон тус яамны харьяа байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажилласан тухай асуудалд төвлөрч ажиллав. Шинээр гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтийг баримтжуулахын тулд “Шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм,

эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдахаас өмнө боловсролын салбарт батлан хэрэгжүүлж байсан бодлого, шийдвэр ба тус хууль батлагдан гарснаас хойших хугацааны бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг харьцуулж үзэхийг зорив.

3. Мониторингийн гуравдах шатанд боловсролын алсын зайн үйлчилгээний хүртээмжийг цахилгаан эрчим хүч, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээний дэд бүтцийн өнөөгийн байдалтай уялдуулж шинжлэв. Тархуу сийрэг хүн амтай, том газар нутагтай, хөгжиж буй эдийн засагтай манай улсын хувьд зайнаас үйлчилгээ хүргэхэд цахилгаан эрчим хүч, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээ, мөн зам харилцаа чухал нөлөөтэй байх юм. Эцэст нь, шинээр бүрдүүлсэн мэдээлэл, гүйцэтгэсэн дүн шинжилгээ, гаргасан дүгнэлтүүддээ түшиглэн алсын зайны сургалтын бодлого зохицуулалт, зохион байгуулалт, гүйцэтгэлийг сайжруулахтай холбоотой зөвлөмж боловсруулав.

Мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах арга зүй

Энэхүү судалгаанд шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал шиг бүх нийтийг хамарсан онцгой нөхцөлд боловсролын үйлчилгээний хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор төрөөс гаргасан шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтэд мониторинг хийхдээ судалгааны баг нь хэд хэдэн эх сурвалжийн мэдээллийг харьцуулж баталгаажуулах байдлаар судалгааны найдвартай байдлыг хангах, мөн одоогоор нээлттэй тавигдаагүй мэдээллийг холбогдох байгууллагаас албан бичгээр хандаж гаргуулах, шаардлагатай тохиолдолд шинжлэх ухааны аргачлал ашиглан тооцоолж гаргах, мөн тодорхой асуудлаар ярилцлагад тулгуурласан кейсийн судалгаа хийх зэрэг аргуудыг ашиглав.

Боловсролын үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэлийн тухай тоон мэдээллийг салбарын статистикийн дүн мэдээнээс түүвэрлэн авч, үндэсний статистикийн дүн мэдээтэй тулган баталгаажуулав. Хичээл боловсруулах, гүйцэтгэхтэй холбоотой мэдээлэл, сургалтын технологиуд нэвтрүүлсэн тухай мэдээллийг БСШУСЯ, Боловсролын хүрээлэнгээс авч, дараа нь тодорхой тооны улсын болон хувийн боловсролын байгууллагаас ярилцлага авч баталгаажууллаа.

Харилцаа холбоо, мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн байдлыг судлах зорилгоор Харилцаа, холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-нд хүсэлт гаргасны дагуу 2019 оны зарим үзүүлэлтийг ирүүлсэн бөгөөд энэ мэдээллийг үндэсний болон олон улсын статистик мэдээтэй харьцуулах, мөн түүвэрлэн авсан тодорхой орон нутаг дахь боловсролын байгууллагаас ярилцлага авах зэргээр нягтлан шалгав.

Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн тухай мэдээллийг ханган нийлүүлэгч эх сурвалжаас авах боломжгүй тул олон улсын болон үндэсний статистик мэдээлэл, Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн эх сурвалж зэргийг ашиглан тооцоолж гаргасан болно.

“Боловсролын салбарт коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үзүүлж буй нөлөөлөл, түүнийг даван туулахад анхаарах зарим асуудал” судалгааны тайланг “Эрдэм” сургалт, судалгааны хүрээлэн ТББ-ын судлаачдын баг хийж гүйцэтгэв.

НЭГ. ШИНЭ КОРОНОВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АЛСЫН ЗАЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед дэлхийн улс орнуудад тулгарсан нэг нийтлэг асуудал бол цэцэрлэг, сургууль хаасан үед сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, хүртээмжтэй зохион байгуулах шаардлага байв. Цэцэрлэг, ЕБС-ийн теле-хичээл, их, дээд сургууль, коллежийн цахим сургалтыг зохион байгуулах, багш, суралцагчдын оролцоог хангаж, хяналт тавих зэргийг хэрхэн журамлаж, хэрэгжүүлсэн байдлыг харьцуулах зорилгоор эрх зүйн баримт бичгүүд, оролцогч талуудын өгсөн чанарын мэдээлэл, кейсийн судалгааны дүн зэргийг ашигласнаа тайлангийн уг бүлэгт танилцуулж байна. Энд 2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг хамран сургах тойргийн ЕБС-д элсүүлэн сургах бодлого хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тусгай хэрэгцээт боловсролын хэрэгжилтийг мөн хөндөх болно.

1.1 Цэцэрлэг, ЕБС-ийн болон онцлог хэрэгцээт бүлгүүдэд зориулсан теле-хичээл

Шинэ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор цэцэрлэг, ЕБС-ийн танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хаах шийдвэрийг ЗГ-аас 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр гаргасны дагуу зайн сургалтыг БСШУСЯ, түүний харьяа байгууллагууд шуурхай зохион байгуулж ажиллажээ. БСШУС-ын Сайдын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/43 дугаар тушаалаар 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс 6 дугаар сарын 1-ийг хүртэлх хугацаанд цэцэрлэг, ЕБС-ийн сургалтыг теле-хичээлийн хэлбэрээр зохион байгуулах шийдвэр гаргав. Боловсролын хүрээлэнгийн захирлын 2020 оны А/03, А/06, А/08, А/10 тоот тушаалаар батлагдсан теле-хичээлийн агуулга, хуваарийн дагуу Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь цэцэрлэг, сургууль, их, дээд сургуулийн багш нар, Монголын телевизүүдийн холбоотой хамтран теле-хичээлийн бичлэг хийх ажлыг зохион байгуулж, олон нийтэд зарласан хуваарийн дагуу телевизээр цацжээ. Эдгээр байгууллага нь теле-хичээлийг цэцэрлэгийн 263.3 мянган хүүхэд, ЕБС-ийн 640.4 мянган суралцагчид¹ хүргэх зорилго дэвшүүлжээ. Энэ нь 2019-2020 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ЕБС-д хамрагдаж байсан бүх хүүхдийн тоотой

¹ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/94 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт БСШУСЯ-аас 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдөр танилцуулсан өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн теле болон цахим хичээлийн талаарх товч тайлан.

дүйцэж² байгаа тул БСШУСЯ нь бүх нийтийн хүртээмжтэй теле-хичээл зохион байгуулах томоохон зорилт дэвшүүлжээ хэмээн дүгнэж байна.

Теле-хичээлийг зохион байгуулахад БСШУСЯ-ны 3, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ)-ийн 49, Боловсролын хүрээлэнгийн 34 мэргэжилтэн зөвлөгөө өгч, зохион байгуулалтыг хариуцан ажилласан бөгөөд нэмж 12 дугаар ангийн сурагчдад ЭЕШ-д бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Боловсролын үнэлгээний төвийн 13 мэргэжилтэн, насан туршийн боловсролын агуулгыг боловсруулахад Насан туршийн боловсролын үндэсний төвийн 11 мэргэжилтэн оролцжээ. Теле-хичээлүүдийг телевизийн 18 сувгаар урьдчилан зарласан хуваарийн дагуу дамжуулсан байна. Үүнээс харахад БСШУСЯ, түүний харьяа байгууллагууд теле-хичээлийг бэлтгэн, хүргэх ажилд салбарын 500 гаруй мэргэжилтнийг шуурхай зохион байгуулж, ТВ-үүд, хандивлагч нартай хамтран гүйцэтгэжээ (Хүснэгт 1-ийг харна уу.).

Хүснэгт 1. Теле-хичээл хүргэхэд оролцсон хүний нөөц³

Байгууллага	Чиг үүрэг	Оролцож ажилласан хүний тоо
БСШУСЯ	Бодлогын дэмжлэг, зөвлөгөө (УОК, ЗГ, БСШУСЯ-ны Сайдын тушаал, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах)	3
Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	Арга зүйн зөвлөгөө Зохион байгуулалт (бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж оролцох)	49
Боловсролын хүрээлэн	Арга зүйн зөвлөгөө Зохион байгуулалт (теле-хичээлийн агуулга, хуваарийг батлах, телевизүүдтэй хамтран ажиллах)	34
Боловсролын үнэлгээний төв	Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл	13
Насан туршийн боловсролын үндэсний төв	Насан туршийн боловсролын агуулга бэлтгэх	11
Телевизийн ажилтан		170
Хичээл заасан багш	Сургуулийн өмнөх боловсрол	20
	Ерөнхий боловсрол	314
	Тусгай хэрэгцээт боловсрол	28
	Насан туршийн боловсрол	10

² Эх сурвалж: <https://www.meds.gov.mn/>

³ Теле-хичээл зохион байгуулсан тайлан. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, 2020 он, 5 дахь тал

Байгууллага	Чиг үүрэг	Оролцож ажилласан хүний тоо
	Дохионы хэлний хэлмэрч	20
	Элсэлтийн ерөнхий шалгалт	20
	Зочин багш	16
	Бусад (зөвлөх)	2
Хандивлагч байгууллага	5	
Телевиз	18	
Бичлэг хийсэн байгууллага	Цэцэрлэг ⁴	3
	Сургууль ⁵	7

Үүсээд буй онцгой нөхцөлд хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, хүртээмжтэй хүргэх нөр их ажлын шуурхай зохион байгуулалтыг БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ хариуцан ажиллажээ. Теле-хичээл заах багшлах бүрэлдэхүүнд 428⁶ багш багтсаны 97.6 хувь (418 багш) нь нийслэлийн, 2.4 хувь (10 багш) нь орон нутгийн цэцэрлэг, сургуулийн багш нар байжээ. Хөдөө орон нутгийн багшийн тоо цөөн байгаа нь хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотой бололтой. Эдгээрийн 70 хувь нь төрийн, 30 хувь нь төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн багш нар байна.

Теле-хичээлийн хэрэгжилт

Боловсролын хүрээлэнгийн захирлын тушаалаар⁷ теле хичээлийн агуулга, хуваарийг баталж, нийтдээ 2872 цагийн хичээл тус тус бэлтгэн телевизээр цацаж, цэцэрлэг болон ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сургалтын хөтөлбөрт туссан агуулгыг бүрэн хамруулахыг зорьжээ (График 1-ийг харна уу.).


⁴ Нийслэлийн 46, 70, 146 дугаар цэцэрлэг

⁵ Нийслэлийн ерөнхий боловсролын 1, 11, 20, 73 дугаар сургууль, МУБИС-ийн харьяа ЕБС, Шинэ Эрин, Шинэ Монгол сургууль

⁶ Теле-хичээлийг бэлтгэн заахад нийслэл, орон нутгийн цэцэрлэг, сургуулиуд шилдэг тэргүүний 428 багшаа оролцуулж хамтран ажилласнаас хамгийн олон багш оролцуулсан нь Шинэ үе (17 багш), нийслэлийн 23 дугаар сургууль (13 багш), Шинэ Монгол (9 багш) сургуулиуд байна. Теле-хичээл зохион байгуулсан тайлан. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, 2020. 7 дахь тал


⁷ Боловсролын хүрээлэнгийн захирлын “Телевизээр явуулах хичээлийн агуулга, хуваарь батлах тухай” 2020 оны А/03 тоот тушаал, “Теле-хичээлийн агуулга, хуваарь батлах тухай” 2020 оны А/06 тоот тушаал, “Теле-хичээлийн агуулга, хуваарь батлах тухай” 2020 оны А/08 тоот тушаал “Теле-хичээлийн агуулга, хуваарь батлах тухай” 2020 оны А/10 тоот тушаал.

График 1. 2020 оны 2-5 дугаар сард бэлтгэн телевизээр нэвтрүүлсэн хичээлийн цагийн тоо



Тэрчлэн 2-5 дугаар сард сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, ахлах анги, тусгай болон насан туршийн боловсролын нийтдээ 3902 хичээл бэлтгэн, 18 телевизээр дамжуулсан байна (График 2-ыг харна уу.).

График 2. 2020 оны 2-5 дугаар сард бэлтгэсэн хичээлийн тоо



Хүснэгт 2. Телевизээр цацсан теле-хичээлийн тоо, агуулгын түвшин, чиглэл⁸

№	Анги, дэд салбар	II сар	III сар	IV сар	V сар	Нийт
1	Сургуулийн өмнөх боловсрол	40	50	40	110	240
2	1-р анги	26	26	43	88	183
3	2-р анги	26	26	45	87	184
4	3-р анги	26	26	45	90	187
5	4-р анги	27	26	48	116	217
6	5-р анги	32	33	54	124	243
7	6-р анги	33	39	63	127	262
8	7-р анги	34	46	74	157	311
9	8-р анги	35	47	76	183	341
10	9-р анги	32	47	75	180	334
11	10-р анги	46	51	92	165	354
12	11-р анги	47	54	109	179	389
13	12-р анги	54	58	122	190	424
14	Тусгай хэрэгцээт боловсрол			54	54	108
15	Элсэлтийн ерөнхий шалгалт		66	44	40	150
16	Бага боловсролын багш				22	22
17	Насан туршийн боловсрол	14	30	40	40	124
		472	625	1024	1952	4073
18	Үндэсний цөөнх (казах, тува)		277		135	412
			2398		2087	4485

Боловсролын хүрээлэнгийн захирлын “Теле-хичээлийн агуулга, хуваарь батлах тухай” 2020 оны А/13 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1, 2 дугаар улиралд заагдах теле-хичээлийн зэрэгцээ нэмэлтээр 3 ба 4 дүгээр улиралд заагдах 149 теле-хичээлийг бэлтгэн, бүтэн хичээлийн жилийг бүрэн хамарсан нийт 4073 теле-хичээлийн бичлэг бэлтгэж, сан бүрдүүлжээ.

Дээрх мэдээлэлд үндэслэн дүгнэхэд теле-хичээлийн тоо, хичээлийн сэдэв нь батлагдсан хөтөлбөрийн агуулгыг бүрэн хамарч боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчимд нийцүүлэн, тухайн түвшний боловсролын стандартыг ханган, сурлагын хоцрогдол гаргахгүй байхад төрөөс анхаарч ажиллажээ гэж дүгнэж болохоор байна (тусгай хэрэгцээт болон хос хэлний боловсролд хамаарахгүй). Харин теле-хичээл нь бүх нийтийн хүртээмжтэй,

⁸ Теле-хичээл зохион байгуулсан тайлан. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, 2020. 12 дахь тал

чанартай байж чадсан эсэхийг үнэлэхэд нэмэлт дүн шинжилгээ хийх шаардлагатай. Уг судалгааны хүрээнд хүртээмжтэй холбоотой зарим асуултад хариу өгөх бол БСШУСЯ-ны захиалгаар болон хөндлөнгийн үнэлгээний байгууллагын хийж буй судалгаанаас сургалтын чанартай холбоотой мэдээлэл дүгнэлт гарч, мэргэжлийн байгууллагуудад зөвлөмж хэлбэрээр хүргэж буй юм.

Теле-хичээлд хамрагдсан байдал

Сургуулийн өмнөх, бага болон дунд боловсролын суралцагчдын теле-хичээлд хамрагдалтын (2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс мөн оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэл) мэдээг аймаг, нийслэлээр ангилан Хүснэгт 3-т харууллаа.

Хүснэгт 3. Суралцагчдын теле-хичээлд хамрагдалтын мэдээ⁹

№	Аймаг, нийслэл сум, дүүрэг		II сар	III сар	IV сар	V сар	Дундаж
			Дундаж хувиар	Дундаж хувиар	Дундаж хувиар	Дундаж хувиар	
1	Архангай	Аймгийн төв	91	93	82	70	84
		Сум	72	54	48	48	55.5
2	Баян-Өлгий	Аймгийн төв	68	73	79	78	74.5
		Сум	52	59	64	68	60.75
3	Баянхонгор	Аймгийн төв	65	63	61	60	62.3
		Сум	58	56	53	52	54.5
4	Булган	Аймгийн төв	75	74	73	73	74
		Сум	77	75	73	72	74
5	Говь-Алтай	Аймгийн төв	61.8	67.3	60.7	62.4	63.1
		Сум	66.4	65.1	61.1	61.5	63.5
6	Говьсүмбэр	Аймгийн төв	77.8	71	65.7	70	71.1
		Сум	82	81.9	81.4	86	82.8
7	Дархан-Уул ¹⁰	Аймгийн төв	56.9	53.6	58.3	66.8	55
		Сум	43.7	52.5	55.6	50.8	49.6
8	Дорноговь	Аймгийн төв	75.6	74.2	72.5	73.7	74
		Сум	75.6	73.1	70.5	70.2	72.6
9	Дорнод	Аймгийн төв	72	86	85	88	83
		Сум	65	73	75	77	72
10	Дундговь	Аймгийн төв	68.5	61.4	62.3	64.5	64.175
		Сум	68.5	61.4	62.3	64.5	64.175

⁹ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/94 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт БСШУСЯ-аас танилцуулсан өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн теле болон цахим хичээлийн талаарх товч тайлан мэдээлэл. 2020 оны 6 дугаар сарын 29

¹⁰ Дархан-Уул аймаг нь 327.5 мянган га газар нутагтай, Дархан, Орхон, Хонгор, Шарын гол гэсэн 4 сум, 26 багтай.

Хүснэгт 3-ын үргэлжлэл

№	Аймаг, нийслэл сум, дүүрэг		II сар	III сар	IV сар	V сар	Дундаж
			Дундаж хувиар	Дундаж хувиар	Дундаж хувиар	Дундаж хувиар	
11	Завхан	Аймгийн төв	71.48	78.6	66.3	62.3	69.67
		Сум	69.2	65.2	61.2	58.2	63.45
12	Орхон	Аймгийн төв	94.6	95.4	93.6	90.4	93.5
		Сум	92.6	94.4	89.6	87	90.9
13	Өвөрхангай	Аймгийн төв	84	88.3	90.1	80.3	85.6
		Сум	83.7	86.5	88.2	76.2	83.6
14	Өмнөговь	Аймгийн төв	71.3	70.5	65.1	67.7	68.65
		Сум	69.3	63.6	60.6	61.8	63.825
15	Сүхбаатар	Аймгийн төв	80	80	75	73.6	77.15
		Сум	82	78	76.5	72.6	77.2
16	Сэлэнгэ ¹¹	Аймгийн төв	97	95	92	97	95.25
		Сум	92	85	80	94	87.75
17	Төв	Аймгийн төв	94.06	87.06	77.94	75.16	82.5
		Сум	73	71.86	65.2	62.05	66.75
18	Увс	Аймгийн төв	86.2	67.1	71.8	64.6	72.4
		Сум	72.2	57.3	59.7	75.9	66.3
19	Ховд	Аймгийн төв	65.8	64.1	63.7	54.6	62.05
		Сум	55.6	56.5	57.9	41	52.75
20	Хөвсгөл	Аймгийн төв	76.77	69.32	61.98	65.54	68.4
		Сум	68.55	65.99	58.86	65.32	64.68
21	Хэнтий	Аймгийн төв	95	94.6	94.3	94.9	94.7
		Сум	94.3	93.7	92.7	93.1	93.45
22	Улаанбаатар	Баянгол	94	95	93	92	93.5
		Баянзүрх	87.8	85.3	80.2	79.8	83.2
		Багахангай	85.75	82.7	82	87.25	84.4
		Налайх	87	88	86	90	87.75
		Сонгинохайрхан	89.5	87.5	85	84	86.5
		Сүхбаатар	92	93	90.6	92.5	92
		Хан-Уул	92	93	92.6	92.7	92.7
		Чингэлтэй	80.2	75.1	88	86	82.3
		Дүүргийн дундаж	88.5	87.5	87.2	88	88.4
Улсын дундаж		76.6	75.6	73.7	73.4	74.7	
Аймаг		76.7	76.5	73.9	72.9	75.0	
Сум		72.0	69.9	68.3	68.4	69.5	


¹¹ Сэлэнгэ аймаг нь 41.2 мянган дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, 17 сумтай

Теле-хичээлд хамрагдалтын улсын дундаж 74.7 хувь, аймгуудын дундаж 75 хувь байна. Аймгийн төв, нийслэлийн 9 дүүргийн сурагчдын оролцоо 90 хувьд дөхсөн өндөр үзүүлэлттэй байгаа бол сумдын дундаж 70 орчим хувьтай гарчээ. Улаанбаатарт теле-хичээлд хамрагдалт 88.4 хувь байна. Нийслэлийн хэмжээнд нутаг дэвсгэр, хүн ам, орон нутгаас шилжин ирэгсэд зэрэг үзүүлэлтээр тэргүүлэх Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн сурагчид теле-хичээлд идэвхтэй оролцож буй дүн гарчээ. Сэлэнгэ аймаг 95.3 хувийн хамрагдалтаар улсдаа тэргүүлж байгаа бол Дархан-Уул аймаг 55 хувийн хамрагдалттайгаар сүүл мушгижээ (График 3-ыг харна уу.).

Теле-хичээлд хамрагдалтын энэхүү дүн мэдээг сургууль бүрийн бүрдүүлж ирүүлснээр аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар нэгтгэн Боловсролын хүрээлэнд ирүүлсэн мэдээллээр энд тайлагнаж байгааг бид дурдах нь зүйтэй.

Теле-хичээлийн хамрагдалтыг аймаг, сум, нийслэл, дүүргээр задалж гаргасан нь мониторинг хийх, дараа дараагийн бодлого, үйл ажиллагааны алхмуудаа төлөвлөхөд дэмтэй болсныг мөн тэмдэглэх нь зүйтэй юм. Уг мониторингийн судалгааны хувьд энэхүү задаргаа мэдээ нь боловсролын оролцоог улсын дэд бүтцийн хүртээмжтэй холбож дүгнэхэд тус дэм боллоо.

График 3. Суралцагчийн теле-хичээлд хамрагдалтын мэдээ



1.2 Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад чиглэсэн боловсролын үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд ЕБС-д суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо 2017 онд 7,279 байсан бол 2018 онд 6,518, 2019 онд 6,053 болж буурчээ.¹² 2019 оны байдлаар ерөнхий боловсролын 640,400 орчим суралцагчийн 1 хүрэхгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах тойргийн ЕБС-д элсүүлэн сургах бодлого 2019-2020 оны хичээлийн жилд албан ёсоор хэрэгжиж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн тасралтгүй сурах, чанартай боловсрол эзэмших эрхийг хангаж ажилласан асуудлыг энэхүү судалгааны хүрээнд авч үзэх үндэслэл болов.

2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т хөгжлийн бэрхшээлтэй хүний "...сурч боловсрох, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох ...эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх" төрийн үүргийг тодорхой зааж, 6.3.3 дахь хэсэгт "... хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах"-ыг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ гээд, 14.1.3 дахь хэсэгт "... бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх", 14.1.4 дэх хэсэгт "... хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн" сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр тус тус заажээ.

Уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор БСШУС-ын Сайдын 2019 оны А/292 тоот тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилээс "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам" батлагдав. Энэхүү журмаар хөгжлийн бэрхшээлтэй сурагч ердийн сургууль, эсвэл тусгай сургуульд сурах сонголтыг эцэг эх, асран хамгаалагчийн хамтаар өөрөө хийж, ердийн ЕБС-д элсэх тохиолдолд шаардлагатай нэмэлт дэмжлэгийг хангах үйл явцыг журамласан юм. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн ЕБС-д тэгш хамруулан сургах бодлого албан ёсоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд харин эхний жилд нь цар тахлын улмаас алсын зайнаас суралцах шаардлага тулгарчээ.

¹² Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, бүс, аймаг, нийслэлээр, https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2002_058V1

Боловсролын хүрээлэн нь 4, 5 дугаар сард тусгай хэрэгцээт боловсролын 108 теле-хичээл бэлтгэж, ТВ-ээр хүргэжээ. Улмаар тусгай хэрэгцээт боловсролын теле-хичээл нь ЕБС-ийн теле-хичээлээс хожуу эхэлж, эрт дууссан байна. “Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл (нөхцөл байдлын судалгаа)” судалгаанд¹³ шүүмжлэлт хоёр асуудал хөндөгдсөн бөгөөд үүнд теле-хичээлийн дохионы хэлний чанар сайнгүй байснаас гадна дэлгэц нь жижиг тул харагдахгүй, мөн теле-хичээл үзэж байгаа хүүхдэдээ туслахын тулд эцэг эхчүүд ихэнх тохиолдолд бусдаас дэмжлэг авах шаардлага тулгарч байжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн зайн сургалттай холбоотой тайлан, мэдээ хомс байгаа тул энэхүү судалгааны хүрээнд Архангай, Дорнод, Дорноговь, Ховд аймгууд, Улаанбаатар хотын¹⁴ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 20 эцэг, эхтэй уулзаж, алсын зайн сургалтын чанартай холбоотой 12 ерөнхий асуултын дагуу ганцаарчилсан ярилцлага хийв.

Хүснэгт 4. Судалгаанд оролцогч хүүхдүүдийн тухай ерөнхий мэдээлэл:

Хүүхдийн насны байдал	5	8	9	11	12	13	14	15	16	17
Хүүхдийн тоо	3	2	3	1	1	2	3	0	2	1

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлийн төрөл

Хөгжлийн бэрхшээл	Оюуны бэрхшээл	Сонсголын бэрхшээл	Харааны бэрхшээл	Хавсарсан хөгжлийн бэрхшээл	Бусад
Хүүхдийн тоо	6	4	4	2	4

Судалгаанд нийт 20 хүүхэд оролцсоноос 12 нь буюу 60 хувь нь улсын сургуульд, 2 нь тусгай сургуульд суралцаж байгаа ажээ.

Судалгаанд оролцсон 1 хүүхэд л бие даасан, бусад 19 хүүхэд (95 хувь) байнгын хараа хяналт шаардлагатай байсан ажээ. 10 хүүхэд нь байнгын халамжлах хүн байгаа бол ижил тооны буюу 10 хүүхдийнх нь хувьд байнга харах хүн байхгүй гэж эцэг, эх нь хариулжээ. Байнга харах хүнгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хичээлийг давтуулах боломжгүй болж, хүүхэд хичээл сурлагаар хоцрох эрсдэл нэмэгддэг тухай оролцогчид дурдсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхэд хөгжлөөр хоцрох илүү их эрсдэлтэй ч хүүхэд

¹³ Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл (нөхцөл байдлын судалгаа). Нээлттэй Нийгэм Форум. 2020. 4 дүгээр тал.

¹⁴ Ганцаарчилсан ярилцлагад Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 4, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд, Архангай аймгийн Эрдэнэбулган сум, Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумд, Дорнод аймгийн Хэрлэн сум, Ховд аймгийн Жаргалант, Дуут сумдаас тус бүр нэг төлөөлөгч оролцов.

хөгжүүлэх нийтийн үйлчилгээ, хөтөлбөрт хамрагдаж чадахгүй орхигдох нь их байна. Мөн тэд тусгайлсан буюу зорилтот дэмжлэг тусалцаа авч чадахгүй хоцордог бөгөөд тэдний гэр бүлд эрх зүй болон төрийн бодлогын мэдлэг дутмаг байхын зэрэгцээ олон нийтийн сөрөг хандлага, хангалтгүй үйлчилгээ, хүртээмжгүй орчин зэрэг янз бүрийн саад бэрхшээл тулгардаг байна. Хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хөгжүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хамгаалалтыг хөгжлийн хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлүүдэд цаг алдалгүй хүргэж чадахгүй бол тэдэнд тулгарах хүндрэл, бэрхшээл улам гүнзгийрч, яваандаа ядуурал, нийгмийн амьдралаас тусгаарлагдахад хүргэдэг.¹⁵

Үүсээд буй шинэ нөхцөлд ТВ хичээлийн чанар, хүртээмж муу байгаа тул “боловсролын асуудал орхигдож байна”, “маш хүнд асуудал болж байна”, “сурлагын хоцрогдол үүсэж байна” гэж оролцогчид онцолжээ. Бий болсон хамгийн хүндрэлтэй асуудлыг тодруулахад хүүхэд нь хичээл сурлагаар хоцорч байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлсэн эцэг, эх хамгийн олон (12 эцэг, эх) байсан бөгөөд тэдний дунд хүүхэд нь хичээл огт хийгээгүй 3 хүн байв. Мөн хүүхэд нь нийгэмшихгүй байгаа (7 эцэг, эх), хүүхэд харах хүн олдохгүй байгаа (6 эцэг, эх) зэрэг нийтлэг хүндрэл эцэг эхчүүдэд тулгарчээ. Бараг асуудал байгаагүй гэж 2 хүн л хариулсан байв. Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дийлэнх нь хичээлээс хоцрогдон, нийгмийн харилцаа нь хязгаарлагдаж байх магадлалтай.

Теле-хичээлийн чанар, хүртээмж нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцэхгүй байна гэсэн хариулт илт давамгайл байлаа. 11 хүн буюу нийт оролцогчдын 55 хувь нь “хэтэрхий хурдан заадаг, нөхөж үзэж чаддаггүй”, 5 оролцогч буюу нийт оролцогчийн 20 хувь нь “хүүхэд ойлгодоггүй” гэж хариулсан бөгөөд нэмэлтээр 15 хүн буюу нийт оролцогчийн 75 хувь нь “ТВ хичээлүүд хүүхдийн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн онцлог хэрэгцээнд нийцсэн байх шаардлагатай” гэсэн санал дэвшүүлжээ. Үүнээс дүгнэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд теле-хичээлийн чанар, хүртээмж сайнгүй байсан байна.

Алсын зайн сургалтад шилжсэнээр багш, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын холбоо харилцаа багасжээ. Танхимын сургалтын үеэр багш нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн онцлогийг харгалзан дасгал, гэрийн даалгавраа зохицуулан тусгайлан бэлтгэж өгдөг байсан бол алсын зайн сургалтын явцад ийм боломж байхгүй болсон гэж эцэг эхчүүд хэлж байв. Зайн сургалтад

¹⁵ Нээлттэй Нийгэм Форум, Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл: Асуудал дэвшүүлсэн тайлан, 2015 он, 5 дугаар тал, https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/75355/9789997332028_mon.pdf?sequence=9&isAllowed=y

шилжсэнээр хүүхдийнхээ багштай харилцах боломжгүй болж, хүүхэд хичээлээ ойлгохгүй хоцорсон ч багшаас нөхөж асууж, хүүхдэдээ туслах боломжгүй болсон байна. Энэ дүгнэлтийг өөр судалгаанууд мөн баталж байгаа бөгөөд жишээлбэл, “Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл” судалгаанд сургууль, багш нь хүүхэд, эцэг эхтэй холбоо тасалдаж, эцэг эх нь санаачилга гаргахгүй бол ангийн багш асууж сурагладаггүй байдал нийтлэг байгаа¹⁶ тухай онцолжээ.

Хүүхдийнхээ багштай холбогдсон, уулзсан байдлыг судалж үзэхэд 1 хүн хариулаагүй бөгөөд үлдсэн 19 хүнээс 8 нь буюу 42 хувь нь багштай уулзсан, 11 нь буюу 58 орчим хувь нь уулзаагүй байна. Багштай уулзахад саад болсон хүчин зүйлсийг асуухад Улаанбаатарт машингүй тохиолдолд нийтийн унаагаар явах хүндрэлтэй, зардал их гардаг бол хөдөө орон нутагт сургуулиас хол учир уулзах боломжгүй, хуваарийн дагуу үйлчилдэг албан газар (цэргийн анги)-ын автобусаар явдаг тул ажил хөөцөлдөх боломжгүй байдаг зэрэг хүндрэлийг дурдсан байв.

Хүүхдийнхээ багштай уулзсан тоон үзүүлэлт харьцангуй өндөр байгаа боловч уулзалтын мөн чанар нь хүүхэдтэйгээ ажиллахад эцэг эхэд зөвлөн туслах зорилготой уулзалт цөөн байв. Эцэг эхчүүд хичээл хэвлүүлж авах, замдаа ороод гарах зэрэг хүүхдийн хичээл сурлагын талаар зөвлөлдөх, даалгаврыг нь шалгуулахтай холбоогүй шалтгаанаар багштай уулзахаас гадна ихэнх нь нэг, хоёр удаа л уулзсан байна (Хүснэгт 6-г харна уу.).

Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ багштай нь уулзсан байдал

	Хариулаагүй	Тийм	Үгүй	Бүгд
Баянзүрх (дүүрэг)	0	0	1	1
Дуут (сум)	0	1	0	1
Жаргалант (сум)	0	0	3	3
Мандах (сум)	0	0	1	1
Сонгинохайрхан (дүүрэг)	0	0	1	1
Сүхбаатар (дүүрэг)	0	0	1	1
Чингэлтэй (дүүрэг)	0	1	0	1
Хан-Уул (дүүрэг)	1	2	1	4
Хатанбулаг (сум)	0	1	1	2
Хэрлэн (сум)	0	1	1	2
Эрдэнэбулган (сум)	0	2	1	3
Нийт	1	8	11	20

¹⁶ Ковид-19 ба хөгжлийн бэрхшээл (нөхцөл байдлын судалгаа). Нээлттэй Нийгэм Форум. 2020. 4 дүгээр тал.

Багштай харилцах арга замын хувьд 5 тохиолдолд багш гэрээр ирж хичээл давтуулан, давтлага өгсөн байна. Үлдсэн 11 тохиолдолд эцэг, эхчүүд гар утас, фэйсбүүкийн чатаар хүүхдийнхээ багштай холбогдсон байх ч 2 хүн зөвхөн гар утсаар, 2 хүн зөвхөн фэйсбүүкээр, бусад 7 нь хоёр сувгийг давхар ашиглажээ. Багштай уулзаж, давтлага, зөвлөгөө авсандаа эцэг эхчүүд ерөнхийдөө сэтгэл ханамжтай байгаа ч хүүхдийн сурлагын хоцрогдол, нийгэмшихүйн хязгаарлагдмал байдалд санаа зовох нь хүүхдийнхээ багштай холбоо харилцаагүй эцэг, эхчүүдээс ялгаагүй байв.

Багштай холбогдоогүй эцэг, эхээс шалтгааныг лавлахад багш өвчтэй байсан, хүүхдээ хөдөө явуулсан, дунд ангид орсноор олон багштай болсон тул хүүхдийг тоохгүй байгаа, багш угаасаа тоодоггүй, ялгаварлан харьцдаг зэргээр хариулжээ. Улмаар хүүхдийн эцэг, эх, эсхүл хүүхэд өөрөө багштайгаа уулзсанаар сурлагын ахицад эергээр нөлөөлж чадахгүй байх магадлалтай бөгөөд үүнийг танхимын сургалт шиг тогтмол холбоо харилцаа байхгүйгээр тайлбарлаж болох юм.

Хүүхдийн сурлагад нөлөөлж буй багшаас бусад хүчин зүйлийг эцэг эхчүүд мөн нэрлэжээ. Эцэг эх нь дохионы хэл мэдэхгүй, эсвэл хичээлийг нь ойлгохгүй, заах арга зүйн мэдлэггүйн улмаас хүүхдийнхээ хичээлийг давтуулж чадахгүй байгаа, мөн хичээл давтуулах цаг гаргаж чадахгүй байгаа нь хүүхдийн сурлагын амжилтад сөргөөр нөлөөлнө гэж эцэг эцэг, эхчүүд эмээж байна. Харааны бэрхшээлтэй хүүхэд удаан хугацаагаар дэлгэц ширтэж хичээл хийх боломжгүй, гар утас удаан үзэж чадахгүй, харах чадвар сул тул өгөгдлийг бүрэн харж чадахгүй зэрэг шалтгаанаар теле-хичээлийн хурдыг гүйцэхгүй хоцорч, улмаар хичээлээ ойлгохгүй үлддэг ажээ. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх нь дохионы хэл мэдэхгүйгээс хүүхдийнхээ хичээлийг нэмж тайлбарлах, давтуулах боломжгүй, теле-хичээлийн дохионы хэлний чанар муу тул хичээлээ ойлгохгүй байгаадаа хүүхдүүд уурлаж бухимддаг байна. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд бичиж чадахгүй тул багш нь аман хариулт авах зэргээр хувилбарт арга зүй ашиглан ажиллаж байсан бол алсын зайн сургалтын явцад ийм тохируулга хийх боломжгүй болж эцэг эх нь хүүхдийнхээ гарыг барьж бичүүлж байгаа ч ТВ хичээлийн хурдыг гүйцэхгүй хоцордог байна. Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх нь зайн сургалтад шилжсэнээс хойш хичээл огт хийгээгүй, багшаас давтлага авах боломжгүй, багш нь тоохгүй байгаа зэрэг хүндрэл, бэрхшээлийг дурдав.

Хил хаасны улмаас хүүхдийн байнга уудаг эм нь тасарсан, хүүхдээ харахын тулд эцэг, эх ажил хийхгүй байгаа зэрэг боловсролын үйлчилгээнд шууд хамаарахгүй боловч дам сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл байдал бий болсныг анхаарах нь зүйтэй.

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон өрхүүдийг цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр нь авч үзэхэд, 14 өрх буюу 50 хувь нь төвийн эрчим хүчинд холбогдсон, Ховд аймагт амьдардаг 3 өрх Оросын Холбооны Улсаас эрчим хүч авдаг гэсэн бол 2 өрх аймгийн цахилгаан станцад холбогдсон, Улаанбаатар хотын нэг өрх айлаас тог авч байгаа гэв. Эрчим хүчний найдвартай байдлын хувьд Улаанбаатар хотын айл өрхүүдийн тог бараг тасалддаггүй ч Сүхбаатар дүүргийн нэг өрхийн тогны хүч их муу, олон юм залгавал тасардаг бөгөөд тог тасрах нь хэвийн үзэгдэл болсон гэж хариулав. Ховд аймгийн айл өрхүүдийн цахилгаан намрын улиралд тасалдах нь их болдог бол орон нутгийн бусад өрх бүгд л хааяа хааяа тог тасардаг гэж хариулжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эдгээр 20 өрхөөс 11 нь Улаанбаатар болон аймгийн төвд амьдардаг бөгөөд суурин интернэттэй бол бусад 9 өрх суурин интернэтгүй ч 5 нь гар утасны хөдөлгөөнт интернэт ашиглах, ажил дээрээ интернэтэд холбогдох зэргээр интернэтийн тогтмол хэрэглээтэй ажээ. Харин огт интернэтгүй 4 өрх байв. Суурин интернэттэй өрхүүд давхар бас гар утсаараа хөдөлгөөнт интернэт ашиглаж байгаа нь ажиглагдсан юм. Интернэт холболт харьцангуй найдвартай, тасалдал нэг их гардаггүй ч хөдөлгөөнт интернэтийн хурд унах, мэдээллийг уншихгүй байх, сүлжээ тасалдах тохиолдол гардаг бол суурин интернэт нь тог тасрах, төлбөр төлөөгүй зэргээс бусад шалтгаанаар тасардаггүй гэсэн хариулт нийтлэг байв. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт Кевико интернэтийн хурд муу, бороо орохоор гацдаг тухай мэдээлэв. Улмаар интернэтээр алсын зайн хичээл сургалт явуулах, сургалтын нэмэлт материал байршуулах, цахим анги танхимд хамрагдах бол уг судалгаанд оролцсон 20 өрхийн 4 буюу 20 хувь нь огт интернэтгүй, үлдсэн 16 буюу 80 хувь нь суурин, эсвэл хөдөлгөөнт интернэтийн нэгийг, эсхүл хоёуланг ашиглах боломжтой ч зөвхөн хөдөлгөөнт интернэт ашиглаж байгаа өөр 5 өрх буюу дахиад 25 хувь нь найдвартай интернэтгүй байгааг анхаарна уу.

Теле-хичээлийг ухрааж, нөхөж үзэх шаардлага бараг бүх өрхөд тулгардаг бөгөөд энэ асуултад хариулаагүй 4 оролцогчийг хасаад, үлдсэн 16 оролцогчийн 15 нь нөхөж үзэх шаардлагатай байдаг гэжээ. Нөхөж үзэх шаардлагагүй гэж хариулсан нэг оролцогч нь цэцэрлэгийн насны хүүхэдтэй бөгөөд теле-хичээлийг хүүхдэдээ үзүүлэх шаардлагагүй гэж эцэг, эх нь үзсэн байв. Нэг өрхийн сургуулийн насны хоёр хүүхдийн ТВ хичээлийн цаг давхцах, хичээлийн хурдыг гүйцэхгүй, ойлгохгүй байх тул давтаж, нөхөж үзэх хэрэгцээ гардаг байна. Шаардлагатай байгаа ч теле-хичээлийг нөхөж үзэх боломжтой эсэхийг судлахад хариулаагүй 2 оролцогчийг хасаад, үлдсэн 18 өрхөөс 2 нь л ийм үйлчилгээнд хамрагдсан байх ба үлдсэн 16 өрх нь интернэт протоколд суурилсан телевизийн үйлчилгээнд хамрагдаагүй учир нөхөж үзэх боломжгүй байв. Улаанбаатар хотод 47.6 хувь,

орон нутагт дунджаар 11.4 хувийн хүртээмжтэй энэ үйлчилгээ улсын хэмжээнд төдийлөн хангалттай хэмжээнд хүрээгүй тул энэ үйлчилгээний хэрэглэгч өрхийн тоо судалгааны хүрээнд хязгаартай байгаа нь ойлгомжтой юм. Хоёр хүүхдийн теле-хичээл давхцаад хоцорчихдог тул нөхөж үзэх аргагүй болохоор багшаас нь заавал очиж давтлага авах, Лүүк ТВ (Look TV)-д эхэндээ үнэгүй тавигдсан ТВ хичээлийг эцэг, эх нь үзэж тэмдэглэж аваад хүүхдэдээ зааж өгдөг байсан ч сүүлдээ төлбөртэй болсноос хойш үзэхээ больсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ТВ-хичээлийн зарим зүйлийг ойлгохгүй тул давтаж үзэх хэрэгцээ байгаа ч ухрааж үзэх боломжгүй тухай хөдөө орон нутгийн эцэг эхчүүд ярьж байв. Дээр дурдсан нөхцөл байдлаас дүгнэхэд, зайн сургалтын чанарт теле-хичээлийг нөхөж үзэх боломж хүчтэй нөлөөлөх бөгөөд ТВ хичээл үзэх ёстой нэгээс олон хүүхэдтэй, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд нөхөж үзэх шаардлага бодитойгоор тулгарч байна.

Шигтгээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Яг тэр цагт нь үзээгүй л бол сурлагын хоцрогдолтой болчихоод байна. Манайх шиг айл ялангуяа нөхөж үзэх ямар ч боломжгүй болохоор гарах давтамжийг нь сайжруулах арга хэмжээ авмаар байна. Интернэтээр үзье гэхээр боломжоороо авсан дата маань маш хурдан дуусчихдаг. Уг нь интернэтийг хямдруулах зэрэг арга хэмжээ авчихвал багш руу нь байнга очилгүй үзчихэж болох л юм байна билээ.

Ганцаарчилсан ярилцлагын оролцогч

Интернэтэд холбогдох төхөөрөмжийн хувьд Улаанбаатар хотын нэг оролцогч интернэтэд холбогдох төхөөрөмж байхгүй, бусад бүх оролцогч гар утсаар холбогддог бөгөөд тэдний 4 нь буюу 21 хувь гар утаснаас гадна зөөврийн компьютер давхар ашигладаг ажээ. Улмаар интернэтэд холбогдох боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 79 хувь нь зөвхөн гар утсаараа хичээл үзэж байгаа бөгөөд энэ нь тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байх магадлалтай.

Судалгааны оролцогчдоос гар утас хэрхэн нөлөөлж байгаа талаар асуухад “Хүүхэд утас их оролдвол хурдан ядардаг. Утсаар дата авахаар хааяа ажиллана, ажиллахгүй тохиолдол ч их бий”, “Гар утсаар интернэт орохоор нүд нь өвддөг”, “Гар утас их үзэхэд нүд нь өвддөг”, “Теле-хичээлд гар утас тохиромжгүй байдаг”, “Утас удаан ширтвэл толгойнд нь ачаалал өгч нүд, толгой нь өвддөг”, “Ер нь гар утас ашиглуулахаас зайлсхийдэг”, “Утсаараа л ихэвчлэн интернэт ордог. Манай хүүхэд харааны бэрхшээлтэй болохоор утас их үзэхээр нүд нь улайгаад өвддөг. Зөөврийн компьютероор ороход том дэлгэцтэй учраас харьцангуй

гайгүй байдаг”, “Хөгжлийн бэрхшээл нь хараатайгаа хавсарсан болохоор утсаар интернэт ашиглахад хүндрэлтэй байдаг”, “Таталт өгдөг болохоор утас, нотебүүк их харж тархинд ачаалал өгөхөөс зайлсхийдэг” гэсэн ихэвчлэн сөрөг хариулт өгчээ. Харин хоёр оролцогч “Дата болон шаардлагатай бүх зүйл байвал хүндрэл бага гардаг”, “Дата, интернэтийн хурд л гэхээс бусдаар төдийлөн асуудал байдаггүй” гэсэн эерэг хариулт өгсөн байлаа.

БСШУСЯ-ны www.econtent.edu.mn вэбсайтад байршуулсан хичээлийг үзэж ашиглаагүй 18 оролцогч, ашигладаг 2 оролцогч байлаа. Тус вэбсайтыг ашиглаагүй оролцогчдын дийлэнх нь мэдэхгүй учраас үзээгүй гэж хариулжээ. Мэддэг боловч ашиглаагүй 2 оролцогчийн нэг нь теле-хичээл хүүхдэдээ үзүүлэхийг хүсээгүй бол нөгөөх нь IPTV ашиглан ухрааж үздэг учир ашиглаагүй байна. Энэхүү вэбсайтын талаар оролцогчдод тайлбарласны дараа уг эх сурвалжийн талаарх тэдний сэтгэгдлийг дахин асуухад 12 оролцогч “ашиглах боломжтой байсан байна” гэж хариулжээ. Иймд БСШУСЯ-ны www.econtent.edu.mn вэбсайтад байрлуулсан хичээлийг үзэхгүй байгаа үндсэн шалтгаан нь тус вэбсайтын талаар мэдлэг, мэдээлэл байхгүйтэй холбоотой гэж дүгнэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүдээс авсан ганцаарчилсан ярилцлагаар алсын зайн сургалтыг сурагчийн хэрэгцээнд нийцүүлэх арга хэмжээ авах, хичээлийн хурдыг сааруулах, дохионы хэлний орчуулгын чанарыг сайжруулж дүрсийг томруулах, зарим хичээл дээр дохионы хэлний орчуулга байхгүй байгааг анхаарах, багш нар гэрээр ирж хүүхэдтэй ажиллах боломжийг нэмэгдүүлэх, ТВ хичээлийг нөхөж үзэх боломжийг сайжруулах гэсэн санал гаргаж байлаа.

Дэд бүлгийн дүгнэлт

2019-2020 оны хичээлийн жилээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутгийнхаа ЕБС-д, эсхүл тусгай сургуульд суралцах сонголт нээлттэй болсон. 2020 оны 2 дугаар сараас цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд цэцэрлэг, сургуулиуд алсын зайн сургалтад шилжихэд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан теле-хичээлүүдийг тусад нь бэлтгэж төрийн зүгээс тодорхой хэмжээнд санаачилга гарган ажилласан нь баримт бичгийн судалгаанаас харагдав. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөр өөр хэрэгцээтэй тул хэрэгцээг нь хангахад туслах хувилбарт арга зүй, сургалтын материал, зорилтот дэмжлэг шаардлагатай бөгөөд ийм ганцаарчилсан дэмжлэггүйгээр сурлагаар хоцрох эрсдэл нэмэгддэг байна.

2016 онд УИХ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг

бүрдүүлэн, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэн, тэгш хамруулан сургахдаа онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт хэрэгжүүлэх тухай заасан. Уг хуульд хөгжлийн бэрхшээлийн улмаас боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандахыг хориглосон. Харамсалтай нь, коронавируст халдварын цар тахлын үед хуулийн эдгээр зүйл заалтаас нэг нь ч бүрэн хэрэгжээгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Тэгш хамрагдан суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ерөнхийдөө теле-хичээлийн хурдыг гүйцэхгүй, дохионы орчуулгыг харж чадахгүй байсан учраас ойлгохгүй өнгөрөх нь их, энэ нөхцөлд туслах ганцаарчилсан зөвлөгөө, тохируулгат сургалтын арга зүй, сургалтын материал байхгүй байв. Хууль, журмаар уг дэмжлэгийг хангаж өгөх үүрэгтэй сургууль, багш нь хүүхэд, эцэг эхтэй холбоо тасарч, эцэг эх нь санаачилга гаргахгүй бол ангийн багш асууж сурагладаггүй байдал нийтлэг байгаа нь нотлогдсон гэж үзэж байна.

Зайн сургалтын хугацаанд багш нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн хэрэгцээг харгалзан сурах үйл явц, сургалтын материалд тохируулга хийх, ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх, эцэг эхэд зөвлөгөө өгөх боломжгүй болсон нь түгээмэл хүндрэл байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн багш нь гэрээр ирж уулзах, давтлага өгөх, эцэг эхэд зөвлөж ажилласан сайн туршлага байгаа бөгөөд үүнийг эцэг эхчүүд маш их сайшааж байв. Гэвч нийтлэгээр багштай уулзаж давтлага авсан тохиолдол харьцангуй цөөн (энэ судалгаагаар 21 орчим хувь) бөгөөд ихэвчлэн эцэг, эх нь гар утсаар, эсвэл фэйсбүүкээр багшаас чиглэл, зөвлөмж авч байжээ. Заримдаа багш нь өвчтэй, тоохгүй зэрэг шалтгаанаар багштай ярьж чадахгүй байх явдал гарч байжээ. Мөн багштай уулзаж, зөвлөгөө авсан нь цөөн, нийт алсын зайн сургалтын хугацаанд нэг хоёр тохиолдлоос хэтрээгүй байна. Багшаас давтлага, зөвлөгөө авсан хүүхдүүдийн сурлагад ахиц гарч, эсхүл хоцрогдол арилсан тухай судалгааны явцад дурдагдаагүйгээс үзэхэд цөөн удаа уулзах, давтлага авах, даалгавар шалгуулах нь эцэг эхийн сэтгэл санаанд эерэг нөлөөлж болох боловч сургалтын чанарыг хадгалах, сайжруулах нийтлэг арга хандлага болж чадахгүй байгааг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ихэвчлэн (уг судалгаанд оролцогчдын 95 хувь) байнгын анхаарал шаардлагатай тул алсын зайн сургалтын явцад тогтмол анхаарал тавьж ажиллах, хүүхдийн хичээлийг давтуулах эцэг эхтэй ажиллах арга замыг эрэлхийлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлийн онцлогийг харгалзсан дэмжлэг үгүйлэгдэж байгаа нь ажиглагдлаа. Харааны бэрхшээлтэй хүүхдүүд гар утас, ТВ-ээр хичээл үзэх

боломжгүй, дунд нь завсарлах, ухрааж үзэх, дахин дахин сонсох хэрэгцээтэй ч ийм боломж олгоогүй байна. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд дохионы хэлний орчуулгын чанар муу, хэлмэрчийн дүрс хэт жижиг зэрэг нь ТВ хичээлээ үзэж ойлгоход ноцтой саад учруулжээ. Танхимын сургалтын үеэр саажилт зэргийн улмаас бичгээр хариулж чадахгүй үед багш аман харилцаа зэрэг сургалтын хувилбарт арга ашиглаж байсан бол зайн сургалтын үеэр ийнхүү арга зүйн тохируулга хийх боломж алдагдсан байна. Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүд багштайгаа уулзахын тулд автобус, машинаар явж очих хэрэгтэй болж, энэ нь зарим тохиолдолд хүндрэл үүсгэж байжээ. Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд ТВ хичээлийн агуулга, арга зүй тохиромжгүй, багшаас тусгайлан боловсруулсан даалгавар авах, ахицаа хянуулах зэрэг асуудлаар бусад хүүхдээс илүү их хүндрэлтэй тулгарч, улмаар оюуны бэрхшээлтэй хүүхдэд алсын зайн сургалт хүнд тусдаг гэж дүгнэж болохоор байна. Теле-хичээлийн өрнөл хэтэрхий хурдан, хичээлийг нөхөж үзэх боломжгүй байгаа нь хамгийн олон давтагдсан шүүмжлэл байв.

Дэд бүтцийн найдвартай байдал нь ялангуяа хөдөө орон нутгийн хувьд нийтлэг бэрхшээл болж илэрлээ. Орон нутагт тог тасрах, суурин интернэтийн үйлчилгээ байхгүй, хөдөлгөөнт интернэтийн хурд муу, ТВ хичээлийг нөхөж үзэх боломж олгосон интернэт протоколд суурилсан телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж муу (ХХЗХ-ны мэдээлснээр 11.4 хувь нь холбогдсон) зэрэг нөхцөл нь ТВ, интернэтээр боловсролын үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжийг хязгаарлаж байгааг судалгааны үр дүн тодорхой харуулж байна. Маш их хүч хөдөлмөр, хөрөнгө зарцуулж бүтээсэн ТВ хичээлүүдийг БСШУСЯ-ны www.econtent.edu.mn вэбсайтад байршуулсан ч энэ талаар эцэг, эхчүүд тэр бүр мэддэггүй, мэддэг нь байнга ашигладаггүй аж. Тус вэбсайтын гар утсанд зориулсан хувилбар нь хичээлийг татаж аваад интернэтгүй үед үзэх боломжтой зэрэг давуу талтай (давуу, сул талуудын тухай 3 дугаар бүлгээс үзнэ үү) тул энэ үйлчилгээний талаар мэдээлэл түгээж, сурталчлах шаардлагатай юм.

Цаашид, бэлтгэж боловсруулсан алсын зайн сургалтын хичээлүүдээ агуулгыг нь өөрчлөхгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хүртээмжтэй хувилбарт оруулан бичих, ингэхдээ хөгжлийн бэрхшээлээс үүдсэн онцлогийг харгалзсан сургалтын арга зүй, материал, тохируулгуудыг ашиглах шаардлагатай. Энэ нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдаар хязгаарлагдахгүй, хичээлээ нөхөж үзэх, давтах шаардлагатай бүх хүүхдэд сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, боловсролын эх сурвалж болох юм.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай холбоотой мэдээллийг боловсруулахдаа судалгааны баг нь ЕБС-д тэгш хамрагдан суралцаж буй хүүхдүүдэд тусгайлан төвлөрч судалсан бөгөөд тэдний эзлэх хувь нь ерөнхий боловсролын нийт

суралцагчийн 1 хувьд ч хүрэхгүй байгаа тул албан эх сурвалжийн мэдээ, баримт бага байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад хамаарах үр дүнг нийт сурагчдын дүнтэй харьцуулахгүйгээр зөвхөн энэхүү дэд бүлэгт дүгнэлээ.

1.3 Цар тахалтай тэмцэх арга хэмжээ ба 2019, 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалт

Манай улс 2006 оноос эхлэн ЕБС төгсөгчдөөс авдаг дээд боловсролд дэвшин суралцах шалгалтыг нэгдсэн журмаар зохион байгуулах тогтолцоог бэхжүүлэн, элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ) авч байна. Уг шалгалтыг БСШУСЯ-ны Боловсролын Үнэлгээний Төв (БҮТ) хариуцан зохион байгуулдаг. ЭЕШ нь жил бүр зохион байгуулагддаг тул сүүлийн 14 жилийн туршид ЕБС төгсөгчдийн авсан онооны талаарх мэдээллийн бааз бүрэлдсэн байна. Гагцхүү ЭЕШ-д стандартчилсан оноо бус, хэмжээст онооны системийг ашигладаг тул жил жилийн дундаж оноог хооронд нь харьцуулах боломжгүй.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын энэ үеэр БҮТ нь ЭЕШ-д орох сурагчдад бодитой дэмжлэг хүргэхэд анхаарч ажиллажээ. Уг байгууллага алсын зайн сургалтын хугацаанд 150 теле болон онлайн хичээл, төгсөх ангийн буюу 12 дугаар ангийн сурагчдад зориулсан ЭЕШ-д бэлтгэх гарын авлага, DVD гаргаж, тараан түгээжээ. Түүнчлэн хөл хорио тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдал зарлаад байгаа энэ үед ЭЕШ-д оролцох суралцагчдад танхимаар давтлага өгөх асуудлаар эцэг эх, сурагчдын дунд 2020 оны 4 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд онлайн санал асуулга зохион байгуулжээ. Судалгаанд 14,094 суралцагч, 10,711 эцэг эх оролцож, 81.2 хувь нь танхимаар давтлага авах саналыг дэмжсэн байна. Улмаар уг асуулгын дүнг ЗГ-ын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар танилцуулж, хэлэлцүүлснээр ЭЕШ-д бэлтгэх давтлага зохион байгуулах шийдвэр гарсан юм. 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс ЕБС-ийн 12 дугаар ангийн суралцагчид зөвхөн сургуулийн орчинд, халдвар, хамгааллын дэглэмийг чанд баримтлан нэг сарын хугацаанд давтлага сургалтад хамрагджээ. ЭЕШ-ыг хариуцан зохион байгуулдаг байгууллагын хувьд БҮТ нь үүсээд буй онцгой нөхцөл байдалд санаачилга гарган нөхцөл байдалд тохирсон, оновчтой ажил зохион байгуулж ажиллажээ гэж дүгнэж байна.

Цар тахлаас сэргийлэн алсын зайнаас суралцаж шалгагдсан хүүхдүүдийн сурлагын амжилтын талаар бодит дүгнэлт хийхийн тулд БҮТ-өөс 2019, 2020 онд зохион байгуулсан ЭЕШ-д сурагчдын авсан дундаж оноог харьцуулан авч үзлээ. Үүнд засаг захиргааны нэгжээр, дэд бүтцийн хүрэлцээ хангамжтай уялдуулан газар зүйн болон сургуулийн байршлаар, мөн сургуулийн өмчийн хэлбэрээр дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 7. 2019, 2020 оны ЭЭШ-ын дүнгийн харьцуулалт, газарзүйн байршлаар (төвийн болон баруун бүс)¹⁷

№	Шалгалтын нэр	2019				2020				2020			
		Төвийн бүс		Төвийн бүс		Төвийн бүс		Баруун бүс		Баруун бүс		Баруун бүс	
		Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
1.	Математик	1083	27.6	503.7	3010	28	507	1917	27.9	504.5	2298	27.2	498
2.	Монгол хэл	728	57.3	513.9	1823	57.5	527	1161	54.9	498.6	1290	53.5	500
3.	Нийгмийн ухаан	1000	4966	509.9	2641	58.8	519	1686	48.9	504.5	2000	54.5	493
4.	Англи хэл	915	34	490.4	2614	33.9	491	1255	31.9	478.6	1511	32	482
5.	Орос хэл	30	57	488	61	66.5	523	110	65	514.4	97	58.8	492
6.	Газар зүй	37	54.8	534	115	56.5	528	110	42.5	469	65	47.8	475
7.	Физик	496	31.6	504.7	1252	29.6	510	780	33	514.4	885	28.8	500
8.	Биологи	213	49.5	519.2	654	52.4	525	739	46.9	502.6	771	47.8	501
9.	Хими	212	26.8	505.8	635	26.2	511	716	25.5	491.3	763	25.1	501
10.	Монгол Улсын түүх	33	46.4	555.4	77	54.2	554	61	44.7	541.8	58	49.7	521

Тайлбар: Ш.Тоо - Шалгуулагчийн тоо, А.О.Д - Анхны онооны дундаж,
Х.О.Д - Хэмжээст онооны дундаж¹⁸

¹⁷ Боловсролын үнэлгээний төвийн албан ёсны вэбсайт, <http://stat.eec.mn/>

¹⁸ Шалгуулагчийн амжилтыг анхны оноо, хэмжээст оноо, проценталь оноо, амжилтын чанарын индекс гэсэн үзүүлэлтээр эрэмбэлэн дүгнэдэг. Анхны оноо нь шалгуулагчийн үнэлгээний гүйцэтгэлд өгсөн оноо бөгөөд ЭЭШ-д шалгуулагч хамгийн ихдээ 100 оноо авах ёстой. Анхны оноо гэж тухайн хичээлийн шалгалтын сэдэв даалгаврыг хэрхэн гүйцэтгэснийг илтгэх үнэлгээ бөгөөд авбал зохих онооноос хэдэн оноо авсныг хувьд шилжүүлсэн тоон үзүүлэлт юм. Тухайлбал, математик хичээлийн шалгалтын сэдэв нийт 50 оноотой ба шалгуулагч нийт 40 оноо цуглуулсан байг. Энэ нь анхны оноо болох бөгөөд хувьд шилжүүлэн тооцвол 80 хувийн гүйцэтгэлтэй шалгагджээ гэсэн үг юм. Анхны оноо нь хэмжээст оноог тооцон гаргах хамгийн чухал хамаарал юм. Хэмжээст оноо гэж (ЭЭШ-ын батламж хуудас хоёр жил хүчинтэй тохиолдолд) жил жилийн даалгаврын хүнд хөнгөний харьцааг тогтвортой байлгах зорилго бүхий олон улсын үнэлгээний аргачлал юм. ЭЭШ-ын үнэлгээ, оноо//eec.mn/?p=935

Төвийн бүсийн хувьд 2019 оны хэмжээст онооны дунджийг 2020 оны дундажтай харьцуулахад математик 3.3, монгол хэл 13.1, нийгмийн ухаан 9.1, англи хэл 0.6, орос хэл 35, физик 5.3, биологи 5.8, хими 5.2 оноогоор тус тус нэмэгджээ. Харин газар зүй 6, Монголын Улсын түүх 1.4 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. Баруун бүсийн хувьд 2019 ба 2020 оны хэмжээст онооны дунджийг хооронд нь харьцуулахад монгол хэл 1.4, англи хэл 3.4, газар зүй 6, хими 9.7 оноогоор тус тус нэмэгдсэн бол математик 6.5, нийгмийн ухаан 11.5, орос хэл 22.4, физик 14.1, биологи 1.6, Монгол Улсын түүх 20.8 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. Ерөнхий шалгалтад багтсан 10 хичээлийн 4-ийнх нь дундаж оноо нэмэгдэж, 6 хичээлийн дундаж оноо 1.6-22.4-өөр буурчээ. Төвийн бүсийн хувьд нийгмийн болон байгалийн ухааны хичээлийн хэмжээст онооны дундаж өмнөх оноос нэмэгдэж, 2 хичээлийн оноо буурсан бол баруун бүсийн шалгуулагчдын хувьд 6 хичээлийн дундаж оноо буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 8).

Зүүн бүсийн хувьд 2019 ба 2020 онуудын хэмжээст онооны дунджийг харьцуулахад математик 8, орос хэл 35, газар зүй 17.4, физик 15.7, биологи 11.7, хими 17.7, Монгол Улсын түүх 42.3 оноогоор тус тус нэмэгдэж, монгол хэл 3, нийгмийн ухаан 1.5, англи хэл 3.8 оноогоор тус тус буурчээ. Ерөнхий шалгалт өгөх 10 хичээлийн 7 хичээлийн дундаж оноо нэмэгдэж, 3 хичээлийн дундаж оноо 1.5-3.8 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

Хангайн бүсийн хувьд 2019 ба 2020 онуудын хэмжээст онооны дунджийг харьцуулахад математик 9.3, монгол хэл 7.9, нийгмийн ухаан 5.9, англи хэл 13.1, орос хэл 15.6, физик 12.4, биологи 0.1, хими 7.6, монгол улсын түүх 30.5 оноогоор тус тус нэмэгдэж, газар зүй 22.3 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатарын хувьд 2019 ба 2020 онуудын хэмжээст онооны дунджийг харьцуулахад зөвхөн орос хэлний үнэлгээ 9.5 оноогоор нэмэгдэж, бусад бүх шалгалтын дундаж оноо буурчээ. Тухайлбал, математик 9.8, монгол хэл 9.8, нийгмийн ухаан 3, англи хэл 8.3, газар зүй 30.7, физик 16, биологи 9.5, хими 19.9, Монгол Улсын түүх 1.8 оноогоор тус тус буурсан байна. Ингэснээр ерөнхий шалгалт өгөх 10 хичээлээс 1 хичээлийн дундаж оноо нэмэгдэж, 9 хичээлийн дундаж оноо 1.8-30.7 оноогоор буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 9).

Хүснэгт 8. 2019, 2020 оны ЭШ-ын дүнгийн харьцуулалт, газарзүйн байршлаар
(зүүн болон хангайн бүс, Улаанбаатар)

№	Шалгалтын нэр	2019		2020		2019		2020		2019		2020							
		Зүүн бүс		Зүүн бүс		Хангайн бүс		Хангайн бүс		Улаанбаатар		Улаанбаатар							
		Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д			
1.	Математик	617	27.4	502	1257	28.7	510	2052	27.3	498.7	3536	29	508	4752	30.7	518.8	8778	29.2	509
2.	Монгол хэл	351	60.5	537	699	58.4	533	1143	56.8	510.1	2042	56.2	518	2207	56.5	507.8	4403	53	498
3.	Нийгмийн ухаан	496	51.7	524.5	1088	59.3	523	1620	48.3	501.1	2894	56.8	507	4175	49.5	510	7701	57	507
4.	Англи хэл	440	34	491.8	1019	32.9	488	1541	31.5	475.9	2592	33.6	489	5159	42.8	526.3	9324	41.1	518
5.	Орос хэл	13	67.4	537	35	73.6	572	54	71.8	575.4	72	75.6	591	333	80	625.5	360	81.7	635
6.	Газар зүй	25	54.3	534.6	45	60.5	552	67	56.2	544.3	120	55.6	522	131	54.7	537.7	314	52.9	507
7.	Физик	305	30.7	497.3	483	30.3	513	995	30.7	498.6	1528	30.3	511	1835	34.3	519	3129	28.9	503
8.	Биологи	172	46.9	502.3	339	50.7	514	536	48.7	513.9	1063	50.2	514	861	50.2	521.5	1788	49.9	512
9.	Хими	175	25.8	494.3	345	26.7	512	545	27.1	504.4	1049	26.8	512	891	30.8	529.9	1776	26.7	510
10.	Монгол Улсын түүх	22	46.9	562.7	25	63.9	605	86	41	518.5	87	53.4	549	186	39.2	509.8	422	46.5	508

Хүснэгт 9. 2019, 2020 оны ЭБШ-ын дүнгийн харьцуулалт, сургуулийн байршлаар (нийслэл, аймаг, сум, баг)

№	Шалгалтын нэр	2019				2020			
		Улаанбаатар (223 сургууль)				Аймгийн төв (278 сургууль)			
		Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	Х.О.Д
1.	Математик	4750	30.7	518.8	8738	29.1	509	3382	508.2
2.	Монгол хэл	2206	56.5	507.7	4392	52.9	497.9	1794	519
3.	Нийгмийн ухаан	4171	49.5	509.9	7677	57	507.8	2752	515.1
4.	Англи хэл	5156	42.8	526.3	9286	41	518.5	2552	490.6
5.	Орос хэл	333	80	625.3	358	81.6	634.6	126	568
6.	Газар зүй	131	54.7	537.7	311	52.7	506.3	90	534.9
7.	Физик	1834	34.3	519	3110	28.9	503.2	1454	514.7
8.	Биологи	861	50.3	521.5	1785	49.8	512.9	870	529
9.	Хими	891	30.9	529.9	1773	26.7	510.8	884	512.7
10.	Монгол Улсын түүх	186	39.2	509.8	421	46.5	508.8	106	546.5
№	Шалгалтын нэр	Сумын төв (227 сургууль)				Багийн төв (11 сургууль)			
		Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	Х.О.Д
		Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	Х.О.Д
1.	Математик	2182	26	492.9	3991	26.1	493.6	107	491.5
2.	Монгол хэл	1514	55.1	499.5	2719	55.5	514	76	496.2
3.	Нийгмийн ухаан	1961	47.4	494.2	3622	55.1	496.5	93	517.4
4.	Англи хэл	1529	29.5	466.7	2783	29.3	470.4	73	482.8
5.	Орос хэл	79	52.9	463	113	53.4	467.7	2	561.5
6.	Газар зүй	133	47.4	495.6	161	51	496.8	16	445.5
7.	Физик	1066	29.1	490.7	1754	27.4	494.6	57	494.2
8.	Биологи	755	43.2	485.1	1266	45.2	490.7	35	496.8
9.	Хими	737	23.7	480.2	1237	23.4	490	27	494
10.	Монгол Улсын түүх	92	42.6	528.2	109	53.3	546.3	4	455.5
								1	39
									472

Улаанбаатар хотод байршилтай 223 сургуулийн 2019 оны хэмжээст онооны дунджийг 2020 оны дундажтай харьцуулахад орос хэл 9.1 оноогоор нэмэгдэж, математик 9.8, монгол хэл 9.8, нийгмийн ухаан 2.1, англи хэл 7.8, газар зүй 31.4, физик 15.8, биологи 8.6, хими 19.1, Монгол Улсын түүх 1 оноогоор тус тус буурчээ.

Аймгийн төвийн байршилтай 278 сургуулийн 2019 оны хэмжээст онооны дунджийг 2020 оны дундажтай харьцуулахад элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 10 хичээлийн дундаж оноо 3-26.4 оноогоор, сумын төвийн 227 сургуулийн хэмжээст онооны дундаж 0.7-18.1 оноогоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ.

Багийн төвийн 11 сургуулийн 2019 оны хэмжээст онооны дунджийг 2020 оны дундажтай харьцуулахад англи хэл 19.7, физик 0.3, биологи 14, хими 19.6, Монголын Улсын түүх 16.5 оноогоор тус тус нэмэгдэн, математик 0.4, монгол хэл 4, нийгмийн ухаан 10.3, орос хэл 79.1, газар зүй 39.1 оноогоор тус тус буурчээ.

Нийслэлийн болон аймгийн төвийн сургуулийн шалгуулагчдын хэмжээст онооны дунджийг сум, багийн сургуулийн шалгуулагчдын хэмжээст онооны дундажтай харьцуулах нь өрөөсгөл бөгөөд энэ нь дэд бүтэц болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалж байгаа болно.


2019, 2020 онуудын ЭЕШ-ийн хэмжээст онооны дунджийг мөн сургуулийн өмчийн хэлбэрээр харьцуулж үзлээ.

Хүснэгт 10. 2019, 2020 оны ЭЕШ-ын дүнгийн харьцуулалт, сургуулийн өмчийн хэлбэрээр (төрийн болон төрийн бус өмчийн)

№	Шалгалтын нэр	2019				2020			
		Төрийн өмчит сургууль (621)				Төрийн бус өмчит сургууль (118)			
		Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д
1.	Математик	9496	27.6	502.42	17391	27.9	503.68	925	583.66
2.	Монгол хэл	5389	56.4	507.81	9812	54.8	510.01	201	539.63
3.	Нийгмийн ухаан	8460	49	505.82	15414	56.8	506.89	517	546.11
4.	Англи хэл	8357	35.3	494.89	15546	35.5	496.72	953	607.18
5.	Орос хэл	388	68	553.63	503	71	565.21	152	676.12
6.	Газар зүй	353	51	516.06	602	53.8	512.33	17	556.24
7.	Физик	4030	31.1	502.04	6745	28.7	502.71	38	598.81
8.	Биологи	2352	47.7	508.01	4335	49.4	510.33	169	579.88
9.	Хими	2348	26.9	503.18	4280	25.8	506.24	191	581.52
10.	Монгол Улсын түүх	356	41.4	522.43	604	49	522.67	32	537.22
								65	50.8
									535.54

Төрийн өмчит 621 сургуулийн 2019 ба 2020 оны хэмжээст онооны дунжийг хооронд нь харьцуулахад ерөнхий шалгалт өгөх 10 хичээлийн 8-ынх нь хэмжээст онооны дундаж нэмэгдэж, 2 хичээлийнх 2.2-3.73 оноогоор буурсан байна. Мөн энэ үзүүлэлт төрийн бус өмчит 118 сургуулийн хувьд ерөнхий шалгалт өгөх 10 хичээлийн 1 хичээл буюу орос хэл 35.5 оноогоор нэмэгдэж, 9 хичээлийнх 0.15-42.7 оноогоор буурчээ. Төрийн өмчийн 621 сургуулийн 2020 оны хэмжээст онооны дунжийг төрийн бус өмчит 118 сургуулийн мөн үзүүлэлттэй харьцуулахад төрийн бус өмчит сургуулийн төгсөгчдийн хэмжээст онооны дундаж нь ЭЕШ-ын 10 хичээлээр төрийн өмчийн сургууль төгсөгчдийн ижил хичээлийн онооноос илүү байв. Тухайлбал, математик 50.4, монгол хэл 1.09, нийгмийн ухаан 39.07, англи хэл 94.6, орос хэл 145.4, газар зүй 15.4, физик 53.4, биологи 46.3, хими 58.5, Монгол Улсын түүх 12.8 оноогоор тус тус илүү байна.

График 4. 2020 оны ЭЕШ-ын улсын хэмжээний үзүүлэлт, сургуулийн өмчийн хэлбэрээр



Энэхүү харьцуулсан үнэлгээнээс харахад, төрийн бус өмчит сургуулийн сургалт зохион байгуулсан туршлага, сурах орчин нөхцөлөө бүрдүүлсэн байдлыг судалж, сайн туршлагыг төрийн өмчийн сургуульд нэвтрүүлэх, төрийн өмчийн сургуулийн сургалтын үр дүн, чанарыг хувийн сургуулийн түвшинд хүргэхэд анхаарал хандуулах цаг болсныг илтгэж байна.

Уг судалгаанд ашигласан харьцуулсан дүн шинжилгээнээс харахад теле хичээл, цахим сургалт, танхимын нэг сарын давтлагаар 12 дугаар ангийн сурагчдыг ЭЕШ-д бэлтгэсэн нь үүсээд буй нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ болжээ. Харин нийт шалгуулагчийн хэмжээст онооны дунджаар зайн сургалт, танхимын давтлагын чанар, хүртээмжийг таамаглан тооцоолох боломжгүй юм. Учир нь эдгээр арга хэмжээ нь шалгуулагчийн оноонд нөлөөлөх олон хүчин зүйлийн цөөн хэд нь бөгөөд бусад нь жишээлбэл, мэргэжил сонголтоо хийсэн даруйдаа ахлах ангийн сурагчид хувийн давтлага, сонгон суралцах хичээлд хамрагдах, бие даан судлах зэргээр мэдлэгээ зузааруулахад нэмэлт хүчин чармайлт гаргадаг. Иймд теле хичээл, цахим сургалт нь ЭЕШ-ын оноонд бодитой нөлөө үзүүлсэн эсэхийг дүгнэх боломжгүй. Хэдий тийм боловч БҮТ-өөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь сургалтын тасралтгүй байх зарчмыг ханган, ЕБС төгсөгч, тэдний эцэг эхэд сэтгэл санааны дэмжлэг, шалгалтдаа бэлтгэх бодит чиг баримжаа болж чадсан гэж дүгнэж байна.

БҮТ нь хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд бүх шатны боловсролын сургалтын чанарт бие даасан үнэлгээ, судалгаа хийдэг байгууллага юм. Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.¹⁹ Теле болон цахим хэлбэрийн зайн сургалтын чанар, хүртээмжийн талаарх бодитой үнэлгээ нь 2020 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн чанарын үнэлгээний судалгаанаас гарах боломжтой.

1.4 Их, дээд сургууль, коллежийн цахим сургалт

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын улмаас их, дээд сургууль, коллежийн хоёрдугаар улирлын сургалт цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. Манай улс 2002 оноос дээд боловсролд танхим болон цахим сургалтыг хослуулах аргыг туршин ашиглаж байгаа юм. Эрх зүйн орчны хувьд харин Дээд боловсролын тухай хуульд цахим сургалтын талаар дурдаагүй, зөвшөөрсөн, эсхүл хориглосон зүйл, хэсэг, заалт одоогоор байхгүй. БСШУСЯ-нд Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа энэ цаг үед уг асуудалд хуулийн Ажлын хэсгийн анхаарлыг хандуулахад энэхүү судалгааны тайлан ач холбогдлоо өгнө гэж найдаж байна.

¹⁹ Боловсролын үнэлгээний төвийн албан ёсны вэбсайт, <http://eec.mn/>

Манай улсын хэмжээнд 95 их, дээд сургуульд 7,330 багш ажиллаж, 148,446 суралцагч (бакалавр, магистр, докторын хөтөлбөрт) суралцаж²⁰ байна.

Монголын Их Дээд Сургуулиудын Консорциум (МИДСК)-аас 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс мөн оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан, улирлын болон төгсөлтийн шалгалтыг цахим хэлбэрээр авч, тайлан мэдээг 2020 оны 6 дугаар сарын 15-ны дотор гарган, БСШУСЯ-нд хүргүүлэхийг их, дээд сургууль, коллежийн удирдлагад үүрэг болгосон. Тайлангуудыг нэгтгэн БСШУСЯ-нд хүргүүлэх ажлыг МИДСК хариуцан зохион байгуулжээ.

Их, дээд сургууль, коллежийн дийлэнх нь цахим сургалтад *Moodle*²¹, *Google (Google Meet, Google Classroom*²²), *Zoom*²³ программыг ашигласан бөгөөд эдгээр нь хэрэглээний төлбөр шаарддаггүй үнэгүй программууд юм. Үнэгүй эдгээр программ нь хэрэглэгчийн аюулгүй байдлыг хариуцдаггүй нийтлэг нөхцөлтэй бөгөөд энэ нь суралцагчийн мэдээлэл алдагдах, цахим хэлбэрээр байршуулсан лекц, семинарын материал устгах, *Zoom, Google meeting* аппликейшн ашиглан зохион байгуулсан хурал, хэлэлцүүлгийн явцад алдаа гарах зэрэг эрсдэл дагуулдаг.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний боловсролд үзүүлсэн өөр нэг нөлөө бол их, дээд сургууль, коллежийн 2020-2021 оны хичээлийн жилийн элсэлтийг анх удаа бүхэлд нь цахим хэлбэрээр зохион байгуулсан явдал бөгөөд энэ нь иргэдийн сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхийг хязгаарлахгүй байхад чиглэсэн чухал арга хэмжээ боллоо. Цахим элсэлтийг БСШУСЯ-ны Дээд боловсролын газар,

²⁰ БСШУСЯ-ны албан ёсны вэбсайт, дэлгэрэнгүйг <https://www.meds.gov.mn/> холбоосоор үзнэ үү.

²¹ Олон улсын хэмжээн дэх хамгийн том сургалтын менежментийн системийн нэг бол *Moodle* юм. *Moodle* нь нээлттэй open source систем юм. *Moodle* нь *Google Classroom, Microsoft Teams for education*-ийг бодвол маш цогц олон боломжтой, автоматаар даалгавар, шалгалтын дүнг бодох зэрэг хялбарчилсан үйлдлүүдтэй, сургуулийн түвшинд ашиглахад зориулагдсан, сургалтын төлбөр, дүнгийн систем гээд маш олон функцийг илүү гүнзгий хэмжээнд ашиглах боломжтой.

²² *Google Meet* нь *GSuite* системтэй холбож өгсөн маш өргөн хэрэглэгддэг видео уулзалтын хэрэгсэл юм. *Google Meet*-ийг ашиглахын тулд заавал *GSuite* юмуу *GSuite for Education* хэрэглэгч байх ёстой. *GSuite for Education* нь магадлан итгэмжлэгдсэн сургуулиудад үнэгүй байдаг боловч сургууль нь заавал тусдаа хүсэлт гаргасан байх ёстой. *Google Classroom* нь цахим сургалтын менежментийн үнэгүй систем бөгөөд багш нар цаасгүйгээр хичээлээ удирдах боломжтой. Хэн ч дуртай хичээлээ нээгээд оюутан, сурагчаа нэмж болдог.

²³ *Zoom* нь хамгийн алдартай видео уулзалтын хэрэгсэл юм. Хэрэглэхэд маш хялбар бөгөөд ухаалаг утас, зөөврийн, ширээний компьютераасаа ашиглах боломжтой. Үнэгүй багц нь 40 минут хүртэлх видео уулзалт хийх боломжтой.

МИДСК-тай хамтран 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс мөн оны 7 дугаар сарын 10-ны хооронд²⁴ зохион байгуулжээ.

2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн цахим хичээлийн сэтгэл ханамжийн болон агуулгын чанарын судалгааг БСШУСЯ-ны Дээд боловсролын газар их, дээд сургуулиудаас түүврийн аргаар авчээ. Судалгаанд оролцогчдын 82.5 хувь нь цахим хичээлд сэтгэл хангалуун байгаа бөгөөд мөн 82 хувь нь цахим хичээлийн агуулга чанар сайн гэж үнэлжээ.²⁵ Цахим сургалт нь сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх давуу талтай боловч танхимд хичээл заадаг шиг оюутан, сурагчидтайгаа шууд харилцах, асуулт хариулт явуулах, ойлгосон ойлгоогүйг нь харах боломж олгодоггүй сул талтайгаас гадна сургалтын чанарын үнэлгээ нь харьцангуй шинжтэй.

Ихэнх их, дээд сургууль, коллежийн зүгээс багш нарт шаардлагатай дэмжлэгийг хангаж өгөхөд анхаарсан байна. Сургуулиас цахим лекцийн боловсруулалт хийх, семинар, шалгалтын дасгал, даалгаврыг боловсруулахтай холбоотой сургалтыг багш нартаа тухай бүрд нь хийж, харилцан туршлага судлах боломжийг бүрдүүлж ажиллажээ. Нөгөө талдаа, цахим сургалтын үеэр багш нарын ачаалал 1.5-2 дахин нэмэгдсэн гэж үзэж байгаа бөгөөд цахим сургалтад оролцогчдын технологийн мэдлэг, чадвар харилцан адилгүй түвшинд байгаа явдал нь багшийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх, сургалтын үр дүнд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, хүртээмжтэй, хяналттай зохион байгуулахад сургууль бүр тухайлсан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллажээ. Энэ талаар нийслэл болон орон нутагт байршилтай тус бүр нэг их, дээд сургуулийн цахим сургалтын хэрэгжилтийн кейсийг танилцуулъя.

1. Дотоод хэргийн их сургууль²⁶ нь зайн сургалтыг зохион байгуулахтай холбоотой “Цахим сургалт зохион байгуулах түр журам” батлан, мөрдөж байна. Цахим сургалтад *Menti.com, MPEG-4, After effect, Photoshop, Flash, Premier, CorelDraw, Icecream, Microsoft office, Edius, Articulate, Ebook 3ds max* зэрэг программ, аппликейшныг ашиглаж байгаа бөгөөд бүрэлдэхүүн сургуулийн багш нарын туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Тэрчлэн, жишиг цахим хичээлийг их сургуулийн хэмжээнд танилцуулж, жишиг цахим хичээл боловсруулсан багш нар нь бүрэлдэхүүн

²⁴ Монголын их, дээд сургуулиудын консорциумын гишүүн их, дээд сургууль, коллежид аймаг, орон нутгаас 2020-2021 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам. (2020.06.15)

²⁵ “Боловсролын салбар дахь цахим шилжилт” хэлэлцүүлэг. <https://ikon.mn/n/1yh3>

²⁶ Эх сурвалж: ДХИС-ийн Сургалтын бодлого төлөвлөлтийн газар. 2020.08.28// Улаанбаатар хот.

сургуулийн багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулжээ. Тус их сургууль нь өөрийн бүрэлдэхүүн сургуулиудын зарим багшийн цахим хичээлийг жишиг хичээл болгон нийт багш нарт танилцуулсан бөгөөд энэ нь суралцагчдын мэргэшлийн онцлогтой холбогдох хичээлийн төрөл болохыг онцолж байна. Их сургууль нь 118 цахим хичээлийг улирлаар байршуулан, хандсан суралцагчийн тоо, багшийн ашигтай ажилласан цаг, тэмдэглэлээр эргэх холбоог хянаж хэвшсэн байна. Цахим хичээл заасан багшийн цагийн ачааллыг их сургуулийн сургалтын үйл ажиллагааны журмын дагуу “А” багц цагаар тооцож байгаа.

Цаашид цахим гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамж, нэр төрөлд анхаарах шаардлагатай байгаа бөгөөд их сургуулийн төв номын сангаас нэн яаралтай цахимжуулах шаардлагатай номын судалгааг гаргаж, цахимжуулах бэлтгэл ажил эхэлсэн ч *E-book* бэлтгэхэд зохиогчийн эрхийн асуудал хөндөгдсөн тул уг ажлынх нь явц удаашралтай байгаа аж. Энэ судалгааны хүрээнд тус их сургуулиас бусад их, дээд сургуульд санал болгохуйц цахим сургалтын сайн туршлага, хамтран болон нээлттэй хэрэгжүүлэх боломжийг лавлахад 2019-2020 оны 2 дугаар улиралд мультимедиа хэлбэрээр бэлтгэн хүргэсэн хичээл нь илүү ойлгомжтой, сонирхолтой болж сонсогч, суралцагчдаас өндөр үнэлгээ авчээ.

2. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Хүмүүнлэгийн дээд сургууль²⁷ нь *Blended learning* буюу Холимог сургалт явуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө, цахим хичээлийн контент бэлтгэхэд тавигдах ерөнхий стандарт, судалгааны ажил зайнаас хамгаалуулах журам тус тус батлан, мөрдөж байгаа. Зайн сургалтын явцад багшийн блог, и-мэйл, чатаар дамжуулан харилцдаг байсныг *Google Classroom* программ ашиглаж явуулах бэлтгэл хангаж, багш, суралцагчдыг gmail хаягтай болгон, *Google Classroom*-д тус сургуулийн сургалт явуулдаг бүх чиглэлээр цахим анги нээн, багш, суралцагчийн бүртгэлийг үүсгэн, Хөтөлбөрийн бодлого, төлөвлөлтийн алба, Чанарын дотоод баталгаажуулалтын албаны дарга нар хөндлөнгийн хяналт тавьж байх зохион байгуулалтыг хийжээ. Мөн багш нарт цахим сургалтыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор *Google Classroom* дээр хэрхэн ажиллах талаар дэлгэрэнгүй видео хичээл бэлтгэж, багш, суралцагчдад онлайн сургалт, багш нарт олон хувилбарт онлайн-хичээл боловсруулах арга зүйн сургалт, *Camtasia recorder* ашиглах, *amtasia Studio 8*-ыг хөрвүүлэх, ашиглах талаар видео хичээл, *Microsoft PPT*

²⁷ Эх сурвалж: Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Хүмүүнлэгийн дээд сургуулийн Хөтөлбөрийн чанарын алба. 2020.08.28// Дархан-Уул аймаг.

ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад тавигдах шаардлага, заах арга зүйн холбоотой видео-хичээл, зөвлөмж, аудио, видео хичээл боловсруулахад тавигдах шаардлага, дидактик зөвлөмж, *ZOOM, Skype* программ ашиглан хичээл зохион байгуулах асуудлаар онлайн сургалт явуулсан байна. Уг судалгааны хүрээнд авсан санал асуулгад хариулахдаа тус сургууль *Google Classroom, Camtasia8, ZOOM, Microsoft Teams, Skype* программ, аппликейшныг ашиглан сургалтаа 100 хувь цахимаар зохион байгуулж байгаагаа онцолжээ.

Тус дээд сургууль нь суралцагчдын идэвх, оролцоог үнэлэх, цахим хичээлийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019-2020 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлын төгсгөлд 202 оюутнаас цахим сургалтын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийжээ. Уг судалгаанд оролцогчдын 42 хувь нь 80-аас дээш, 46 хувь нь 90-ээс дээш үнэлгээ тус тус өгсөн буюу судалгаанд оролцсон оюутан, суралцагчдын 88 хувь нь цахим хичээлийн чанар, хүртээмжийг хангалттай сайн гэж үнэлжээ. Цахим сургалтад хичээл заасан багшийн ачаалал нэмэгдэх хандлага илэрч байгаа бөгөөд тухайн сургуульд нэг багш 15 багц цаг заахаар журамласан хэдий ч энэ хичээлийн жилийн 2 дугаар улиралд 20-28 багц цагийн ачаалалтай байсан гэж дүгнэжээ. Багшийн ачаалал нь мэргэжлийн чиглэлээс хамаарч харилцан адилгүй байгаа боловч цахим сургалтын үеэр дунджаар 1.5-2 дахин нэмэгдсэн байна.

Дээрх оролцогчдын судалгаанаас дүгнэхэд их, дээд сургуулийн хувьд олон платформ ашиглах боломж нь нээлттэй, харин сургалтын үндсэн программ хооронд интеграци хийх, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Их, дээд сургуулиуд нийтлэг цахим сургалтын платформ ашиглаж байгаа нь цахим сургалтыг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх туршлага солилцох, цаашлаад бүс нутгийн болон олон улсад нээлттэй боловсролын тогтолцоог бүрдүүлэхэд ээлтэй шийдэл болох сайн талтай гэж дүгнэж болохоор байна. Цахим сургалт нь насанд хүрэгчдийн бие даан сурах арга барилыг дэмжсэн давуу тал бий болгож байна гэж үзэх үндэслэлтэй. 2019-2020 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлын үйл ажиллагаа нь багш нарын ажлын ачааллыг өсгөж, багшлах бүрэлдэхүүнд болон суралцагчдад шинэ технологи ашиглаж сурах, сургах арга барилаа зохицуулан өөрчлөх хэрэгцээг тулгаж, сургалтын байгууллагуудад багш, суралцагчдын идэвх оролцоог хянах шинэ механизмуудыг хэвшүүлэх шаардлага бий болгосон. Энэ нь их, дээд сургууль, коллежийн сургалтад шинэ хувилбарт сургалтыг нэвтрүүлэх боломж олгон, цаашид сургалтын холимог (танхим болон зайн) хэлбэрийг хөгжүүлэх, чанаржуулахад түлхэц өгсөн гэж найдаж байна. Мэргэжлийн болон хөндлөнгийн байгууллагын

судалгаа, сургалтын байгууллагын тайлан мэдээнд үндэслэн танхимын болон зайн сургалтыг хослуулан сургалтын тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангах боломжийг боловсролын салбарын бүх шатны байгууллага анхааран судалж, энэхүү онцгой нөхцөл байдлын үед батлан гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох боломжит хувилбарыг эрэлхийлэн ажиллаж буй.

Бүлгийн дүгнэлт

Цэцэрлэг, ЕБС-ийн түвшний теле-хичээлийн агуулгад тухайн теле-хичээлийг зохион байгуулагч талууд онцгой анхаарч, анги тус бүрийн судлах хичээлийг агуулгын хоцрогдол, алгасалтгүй зохион байгуулахыг зорьсон нь хичээлийн тоон мэдээнээс харагдаж байна. ЕБС-иуд үүссэн онцгой нөхцөл байдалд ямар нэг урьдач бэлтгэлгүй, туршлагагүйгээр ийнхүү зохион байгуулалтын ажлыг хийсэн бөгөөд суралцахуйн тасралтгүй байдлыг хангахад голлон анхаарч, өргөн уудам нутагтай, хагас нүүдэлчин соёл иргэншил бүхий тархуу суурьшилтай өөрийн орны онцлогийг харгалзан хамгийн хүртээмжит хувилбар болох өргөн нэвтрүүлгийн телевизээр теле-хичээлийг хүргэж ажиллажээ. ТВ хичээл нь хүртээмж сайтай ч эргэх холбоо байхгүй сул талтай байгааг анхааралдаа авч багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг дэмжсэн эргэх холбоог сайжруулах зорилгоор Боловсролын хүрээлэнгээс багш нарт зориулсан зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Теле-хичээлд бүх хүүхдийг хамруулах зорилт дэвшүүлсэн ч хамрагдалт нь улсын хэмжээнд 74.7 хувьтай байгаа бол аймгуудын дундаж 75, Улаанбаатарт 88.4 хувь тус тус байжээ. Энэхүү судалгааны хүрээнд Улаанбаатар хотын айл өрхүүдийн теле-хичээл үзэх боломж 84.8 хувь, хөдөө орон нутагт теле-хичээл үзэх боломж дунджаар 61.2 хувь, улсын хэмжээнд дунджаар 73.0 хувь гэж тооцоолсон бол БСШУСЯ-ны ажлын хэсгийн бүрэлдэхүүн үүнээс харьцангуй өндөр хувиар дүгнэсэн нь харагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн зайн сургалтад сөрөг нөхцөл байдал нийтлэгээр илэрчээ. Коронавируст халдварын цар тахлын үед Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн зарим зохицуулалт зөрчигдөн, улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс зарим талаар татгалзах, сурч боловсрох сургалтын орчныг бүрдүүлэхгүй байх нөхцөл үүссэн байна. Тухайлбал, энэхүү судалгааны хүрээнд авсан ганцаарчилсан ярилцлагын үр дүнд байнгын халамж шаардлагатай хүүхдийг харж асрах хүн хүрэлцэхгүй болсон, хичээлээс хоцрогдсон төлөв маш нийтлэг, огт хичээл хийгээгүй хүүхэд ч цөөнгүй, багштайгаа харилцах боломжгүй шахуу байгаагаас багш нь тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, суралцах чадварт тохирсон хичээл, даалгавар өгөх боломжгүй болсон,

теле-хичээлийг гүйцэхгүй ч нөхөж үзэх боломжгүй зэрэг нь тулгамдсан нийтлэг асуудал болсон. БСШУСЯ-ны www.econtent.edu.mn вэбсайтад байршуулсан хичээлийг эцэг, эхчүүд тэр бүр мэддэггүй, мэддэг нь байнга ашигладаггүй, багштай цөөн удаа уулзах, давтлага авах, даалгавар шалгуулах нь хоцрогдлыг арилгах хэмжээний үр дүнд хүргэж чадахгүй байгаа зэрэг ихэвчлэн сөрөг дүгнэлтүүдэд хүрсэн юм.

Жил бүр зохион байгуулдаг ЭЕШ-ын бэлтгэл ажил сайн явагдаж, хамрагдалт өндөр байжээ. Харин ЭЕШ-ын гүйцэтгэлийг дүгнэхдээ хэмжээст онооны аргачлалыг ашиглаж байгаа нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулах, улмаар он дамжсан дундаж онооны хэлбэлзлээр теле-хичээлийн чанар, хүртээмжийг үнэлэх боломжгүй байдлыг үүсгэсэн юм. Нөгөө талаас, теле-хичээл нь шалгуулагчийн хувьд чиглүүлэх үүрэгтэй, ЭЕШ-ын оноо нь шалгуулагчийн хувийн хариуцлага, бэлтгэл хангасан байдлаас голлон хамаарна гэж дүгнэж байна.

Их, дээд сургууль, коллежийн цахим хичээлийн хувьд ерөнхий боловсролын сургуулийн зайн сургалттай харьцуулахад өмнө нь нэвтрүүлэхээр судлан, туршиж байсан, зарим сургууль жишиг болгон зохион байгуулсан, суралцагчдын суралцах арга барил, багшлах бүрэлдэхүүний туршлага зэргийн нөлөөгөөр харьцангуй эерэг үзүүлэлттэй гарсан болно. Цар тахлаас сэргийлэх онцгой нөхцөлд цахим сургалтыг хэрэгжүүлэхэд сургуулиуд түр журам гарган зохицуулалт хийж, багш нарыг цахим агуулга бэлтгэх, цахим хичээл удирдан явуулах сургалтуудад хамруулан, хяналтын тогтолцоо бий болгон ажиллажээ. Дээд боловсролын байгууллагад суралцагч нь их хэмжээний материалыг бие даан судлах ёстой байдаг ч цахим сурах бичиг, ном, гарын авлагатай холбоотой зохиогчийн эрхийн асуудал үүсэж, ажил удааширсан талтайг тэмдэглэж байна. Дээд боловсролын үйлчилгээг цахимаар хүргэхтэй холбоотой энэ болон бусад асуудлыг эрх зүйн хувьд зохицуулаагүй байгааг анхаарч, Дээд боловсролын тухай хуульд тусгаж шийдэх хэрэгцээ тулгамдаад байгааг хөл хорио, зайн сургалтын энэ цаг үе тодорхой харууллаа.

Өнөөгийн алсын зайн сургалт нь үүссэн нөхцөл байдлыг боловсролын салбарт хэрхэн даван туулсан туршлага болохын зэрэгцээ зайн сургалтыг боловсролын бүх түвшинд хэрэгжүүлэх, илүү нээлттэй, тэгш хамруулсан, уян хатан боловсролын тогтолцоог бий болгох урт хугацааны зорилтын үндэс суурь болох учиртай. Шинэ зүйл бүхэн туршлага хийгээд дараагийн түвшний суурь, сайжруулалтын нөхцөл бололцоог бүрдүүлдэг учир боловсролын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оролцогчдод чиглэсэн эргэх холбоог сайжруулахад энэхүү бүлэгт дурдсан баримт, дүн шинжилгээ чухал үүрэг гүйцэтгэнэ гэж итгэж байна.

ХОЁР. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮР НӨЛӨӨ

Бүлгийн танилцуулга

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр УИХ, УОК, ЗГ, БСШУСЯ болон тус яамны харьяа байгууллагуудаас хууль, тогтоол, шийдвэр, тушаал, заавар зэрэг эрх зүйн баримт бичиг батлан, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажилласан тухай энэхүү бүлэгт танилцуулна. Уг асуудлыг (i) “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдахаас өмнө төрөөс боловсролын салбарт батлан хэрэгжүүлж байсан бодлого, түүний хэрэгжилт, (ii) уг хууль батлагдан гарснаар боловсролын салбарт гарсан өөрчлөлт гэсэн хоёр хэсэгт зааглан судаллаа.

2.1. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдахаас өмнө төрөөс боловсролын салбарт батлан хэрэгжүүлсэн эрх зүйн баримт бичиг

Дэлхий нийтээрээ шинэ төрлийн коронавирус (Ковид-19)-ын халдварын хурдтай тархалттай тэмцэж байгаа энэ онцгой нөхцөл байдлын үед улс бүр өөрийн онцлогт тохирсон дэглэм тогтоож, салбар бүрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй, тасралтгүй хүргэхэд анхаарч буй. Боловсролын салбарт нийт хүн амын 1/3 орчим хувь нь хамрагдан суралцаж байгаа Монгол Улсын хувьд боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй, тасралтгүй зохион байгуулахад чиглэсэн эрх зүйн актууд гарган хэрэгжүүлж байна.

1. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр зогсоож, олон нийтийн арга хэмжээг хориглон, сургалтыг зайн болон цахим хэлбэрт шилжүүлэх шуурхай арга хэмжээ авч, хүүхдийг хараа хяналтгүй үлдээх, аюулгүй байдал болон хүнсний баталгаа нь алдагдаж болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээний удирдамж гаргажээ.

Шинэ төрлийн коронавирус (Ковид-19)-ын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

УОК 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр анхны хуралдаанаа хийж “ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр хаах” шийдвэр гаргажээ.²⁸ ЗГ-аас 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр 30 дугаар тогтоол²⁹ гарган “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хөтөлбөрийн агуулгаар сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах арга хэмжээ авах, бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан олон нийтийг хамарсан нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахгүй байх” тухай заажээ. БСШУС-ын Сайд 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” А/43 дугаар тушаал³⁰ гарган, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, хүүхэд харах төв, ЕБС, их, дээд сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр зогсоосон. Энэ хугацаанд сурагч, оюутан, багш, эцэг, эхчүүдэд чиглэсэн зөвлөмж, чиглэлийг боловсруулан хүргэх, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгаар теле-хичээл зохион байгуулах, их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг хариуцсан газар, нэгжид даалгажээ.

Уг тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын даргын 4/500 тоот албан бичгээр³¹ аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга нарт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай зөвлөмж хүргүүлэн, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор (i) сургалтын үйл ажиллагааг түр зогсоосны улмаас танхимын сургалт 20 өдрөөр тасарсныг нөхөх зорилгоор сурагчдын зуны амралтыг сунгах; (ii) сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор өргөн нэвтрүүлгийн телевизээр теле-хичээл бэлтгэн хүргэх³²; (iii) ЭЕШ-ын талаар БҮТ-өөс сурагч, эцэг, эхчүүдэд

²⁸ УОК-ын 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын №01 тэмдэглэл. <https://nema.gov.mn/n/96161>

²⁹ Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол

³⁰ БСШУС-ын Сайдын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” А/43 дугаар тушаал.

³¹ БСШУСЯ-ны 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн “Тушаал хэрэгжүүлэх тухай” 4/500 тоот албан бичиг

³² Бага насны хүүхдэд зориулсан агуулга бүхий телевизийн нэвтрүүлэг, I-V анги тус бүрт өдөр бүр 10-20 минутын 2 хичээл, VI-IX анги тус бүрт өдөр бүр 10-20 минутын 2-3 хичээл, XI-XII анги тус бүрт өдөр бүр 10-20 минутын 3-4 хичээл

мэдээлэл өгөх талаар үе шаттай зохицуулалт хийж ажиллажээ. Дээд боловсролын байгууллагын удирдлагуудад тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2/579 тоот албан бичгээр³³ сургалтын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд хичээлийг цахимаар явуулах арга хэмжээ авч, суралцагч, багш нарыг бүрэн хамруулж ажиллахыг зөвлөжээ. БСШУСЯ-аас аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга нарт ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, багш, ажилтнаа ажлын байранд ирүүлэхгүйгээр зайнаас ажлаа гүйцэтгэх боломжийг бүрдүүлэн ажиллах талаар үүрэг, чиглэл өгч³⁴, хяналт тавьж ажиллахыг сануулжээ.

Шигтгээ 2. Зайнаас ажиллуулах горимын зөрчлийг хянаж ажилласан жишээ

Дархан-Уул аймгийн 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч багш, ажилтнаа ажиллуулсан, БЗД-ийн 210 дугаар цэцэрлэгийн эрхлэгч багш нараа 10.00-16.00 цаг хүртэл ажиллуулсан.

БСШУСЯ-ны 2020 оны 2/748 тоот албан бичигт

Өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр тус яамнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг³⁵ БСШУС-ын Сайд батлан гаргажээ. Тус төлөвлөгөөнд яамны харьяа байгууллагууд шуурхай удирдлагын баг томилох, тусгай утас ажиллуулах, салбарын байгууллагад өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах чиглэл, үүрэг даалгавар байнга өгөх тухай заасан нь эрсдэлийг бууруулахад чиглэж байв. Цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд суурилсан теле-хичээл бэлтгэх, телевизээр нэвтрүүлэх, их, дээд сургууль, коллежийн хичээлийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хариуцсан албан тушаалтан, хамтран хэрэгжүүлэх байгууллагад даалгасан байна. Дээрх зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хяналт тавих, ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор БСШУС-ын Сайдын албан тоотоор³⁶ теле-хичээлийн хуваарийг иргэд, олон нийтэд, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж сургалтын тасралтгүй байдлыг хангах; хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон хугацаанд багш, ажилтныг ажлын байранд цуглуулахгүй байх; багш нарыг өөрийн

³³ БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2/579 тоот албан бичиг.

³⁴ БСШУСЯ-ны 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн “Ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах тухай” 2/748 тоот албан бичиг.

³⁵ БСШУС-ын Сайдын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд БСШУСЯ-аас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”

³⁶ БСШУС-ын Сайдын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн “Хамтран ажиллах тухай” 1а/867 тоот албан бичиг

нөөц бололцоонд тулгуурлан суралцагч, эцэг эх, асран хамгаалагчтай эргэх холбоотой ажиллах, цаг үеийн бусад ажилд дайчлахгүй байх зэрэгт анхаарч ажиллахыг асуудал хариуцсан албан тушаалтнуудад зөвлөжээ.

Шигтгээ 3. Зөвлөмжийн хэрэгжилт янз бүр байгааг харуулсан зарим жишээ

Теле-хичээлээ үзсэн. Багшдаа даалгавраа шалгуулж чадаагүй аав, ээж хөдөө мал дээр байдаг учир туслахаар очоод амжаагүй.

*Завхан аймаг, Тосонцэнгэл сумын 12 жилийн сургалттай
сургуулийн III ангийн сурагч*

Теле-хичээлээ үзсэн, багш хуваарь гарган сургууль дээр дуудаж даалгавар шалгасан.

*Завхан аймаг, Завханмандал сумын 9 жилийн сургалттай
сургуулийн VI ангийн сурагч*

Теле-хичээлээ үзсэн. Багш нар гэрээр машинтай явж даалгавар шалгасан. Би www.econtent.edu.mn³⁷ цахим сайтад орж үзээгүй. XII ангийн сурагчид Ерөнхий шалгалтын давтлага хичээлд суусан байх.

*Завхан аймаг, Сонгино сумын 12 жилийн сургалттай
сургуулийн XI ангийн сурагч*

Хөдөө орон нутгийн сургуулийн хувьд теле-хичээлийг хүлээн авч буй сурагчидтай харилцах тодорхой ажил зохион байгуулж эргэх холбоог сайжруулахад анхаарч ажилласан нь дээрх агуулгаар нотлогдож байна.

ХНХ-ын, БСШУС-ын, Эрүүл мэнд (ЭМ)-ийн Сайд нарын 2020 оны 2 дугаар сард хамтран баталсан “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж”³⁸-д:

- цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр хугацаагаар хаасан үеэр бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээх, хүүхдийн амь нас, эрүүл мэнд хохирох, бэртэж гэмтэх, амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүд шаардлагатай хоол тэжээл, түлээ нүүрс, асаргаа сувилгаагаар хангагдаж чадахгүй байх зэрэг нөхцөл байдал үүсэж болзошгүй байдлаас

³⁷ Сурагчдад зориулсан “Теле-хичээл”-ийг илүү хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор БСШУСЯ, ХХМТГ-аас салбарын үүрэн холбооны оператор компаниудад чиглэл өгсний дагуу СӨБ, ЕБС-ийн сурагчдад зориулан www.econtent.edu.mn цахим сайтад байршуулсан теле-хичээлийг гар утаснаас үнэ төлбөргүй үзэх боломжтой болсон.

³⁸ ХНХ-ын, БСШУС-ын, Эрүүл мэнд (ЭМ)-ийн Сайд нарын хамтран баталсан “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж” 2020 оны 2 дугаар сарын 10

урьдчилан сэргийлж эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн зураглал гаргаж, хэрэгцээг тодорхойлох (амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон хүчирхийллийн эрсдэлтэй гэр бүлийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон хараа хяналтгүй хүүхэд, хөдөлмөр эрхэлдэг болон асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхэд) түргэвчилсэн үнэлгээ хийх;

- цэцэрлэг, ЕБС-ийн сурагчдаас эцэг эхийн хараа хяналтгүй үлдэх, ахуйн осол, гал түймрийн эрсдэлд орж болзошгүй хүүхдийн судалгааг нарийвчлан гаргах;
- теле-хичээлийн эргэх холбоог сайжруулах зорилгоор анги удирдсан багш нар хяналт тавих, зөвлөгөө өгөх, тэмдэглэл хөтлөх;
- анхаарвал зохих нөхцөл байдалд буй хүүхдүүдийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэл өгчээ.

Энэхүү Удирдамжаар өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон эхний цаг (2020.01.27-2020.03.02) хугацаанд хийгдэх болон цаашид тогтмолжуулан хийх ажлын чиглэлийг тодорхойлсон байна.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлийг 2020 оны 3 дугаар сарын 30 хүртэл сунгаж, теле болон цахим хичээлийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ 4 ба 5 дугаар сарын хичээлийн бэлтгэл хангаж ажиллах, ЕБС-ийн анги дэвших болон улсын шалгалтыг цуцлан, багшийн мэргэжил дээшлүүлэх хуваарьт сургалтуудыг цахимаар зохион байгуулах шийдвэр гарчээ.

ЗГ-ын 2020 оны 64 дүгээр тогтоолоор³⁹ гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн хугацааг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгаж, БСШУС-ын Сайдад (i) цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд хүүхдийн хоол, үдийн цайны зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг бямба гарагт хичээллэх багш, ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагад ариутгал, халдваргүйжүүлэлтийн материал худалдан авахад зарцуулах; (ii) ЕБС-ийн сурагчдад зориулсан теле-хичээлийг үргэлжлүүлэх, багш нарын 1, 5, 10 дахь жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайнаар зохион байгуулж, шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэн, төсөв нэмэхгүй байхаар даалгажээ.

³⁹ Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол

Тус тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор БСШУС-ын Сайдын 1а/1075 тоот албан бичгээр⁴⁰ аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өмнө хүргүүлсэн тушаал, чиглэл, зөвлөмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, теле-хичээлийг үргэлжлүүлэн зохион байгуулж, хичээлийн хуваарийг олон нийтэд мэдээлэх, багш нар 2020 оны 4-5 дугаар сард заах хичээлийн бэлтгэлийг чанартай хангах, мэргэжил дээшлүүлэх талаар аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газраас чиглэл, зөвлөмж боловсруулж хүргүүлэх, эцэг, эх асран хамгаалагчдад хүүхдээ хичээл хийлгэх, давтуулахдаа шийтгэлийн бус, хүмүүжлийн эерэг аргаар нөлөөлөх тухай зөвлөгөөг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулах зэрэг чиглэл өгчээ.

Түүнчлэн БСШУСЯ-аас дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагад 2/1174 тоот албан бичгээр⁴¹ лекцийг цахимаар тасралтгүй чанартай заах, семинар, явцын шалгалтыг танхимын сургалт эхэлсний дараа авах зохион байгуулалт хийх, цахим сургалтын чанар хангалтгүй байгаа талаар оюутан, суралцагчдаас гомдол, санал гарч байгааг анхаарч, багш тухайн хичээлийн агуулгыг бүрэн хамруулан, шинэлэг хэлбэрээр чанартай хөтлөн явуулж буйд хяналт тавьж, суралцагсадтай эргэх холбоотой ажиллах талаар чиглэл хүргүүлжээ.

Танхимын сургалтыг хойшлуулсны улмаас хаврын улирлын сургалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийх зайлшгүй хэрэгцээ бий болсон тул БСШУС-ын Сайдын А/118 тоот тушаалаар⁴² ЕБС-ийн сурагчдын 2019-2020 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтыг цуцлах, шалгалтын дүнг жилийн эцсийн дүнгээр тооцох шийдвэр гаргаж, шалгалтын үнэлгээг тооцох нэгдсэн аргачлал, зөвлөмж боловсруулж аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газарт хүргүүлэхийг Боловсролын үнэлгээний төвд үүрэг болгожээ. Мөн уг тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд БСШУС-ын Сайдын албан тоотоор анги дэвших болон улсын шалгалтыг цуцалснаас хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцох суралцагчдын идэвх болон багш, эцэг, эх асран хамгаалагчийн хариуцлага буурах зэрэг явдлыг гаргахгүй байхад хяналт тавьж ажиллахыг чиглэл болгожээ. Тэрчлэн, зөвлөгөө дэмжлэгээр хангаж ажиллах, багшийн журнал хөтлөх талаар Боловсролын хүрээлэнгээс гаргах зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар сургуулийн удирдлага, багш нарыг арга зүйгээр хангах зэрэг цаг

⁴⁰ БСШУС-ын Сайдын 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн “Чиглэл өгөх тухай” 1а/1075 тоот албан бичиг

⁴¹ БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 2/1174 тоот албан бичиг

⁴² БСШУС-ын сайдын 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн “Шалгалтын зохицуулалт хийх тухай” А/118 тоот тушаал

үеийн шинжтэй зохицуулалтыг хийж, хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газарт чиглэл⁴³ өгчээ.

БСШУС-ын Сайд тус яам болон харьяа байгууллагын албан хаагчид өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах зөвлөмжийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргасан бөгөөд тус зөвлөмжид албан хаагчдыг ажил үүргээ цахимаар гүйцэтгэн, эргэх холбоотой ажиллах, ажлын уулзалтад оролцсон бол үйл ажиллагааны товч тэмдэглэл хөтлөх, төрийн алба, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор хуваарь гарган ажиллуулсан байна.

2019 оны мэдээгээр манай улсад төрийн өмчийн 21, төрийн бус өмчийн 71, гадаадын сургууль 3, нийт 95 их, дээд сургууль⁴⁴ сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс төрийн өмчийн 20 их дээд сургуулийн вэб хуудсанд хандан, цахим хичээл үзэх, хичээл татах, даалгавар илгээх ажлыг дэмжин, дата хэрэглээг үнэгүй болгож сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг хүссэн албан бичгийг⁴⁵ БСШУСЯ-аас үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч компаниудад хүргүүлж ажиллажээ. Энэ нь манай улс Боловсролын тухай хуульдаа боловсролын байгууллагаа өмчийн хэлбэрээр нь зааглан төрийн өмчийн боловсролын байгууллагад чиглэсэн бодлого шийдвэрийг нэн тэргүүнд гаргаж, дэмжлэг үзүүлдэг нь шинэ төрлийн коронавирус (Ковид-19) халдварын энэ цаг үед ч илүү анхаарч шийдвэр, дэмжлэг үзүүлснээс жижиг гэлтгүй харагдаж байна.

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлыг 4 сарын 30 хүртэл сунгаж, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх, ажлын байраа хадгалж байгаа ажил олгогчийн ажилтныг Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжин, теле болон цахим хичээлийг зуны амралт хүртэл сунгаж, 12 дугаар ангийн сурагчдад ЭЕШ-д бэлтгэх танхимын сургалт зохион байгуулжээ.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор ЗГ-аас 2020 оны 102 дугаар тогтоол⁴⁶ гаргаж, улсын хэмжээнд гуравдах удаагаа бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгав. ЗГ-ын 2020

⁴³ БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн "Тушаал хэрэгжүүлэх тухай" 4/1310 тоот албан бичиг

⁴⁴ www.1212.mn

⁴⁵ БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн "Дэмжлэг хүсэх тухай" 2/1359 тоот албан бичиг

⁴⁶ Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 102 дугаар тогтоол

оны 114 дүгээр тогтоол⁴⁷, УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор⁴⁸ онцгой нөхцөл байдлын улмаас бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр зарим арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь татвар, нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгжийг татвар, торгууль, алдангиас чөлөөлөх, татварын зарим зохицуулалт хийх, даатгуулагчийн төлсөн шимтгэлийг хөнгөлөх, ажлын байраа хадгалж байгаа ажил олгогчийг дэмжих, тухайн аж ахуйн нэгжийн даатгуулагч иргэнд 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200,000 (хоёр зуун мянган) төгрөгийн дэмжлэг олгох, үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч буй нөхцөлд нийгмийн даатгалын шимтгэлээ хуулийн хугацаанд төлж, ажлын байраа хадгалж буй хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд төлснөөр тооцох шийдвэрт төрийн бус өмчийн бүх шатны боловсролын байгууллага хамрагджээ.

Боловсролын байгууллагууд сургалтын үйл ажиллагаагаа алсын зайн хэлбэрт шилжүүлэн боловсролын үйлчилгээг тасралтгүй, тэгш хүртээмжтэй хүргэх зарчмыг бүх шатны сургалтын байгууллага мөрдөж ажиллаж ирсэн бөгөөд 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр ЗГ-аас 139 дүгээр тогтоол⁴⁹ гаргаж, цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежийн суралцагчдад зориулсан теле болон цахим хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх шийдвэр гаргажээ. Улмаар 2019-2020 оны хичээлийн жилийн 2020 оны эхнээс зуны амралт хүртэлх хугацаанд хичээл сургалтын үйл ажиллагаа бүхлээрээ зайн сургалтын хэлбэрээр явагдлаа.

Цаашилбал, ЗГ-ын 2013 оны 37 дугаар тогтоолын⁵⁰ дагуу ЕБС төгсөгч, их дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авч хэвшээд байсныг энэ жил авахгүй байх зохицуулалт хийхээр болж, ЕБС

⁴⁷ Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол.

⁴⁸ УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн “Коронавируст халдвар (КОВИД -19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоол

⁴⁹ Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн “Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 139 дүгээр тогтоол.

⁵⁰ Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол.

төгсөгчдөд ЭЕШ-д бэлтгэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ тус шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд халдвар, хамгааллын дэглэм баримтлан 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд зохион байгуулахыг холбогдох байгууллагад үүрэг болгожээ. Давтлагыг ерөнхий боловсролын 550 сургууль дээр зохион байгуулж, тэдгээрт 25,0 мянган суралцагч хамрагдан, 6,6 мянган багш удирдаж оролцсон талаар БСШУСЯ-наас мэдээлжээ.⁵¹ Түүнчлэн, уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БСШУС-ын Сайдын А/195 тоот тушаалаар 2020-2021 оны хичээлийн жилд дээд боловсролын байгууллагад элсэн суралцагчдын үндэсний хэмжээний босго оноог төрийн өмчийн их, дээд сургуульд 480, төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежид 410, орон нутгийн их, дээд сургууль, коллежид 400 оноо байхаар тогтоон, элсэлтийн үйл ажиллагааг 2020 оны 7 дугаар сарын 10-ны дотор цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллажээ. Харьцуулах юм бол, 2017-2018 оны хичээлийн жилд үндэсний хэмжээний босго оноо 400 байсныг БСШУС-ын Сайдын тушаалаар 2018-2019 оны хичээлийн жилд 480 болгон тогтоосон юм.⁵² Улмаар их, дээд сургуульд элсэн орох үндэсний хэмжээний босго оноо зайн сургалт давамгайлсан энэ жилд өөрчлөлтгүй, өмнөх оныхтой ижил байхаар тогтоожээ.

2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлын сургалт, суралцагчийн анги дэвших болон төгсөлтийн шалгалт, диплом хамгаалалт, төгсөлтийн бичиг баримтыг олгох үйл ажиллагааг 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдөрт багтаан цахим хэлбэрээр зохион байгуулж дуусгахаар элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг зохицуулжээ.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 95 их дээд сургууль, коллеж уг тушаалын хэрэгжилтийг зохих түвшинд ханган ажиллаж ирснийг БСШУСЯ-д ирүүлсэн тайлан, мэдээнээс харж болно.

Төрөөс боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй, тасралтгүй хүргэхэд УИХ, ЗГ, БСШУСЯ түүний харьяа байгууллагууд хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажилласан нь баримт бичгийн агуулга, тэдгээрийн хэрэгжилт, зохион байгуулалтад тодорхой тусжээ. Харин суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч талын байр сууринаас дүгнэвэл, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг эргэх холбоотойгоор нэг бүрчлэн үнэлж, дүгнэсэн нь хомс, мөрдөн хэрэгжүүлэх журам, заавар нь цаг үеийн шинжтэй учир тэр бүр хэрэгжилтийг хянах, сайжруулах тал дээр анхааралгүй орхигдуулсан зүйл байгааг дурдах нь зүйтэй болов уу.

⁵¹ БСШУСЯ-ны үйл ажиллагааны 2020 оны 5 дугаар сарын мэдээ

⁵² Засгийн газрын мэдээ, 2017 он. "Авьяасыг "гудамжинд" үлдээж байгаа босго оноог өөрчилье" нийтлэл.

2.2 Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт боловсролын салбарт

УОК-ын шийдвэрт үндэслэн ЗГ-ын 2020 оны 147 дугаар тогтоолоор⁵³ өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг дөрөв дэх удаагаа 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасан. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” 4 бүлэг, 19 зүйлтэй, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр байх хугацаатай, уг хугацааг УИХ зургаа хүртэл сараар нэг удаа сунгаж боломжтой хууль үйлчилж байна. УИХ нь Түр хороо байгуулан⁵⁴ Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын талаар сар тутам хэлэлцэх, тус асуудлаар дараалал харгалзахгүй Байнгын хороо, чуулганы хуралдаанаар хэлэлцэх, ЗГ-т тогтмол хяналт тавьж ажиллах, ЗГ-аас журам, заавар батлах, төсвийн зохицуулалт хийх, бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгахад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээ авах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Тус хуулийн 7.1.9-д бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах тухай заасан. Энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш УОК-ын шийдвэрт үндэслэн өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг ЗГ-ын 2020 оны 5 дугаар сарын 188 дугаартай тогтоолоор⁵⁵ 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл, 6 дугаар сарын 234 дугаартай тогтоолоор⁵⁶ 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл, 7 дугаар сарын 10-

⁵³ Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 147 дугаар тогтоол.

⁵⁴ УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Түр хороо байгуулах тухай” 49 дүгээр тогтоол. Энэхүү түр хорооны даргад Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, гишүүдэд 9 байнгын хорооны даргын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнгээр УИХ-д 11 байнгын хороо байгуулан ажиллаж байгаа бөгөөд сонгуулийн өмнө байгуулсан түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байгаа болно.

⁵⁵ Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, журам батлах тухай” 188 дугаар тогтоол.

⁵⁶ Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах батлах тухай” 234 дүгээр тогтоол.

ны өдрийн 1 дүгээр тогтоолоор⁵⁷ 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл, 7 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор⁵⁸ 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал тус тус сунгажээ. Улмаар энэ хугацаанд боловсролын салбар нь өндөржүүлсэн бэлэн байдлын горимоор зайн сургалтаар үйлчилгээгээ зохион байгуулж иржээ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын, их, дээд сургууль, коллежийн бүх хичээл ТВ болон цахим хэлбэрээр үргэлжилж байгаа тул боловсролын үйлчилгээний тасралтгүй байдал хангагдаж байна гэж дүгнэж болохоор байна.

Манай улсад хичээлийн жил 9 дүгээр сарын 1-нд эхлэн, арван сар үргэлжлэх бөгөөд чанарын болон анги дэвших, төгсөх шалгалтыг ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежууд 4, 5 дугаар сард зохион байгуулдаг бол их, дээд сургууль, коллежид элсэх уралдаант шалгалтыг улсын хэмжээнд 2006 оноос хойш жил бүрийн 6 дугаар сард, элсэлтийн үйл ажиллагааг 7 дугаар сард зохион байгуулж хэвшсэн. Энэ хичээлийн жилийн хувьд цар тахлын улмаас зохион байгуулах хугацаанд өөрчлөлт оруулсан бөгөөд их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авдаг ЭЕШ-ыг улсын хэмжээнд 2020 оны 7 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд БСШУСЯ-ны дэргэдэх БҮТ зохион байгуулав. Энэхүү уралдаант шалгалтад оролцохоор 30,902 шалгуулагч бүртгүүлсний 27,999 нь 2020 онд ЕБС төгсөгч, 2,903 нь өмнөх онуудад ЕБС төгсөгчид байжээ. Жич дурдахад, жил бүр 12 дугаар анги төгсөгчдийн тоо өөр өөр байдаг тул цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь элсэгчдийн тоонд нөлөөлсөн эсэхийг харьцуулан дүгнэх боломжгүй юм.⁵⁹ ЭЕШ-ыг тасалдуулалгүй зохион байгуулсан явдал нь боловсролын үйлчилгээний тасралтгүй байдал хангагдахын зэрэгцээ дараагийн шатны боловсролд дэвшин суралцах сурагчдын эрх хангагдсаны баталгаа болж байна.

2020-2021 оны хичээлийн жилийн нээлт ч мөн л коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалт буураагүй, зарим улсад цар тахлын хоёр дахь давлагаа идэвхжиж байгаа үетэй давхцав. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас анхаарал сэрэмжээ бууруулахгүй байхыг анхааруулсаар байгаа онцгой нөхцөл байдлын үед шинэ хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, танхимын сургалтыг үе шаттай нээх шийдвэрийг ЗГ-аас гаргаж, улмаар харьяалах Яамд журам, заавар, зөвлөмж гарган, зохион

⁵⁷ Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 1 дүгээр тогтоол.

⁵⁸ Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 31 дүгээр тогтоол.

⁵⁹ Жишээлбэл, 2018 онд ЭЕШ-д нийт 438846 шалгуулагч, 2019 онд 188130 шалгуулагч бүртгүүлсэн тухай БҮТ мэдээлж байжээ.

байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Монгол Улсын Шадар Сайд, Сангийн Сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Боловсрол, шинжлэх ухааны Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2020 оны 8 дугаар сард баталсан “Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” хамтарсан тушаалаар⁶⁰ коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2-ын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд: (i) салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад шаардлагатай журам, заавар, удирдамжийг баталж, мөрдүүлэх; (ii) хичээл сургалтын үйл ажиллагаа удаан хугацаанд завсарласны улмаас багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчдад гарч болзошгүй айдас түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах нийгэм-сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг гэр бүлд түшиглэн 2 сарын хугацаатай зохион байгуулах; (iii) сургалтын байгууллагын төлбөр, хураамжийг эцэг, эх, асран хамгаалагчдад санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр сар, улирлаар төлөх уян хатан зохицуулалт хийхийг сургалтын байгууллагын удирдлагад үүрэг болгох; (iv) сургалтын үйл ажиллагаанд оролцогчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулах; (v) бүх шатны сургалтын байгууллагын халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах зэрэг болно. Эдгээр зохицуулалтын хэрэгжилтийг олон нийтийн мэдээллийн эх сурвалжаас тандав.

2019-2020 оны хичээлийн жилийн гуравдугаар улирлын эхний нэг долоо хоног хичээллээд түүнээс хойш Ковид-19-ийн халдвар тархах эрсдэлийн улмаас улс даяар сургалтын үйл ажиллагаа теле болон цахимд шилжсэнээр багш нар анги болгонд Facebook хуудас нээж, түүндээ хичээлээ тайлбартайгаар оруулаад явсан туршлага өргөн хүрээнд хэрэгжжээ. Мөн энэ хуудсаараа дамжуулан хүүхдүүдийн хичээлийн хамрагдалт, идэвх, орон нутагт явсан сурагчийн тоо, хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан зэргийг судлаад, тус бүрд нь тохирсон арга хэмжээ авч ажиллахыг хичээжээ. Дээрх хугацаанд теле-хичээлийн хүртээмж ямар байсан талаар Боловсролын хүрээлэнгээс эцэг, эх (12,000), сурагчдаас (5,700) тандах судалгаа авахад сурагчдын 46.8 хувь нь байнга, 30.52 хувь нь заримдаа ТВ хичээл үздэг гэж хариулсан байна⁶¹. Тус тандах судалгаанд

⁶⁰ Монгол Улсын Шадар Сайд, Сангийн Сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд, Боловсрол, шинжлэх ухааны Сайд, Эрүүл мэндийн Сайдын “Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” хамтарсан 78, 149, А/164, А/14, А/391 тоот тушаал. 2020 оны 8 дугаар сар

⁶¹ Facebook: Боловсролын хүрээлэн - Mongolian Institute for Education

үндэслэн Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмжийг судлагдахуун тус бүрээр боловсруулан 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 1-ний хооронд теле-хичээлээр өгсөн агуулгыг бататгах, өмнөх ангийн агуулгын хоцрогдлыг арилгах чиглэлээр танхимын сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн нь танхимын сургалт эхлэхээр ерөнхий боловсролын сурагчдын хувьд үүсэж болох хүндрэл бэрхшээлийг даван туулах сэтгэл зүйн бэлтгэл болно гэж салбарын судлаач, багш нар үзсэн байна.

Танхимын сургалт эхлэхээс өмнө боловсролын салбарын багш, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажил нь Ковид-19-ийн цар тахлаас сэргийлэх ажилтай шууд холбоогүй юм. 2019 оны 5 дугаар сард Ерөнхий Сайд У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулсан⁶² Багш нарын долоодугаар их хурлын үеэр ЗГ ээлжит бусаар хуралдаж, баталсан тогтоолд багш нарыг урьдчилсан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах тухай заажээ. Уг заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЭМ, БШУ-ны Сайдын хамтарсан удирдамж гарснаар багш нарыг шинэ хичээлийн жил эхлэхээс өмнө болон хичээлийн жилийн эхний улиралд 135-175 мянган төгрөгийн үнэтэй 12-15 нэр төрлийн багцын үзлэг шинжилгээнд Эрүүл мэндийн даатгалын журмаар үнэ төлбөргүй хамруулжээ.⁶³ Энэ жил Улаанбаатар хотын багш нарыг хуваарийн дагуу зөвхөн дүүргийн эмнэлэгт үзүүлэхээр зохион байгуулсан нь урт дараалал үүссэний улмаас удаан хугацаагаар дугаарлан зогсох, бөөгнөрөл үүсэх, хүн хоорондын зай барих боломжгүй нөхцөл үүссэн тухай мэдээлэл байна.⁶⁴

БШУ-ны Сайдын 2020 оны А/21 тоот тушаалаар⁶⁵ их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа лекцийн хичээлийг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс цахимаар эхлүүлж, семинар, лабораторийн хичээлийг 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдрөөс танхимын сургалтаар үргэлжлүүлэхээр заасан. Тэрчлэн, улсын эдийн засгийн өсөлт саарсан, иргэдийн орлого буурсан байдлыг харгалзан сургалтын төлбөр төлөлтийг уян хатан арга хандлагаар зохицуулж, тухайн нөхцөл байдлыг эрсдэл багатай даван туулах арга хэмжээ авах талаар дээд боловсролын сургалтын байгууллагуудад үүрэг, чиглэл өгчээ. БШУЯ-аас хувийн өмчийн цэцэрлэг, ЕБС, МСҮТ, их, дээд сургуулиудын төлбөрийг сар, улирлаар төлж болох зохицуулалт хийх асуудлаар сургуулийн удирдлагатай зөвлөлдөж байгаа⁶⁶ ч ихэнх хувийн сургууль сургалтын төлбөрөө

⁶² <http://www.mier.mn/wp-content/uploads/2019/05/negtgel-3.pdf>

⁶³ <http://itoim.mn/article/DCqdx/23191>

⁶⁴ <https://gogo.mn/r/8dmw2>

⁶⁵ БШУ-ны Сайдын 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн “Түр журам батлах” А/21 тоот тушаал.

⁶⁶ <https://gogo.mn/r/6v068>

сараар авах боломжгүй тул улирлаар урьдчилж авах, хоёр хувааж авах байдлаар ажиллаж байгаа ба цөөн тооны сургууль 100 хувь урьдчилж авсан гэж Монголын хувийн хэвшлийн 80 бага, дунд сургуулийг нэгтгэсэн холбооноос мэдээлжээ.⁶⁷ Хувийн болон төрийн мэдлийн их, дээд сургуулиуд 2020-2021 оны сургалтын төлбөрөө нэмэхгүй гэж мэдэгдээд байгаа ч сар, улирлаар төлбөрөө төлөх боломжийн талаар ямар нэг мэдээлэл байхгүйн дээр Төрийн сангийн зээлээр суралцдаг оюутнуудын төлбөр өнгөрсөн хичээлийн жилээс төлөгдөөгүй хүлээгдэж байгаа⁶⁸ тухай их, дээд сургуулиуд мэдээлжээ. Улмаар хувийн хэвшлийн цэцэрлэг, бага, дунд сургуулиуд улирлаар төлбөрөө төлөх боломжийг олгож байгаа ч зарим нь төлбөрөө бүрэн хэмжээгээр авч байгаа, харин төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд төлбөр төлөлтийн уян хатан боломжийг хэрхэн нэвтрүүлж байгаа нь тодорхойгүй байна.

БШУЯ-аас 2020-2021 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор тусгайлсан зөвлөмж⁶⁹ гаргаж, бүх шатны боловсролын байгууллага, боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хичээлийн жилийн бэлтгэлийг хангуулах, цар тахлын халдвар болон улирлын ханиадны эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах, цэвэрлэгээ, ариутгалын давтамжийг нэмэгдүүлэх, сургалтын байгууллага дахь хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл, шим тэжээлийн зохистой байдалд хяналт тавих, эрсдэлт нөхцөлд буюу тухайн сургалтын байгууллагад халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж бэлтгэлээ хангахыг зөвлөжээ. БШУ-ны Сайдаар ахлуулсан Шадар Сайдын ажлын алба, МХЕГ, ОБЕГ, СЯ, ЭМЯ, ХНХЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн төлөөллүүд багтсан Ажлын хэсэг байгуулж, хичээл, сургалтыг эхлүүлэх бэлтгэл хангах арга хэмжээнүүдийг тодорхойлж, шаардлагатай удирдамж, чиглэлүүдийг гаргажээ. БШУЯ-аас хичээлийн шинэ жилийн нээлтийн бэлтгэлийг хангах асуудлаар салбар дамнасан болон салбарын байгууллагуудыг хамруулан арга хэмжээнүүд зохион байгуулжээ. Энэ оны 8 дугаар сард БШУЯ-аас “2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажил, анхаарах асуудал” сэдэвт сургалт-семинарыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга, ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан хийж, БШУЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ, БҮТ, ОБЕГ-ын мэдээллийг хүргэжээ. Аймгийн Боловсрол соёлын газар (БСГ)-аар дамжуулан цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, энэ чиглэлээр гарсан УОК, Засгийн газар, холбогдох сайд нарын баталсан тушаал,

⁶⁷ <https://ubn.mn/p/5765>

⁶⁸ <https://ulsturch.mn/research/article/37248>

⁶⁹ <https://www.meds.gov.mn/?p=5138>

шийдвэр, дүрэм, журмыг танилцуулах сургалтуудад харьяа сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч нарыг хамруулжээ.⁷⁰ Түүнчлэн Мэргэжлийн хяналтын байгууллагаас боловсрол, сургалтын байгууллагад зориулсан коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх зөвлөмж⁷¹ гарган, хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сургалтын байр, анги танхимын цэвэрлэгээ ариутгал, багшлах бүрэлдэхүүн, ажилтны эрүүл мэндийн байдал, мэргэжлийн байгууллагаас гаргасан журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд анх удаагаа танхимын сургалт зохион байгуулж байгаатай холбогдуулан гарч болох халдвар хамгааллын журам зөрчих, эрсдэлт нөхцөл байдал үүсэхээс бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хамгаалах талаар зөвлөжээ. МХЕГ-аас боловсролын байгууллагуудад хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, 2020 оны 8-9 дүгээр сард хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн дутагдлыг арилгуулж ажиллажээ.

БШУ-ны Сайдын 2020 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн А/17 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар⁷² цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзалгүй зохион байгуулах түр журмыг батлан, 3-4 настай хүүхдийг үргэлжлүүлэн цэцэрлэгт хүлээн авах, 5 настай 79,900 хүүхдийг⁷³ цэцэрлэгт бүрэн хамруулах, төрийн бус өмчит цэцэрлэгийн сул орон зайг ашиглан 5,087 хүүхдийг хувийн цэцэрлэгт төрийн өмчийн зардлаар⁷⁴ авах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагааг эхлэх гэж байгаатай холбогдуулан нэг хүүхдэд 1-1.5 ам.метр талбай оногдохоор баримжаалж, нэг ангид 20-25 хүүхэд хамруулах, түүнчлэн тухайн харилцаанд оролцогчдын үүргийг сайдын тушаалаар батлагдсан түр журамд тусгасан байна. Мөн тус тушаалын хоёрдугаар хавсралтаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагч танхимын сургалтаар өдөрт 3-4 хүртэл цаг (60 минутаар 2-3 цаг хичээллэх)-ийн хичээл судлах, 7 хоногт судлах танхимын сургалтын нийт цаг 12-оос хэтрэхгүй буюу ажлын 5 өдрийн 3 өдөрт танхимын сургалт, 2 өдөрт теле болон цахимаар хичээллэхээр, нэг анги, бүлэгт хичээллэх хүүхдийн тоо 20-25 байхаар тооцож түр журамд тусгасан байна. Энэ нь эцэг, эхчүүдийн зүгээс тодорхой шүүмжлэл дагуулсан шийдвэр байсныг дурдах нь зүйтэй.

⁷⁰ <http://www.shuud.mn/a/521518>, <https://www.montsame.mn/mn/read/234752>

⁷¹ МХЕГ, Боловсрол, сургалтын байгууллагад зориулсан коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх зөвлөмж. 2020 оны 8 дугаар сарын 18

⁷² БШУ-ын Сайдын 2020 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” А/17 тоот тушаал

⁷³ <https://mecss.gov.mn/news/2680/>

⁷⁴ <https://www.montsame.mn/mn/read/234287>

Бүлгийн дүгнэлт

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдахын өмнөх болон дараах гэж заагтайгаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлан үзлээ. УОК-ын шийдвэрт үндэслэн анх ЗГ-аас 2020 оны 1 дүгээр сарын 27-нд тогтоосон гамшигтай тэмцэх өндөржүүлсэн бэлэн байдлыг удаа дараа сунгасны улмаас 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдөр буюу 2020 оны хичээлийн жил дуусаж сурагчдын зуны амралт хүртэл цэцэрлэг, ЕБС, их дээд сургууль, коллежийн суралцагчид алсын зайнаас хичээллэсэн. Энэ бүх хугацаанд БШУЯ-ны харьяа байгууллага сургуулиудын ажлыг зохион байгуулж, теле болон цахим хичээлийг тасралтгүй хэрэгжүүлэх, ЕБС төгсөгчдийн дээд боловсролд шилжих шалгалтыг зохион байгуулахад анхаарч ажиллажээ. Харин боловсруулж гаргасан олон тооны эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хянах, байгууллагуудын уялдаа холбоог хангах тал дээр сул байгааг суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчид анхааруулж байжээ. Хууль батлагдахаас өмнөх эрх зүйн орчны үр нөлөө, харилцан хамаарлыг дүгнэн үзвэл, сургалтыг тасралтгүй, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах зорилтыг хангахад төвлөрч ажилласан ч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангахад төдийлөн анхаарал хандуулж чадаагүйг илэрхийлсэн баримт цөөнгүй дурдагдсан болно.

УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг батлан гаргасны дараах эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтөөр бол төрийн болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг зааглаж өгснөөр хэрэгжүүлэх, харьяалах ажлын зорилго, чиглэл тодорхой болж хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарал хандуулж эхэлсэн байна. Боловсролын салбарт эрүүл мэнд, мэргэжлийн хяналт, онцгой байдлын салбарын оролцоо нэмэгдэж, аймгийн БСГ, Боловсролын хүрээлэн зэрэг байгууллага, нэгжийн үйл ажиллагаа сургуулиудад хүрч эргэх холбоог сайжруулан ажиллах нь нэмэгджээ. Гэхдээ хуулийн хэрэгжилт хангалттай байгаагүй бөгөөд зарим асуудал одоо ч шийдэгдээгүй хэвээр байна.

Хууль хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын Хүрээлэнгээс Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмжийг судлагдахуун тус бүрээр боловсруулан хүргэж, 2020 оны 9 дүгээр сарын 1-ээс нэг сарын хугацаанд өмнөх хичээлийн жилийн агуулгын хоцрогдлыг арилгах танхимын сургалт зохион байгуулахаар болж, багш нарын сургалт семинар хийсэн нь

танхимын сургалт эхлэхэд багш, сурагчдын сэтгэл зүйг бэлтгэхэд хувь нэмэр болжээ.

2020 оны 8 ба 9 дүгээр саруудад багш, сургуулийн ажилтнуудыг хичээлийн жилийн эхэнд эрүүл мэндийн үзлэгт үнэгүй хамруулах шийдвэр 2019 онд гарч, цар тахалтай тэмцэх хуулиар баталгаажсан арга хэмжээ хэрэгжсэн нь сайн талтай. Хэдий тийм боловч энэхүү арга хэмжээг зохион байгуулалтын хувьд урт дараалал болон бөөгнөрөл үүсгэхгүйгээр, хүн хоорондын зай барих боломж олгосон байдлаар хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж чадаагүй байна.

Мөн хуулиар хувийн өмчийн цэцэрлэг, ЕБС, МСҮТ, төрийн болон хувийн их, дээд сургуулиуд сургалтын төлбөрийн уян хатан хуваарь гаргаж, сар, улирлаар нь төлбөрөө хувааж төлөх боломжийг хангах тухай заалт орсон ч хувийн сургуулиуд ийм зохицуулалт хийх боломжгүй тухайгаа тайлбарлаж, ихэнх сургууль төлбөрөө улирал, хагас жилээр урьдчилж авсан бол цөөн хэдэн сургууль төлбөрөө 100 хувиар төлүүлжээ.

Эрүүл ахуй, халдвар хамгаалалтын горимыг сайжруулах заалтын хүрээнд боловсролын байгууллагууд арга хэмжээ авч ажиллах тухай заалтын хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын газар хяналт тавьж ажиллаж байгаагийн зэрэгцээ аймгийн БСГ нь харьяа цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад чиглүүлж ажиллаж байгаа ажээ.

Энэ бүлэгт судлагдсан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэхэд онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн нөхцөл байдлыг урьдчилан тооцоолон тодорхой шийдвэр гаргаж биелэлтийг хангаж ажилласан нь хангалттай дүгнэлт хийх боломжтой боловч шинээр үүссэн нөхцөл байдлыг дагаж гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах нь цаг үеийн шинжтэй байж болохыг дурдах нь зүйтэй.

ГУРАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗАЙНААС ХҮРГЭХЭД ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖИЙН НӨЛӨӨЛӨЛ

Бүлгийн танилцуулга

Энэхүү судалгаанд боловсролын үйлчилгээг хүргэхэд шаардлагатай дэд бүтцийн хүртээмжийг тооцоолохдоо ерөнхий боловсрол болон дээд боловсролд шаардагдах дэд бүтцийн өнөөгийн нөхцөл боломжийг тусад нь үнэлж дүгнэлээ. Үүний дотор дээд боловсролын үйлчилгээ нь голчлон интернэтэд суурилж хэрэглэгчид хүрэх загвараар хэрэгжсэн тул интернэтийн хүртээмж, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний хангамж гэсэн хүчин зүйлсээс хамаарах таамаглал дэвшүүлээд харин ерөнхий боловсролын хувьд боловсролын үйлчилгээнд теле-хичээл үзэх, интернэтийн эх үүсвэр (<https://econtent.edu.mn/>)-ээс хичээл үзэх, гэрийн даалгавар авах, шалгуулах гэсэн гурван тусдаа үйл ажиллагааг авч үзлээ. Теле-хичээл үзэхэд айл өрхийн телевизийн олон сувгийн үйлчилгээний хэрэглээ, IPTV буюу интернэт протоколд суурилсан телевиз үзэх боломж, цахилгаан эрчим хүчний хангамж нөлөөлж, интернэтийн эх үүсвэрээс хичээл үзэхэд интернэтийн хүртээмж, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний хангамж гэсэн хүчин зүйлс, гэрийн даалгавар авах, шалгуулахад интернэтийн хүртээмж, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний хангамжаас гадна зарим тохиолдолд багш нь суралцагчтайгаа очиж уулзах, эсхүл суралцагчдыг дуудан ирүүлэх замаар ажиллаж байгаа тул тухайн сургуулийн сурагчдын амьдарч буй газар сургуулиас алслагдсан байдал тус тус нөлөөлнө гэж таамаглав.

Дээр дурдсан таамаглалыг баримтлан шинжилгээ хийхдээ (i) дээд боловсролын хичээл үзэх, (ii) интернэтэд байршуулсан www.econtent.edu.mn-ээс хичээл үзэх, (iii) ерөнхий боловсролын сургуулийн багш нар гэрийн даалгавар өгөх, шалгах гэсэн гурван төрлийн үйл ажиллагаанд интернэтийн болон интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний хүртээмж гэсэн хүчин зүйлс нөлөөлнө гэж үзэж байна. Харин ерөнхий боловсролын сургуулийн теле-хичээл үзэх суралцагчийн үйл ажиллагаанд IPTV буюу интернэт протоколд суурилсан олон сувагт телевизийн үйлчилгээг хэрэглэх боломж, хөдөлгөөнт төхөөрөмжөөс теле-хичээл үзэх боломж, интернэтийн хүртээмж болон цахилгаан эрчим хүчний хүртээмж гэсэн хүчин зүйлс нөлөөлнө гэж тооцсон болно. Харин

ерөнхий боловсролын сургуулийн багш нар даалгавар шалгахдаа биечлэн очиж даалгавар өгөх, шалгах болон сурагчдыг дуудан ирүүлж даалгавар өгөх, шалгах байдлаар ажилласан тохиолдлууд байгаа бөгөөд энэ тохиолдолд авто зам болон авто тээврийн хүртээмж, сурагчдын сургуулиасаа алслагдсан байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлөх боломжтой гэж үзэж шинжилгээ хийлээ.

Энэхүү тайлангийн гуравдугаар бүлэг нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ боловсролд нөлөөлөх нь гэсэн эхний дэд бүлэг, харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ боловсролд нөлөөлөх нь гэсэн хоёрдох дэд бүлгээс бүрдэж байгаа болно.

3.1 Цахилгаан эрчим хүчний дэд бүтэц боловсролын үйлчилгээнд нөлөөлөх нь

Цахилгаан эрчим хүчний хэрэглээг хэрэглэгчдийг хангах хүртээмж болон хангамжийн найдвартай байдал, нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ гэсэн үзүүлэлтүүдээр ангилж дараах байдлаар судаллаа.

Цахилгаан эрчим хүчний хүртээмж

Дэлхийн эдийн засгийн форум (*World Economic Forum*)-ын судалгаагаар цахилгаан эрчим хүчний хангамжийн чанараараа Монгол Улс 137 улс орноос 95 дугаар байранд жагссан нь дунджаас доогуур үзүүлэлт юм.⁷⁵ Олон улсын судалгаанаас үзэхэд, ИндексМунди (*IndexMundi*) вэбсайтаас авсан мэдээллээр Монгол Улс нь 2017 оны байдлаар хүн амынхаа 85.87 хувийг цахилгаан эрчим хүчээр хангасан үзүүлэлтээрээ дэлхийн 195 улс орноос 141-д жагсаж байгаа нь мөн л дунджаас доогуур үзүүлэлт юм.⁷⁶ Энэ нь нийт хүн амын 14 орчим хувь цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй байгаа үзүүлэлт. Харин Дэлхийн банкны судалгаанаас үзвэл, 2018 онд Монгол Улсын цахилгааны хүртээмж хотын хүн амын хувьд 99.7 хувь, хөдөө орон нутгийн хүн амын хувьд 94.6 хувь, дунджаар нийт хүн амын 98.1 хувьд хүрсэн үзүүлэлттэй байсан ажээ.⁷⁷

Монгол Улсын дотоодын мэдээллийг судалж үзэхэд Улаанбаатар хотын зарим хэсэгт, мөн зарим орон нутагт цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрх

⁷⁵ World Economic Forum, Quality of electricity supply, <http://reports.weforum.org/global-competitiveness-index-2017-2018/competitiveness-rankings/#series=EOSQ064>

⁷⁶ IndexMundi, Access to electricity (% of population) - Country Ranking, <https://www.indexmundi.com/facts/indicators/EG.ELC.ACCS.ZS/rankings>

⁷⁷ World Bank, Sustainable Energy for All (SE4ALL). Access to electricity (% of population) database from the SE4ALL Global Tracking Framework led jointly by the World Bank, International Energy Agency, and the Energy Sector Management Assistance Program. <https://data.worldbank.org/indicator/EG.ELC.ACCS.ZS?locations=MN>.

цөөнгүй байдаг талаар зарим эх сурвалжид дурдсан байв. Тухайлбал, 2017 онд “Нийслэл хотод эрчим хүчинд холбогдоогүй 6,000 гаруй өрх айл байгаа бөгөөд тэдний ихэнх нь Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд оршин суудаг” гэсэн мэдээ байна.⁷⁸ Мөн өөр нэг эх сурвалжид нийслэлийн хэмжээнд 2016 оны байдлаар 8,000 айл өрх төвлөрсөн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй бөгөөд үүний 6,000 орчим нь Сонгинохайрхан дүүрэгт байсан тухай дурджээ⁷⁹. Түүнчлэн “хотын захын гэр хороололд цахилгаан, гэрлийн бараа харалгүй 10 шахам жил амьдарч байгаа айл өрх олон бөгөөд 2019 оны байдлаар Улаанбаатар хотод 10 мянган орчим айл өрх цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй гэсэн судалгааны дүн гарч”⁸⁰ байжээ. Энэ мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах зорилгоор Эрчим хүчний яамны мэдээллийг шүүж үзэхэд, уг яамнаас 2019 онд төвийн эрчим хүчинд холбогдоогүй Сонгинохайрхан дүүргийн 7, 9, 24, 25 дугаар хорооны айл, өрхүүдийг холбох тендер зарлаж байжээ.⁸¹ Эдгээр мэдээллээс үзэхэд, Улаанбаатар хотын хэмжээнд ойролцоогоор 6,000-8,000 өрх цахилгаанд холбогдоогүй хэвээр байгаа гэж үзэх үндэслэлтэй. Улаанбаатар хотод амьдарч байгаа 601,500 өрхөөс⁸² ойролцоогоор 7,000 айл өрх нь цахилгаанд холбогдоогүй гэж үзвэл нийт өрхийн 1.16 хувь болох бөгөөд энэ нь Дэлхийн банкны Монгол Улсын цахилгааны хүртээмж 98.1-д хүрсэн гэх мэдээлэлтэй ойролцоо тоо юм.

Үндэсний статистикийн хорооноос 10 жил тутамд зохион байгуулдаг⁸³ Хүн ам, орон сууцны тооллого (ХАОСТ)-ын судалгаанд өрхийн цахилгаан эрчим хүчээр хангагдсан байдлыг багтаахаар төлөвлөсний дагуу сүүлийн буюу 2020 оны ХАОСТ-ын судалгаанд энэ мэдээлэл туссан байна. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээс үзэхэд, нийт өрхийн 99.5, гэрт амьдардаг өрхийн 98.7, байшинд амьдардаг өрхийн 99.9 хувь нь тус тус цахилгааны эх үүсвэрт холбогджээ. Улсын хэмжээнд 4.7 мянган өрх цахилгаангүй байгаагаас 93.5 хувь нь гэрт амьдардаг өрх бөгөөд тэдгээрийн 76.8 хувь нь орон нутагт оршин сууж байна. Улмаар улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчээр хангагдсан

⁷⁸ VIP76 вэбсайт, <https://vip76.mn/content/47273>

⁷⁹ VIP76 вэбсайт, [дhttp://www.enkhamgalan.mn/content/49113](http://www.enkhamgalan.mn/content/49113)

⁸⁰ BARILGA.mn сайт, Хонгилын үзүүр дэх гэрэл 5-р цахилгаан станцыг хүлээх зуур, 2019-11-05, <https://www.barilga.mn/n/5533/>

⁸¹ Эрчим хүчний яамнаас зарласан худалдан авах ажиллагааны зар, Тендер шалгаруулалтын дугаар: ТӨБЗГ/201904031, 2019-04-04, https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1551751972797#tab_18_3

⁸² Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, Хуудас 170, <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn>

⁸³ Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль (2008)-ийн 7 дугаар зүйлийн 7.1.10 жил тутамд улс орон даяар явуулах ээлжит тооллого.

884,700 өрх, эрчим хүчинд холбогдоогүй 4,700 өрх байгаа бол эрчим хүчээр хангагдсан нь 99.47 хувь, харин эрчим хүчинд холбогдоогүй нь 0.53 хувь байна гэж статистикийн мэдээнд тусжээ. Эдгээр статистик үзүүлэлтийг доорх хүснэгтэд тоймлон харуулав.

Хүснэгт 11. Өрхийн тоо, сууцны төрөл, цахилгааны эх үүсвэр, хот, орон нутагт (дүнд эзлэх хувиар, 2020 он)

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Орон нутаг	
	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь
Бүгд	889,400	100.0	601,500	100.0	287,900	100.0
Төвлөрсөн систем	725,500	81.6	594,500	98.8	131,000	45.5
Дизель станц	500	0.1	200	-	300	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	151,200	17.0	4,600	0.8	146,600	50.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	7,600	0.8	1,000	0.2	6,600	2.3
Цахилгааны эх үүсвэргүй	4,700	0.5	1,300	0.2	3,400	1.2
ГЭР	342,400	100.0	149,900	100.0	192,500	100.0
Төвлөрсөн систем	196,700	57.4	144,100	96.2	52,600	27.3
Дизель станц	200	0.1	-	-	200	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	134,400	39.2	3,900	2.6	130,500	67.8
Бага оврын цахилгаан үүсгүүр	6,800	2.0	800	0.5	6,000	3.1
Цахилгааны эх үүсвэргүй	4,400	1.3	1,000	0.7	3,400	1.7
БАЙШИН	547,000	100.0	451,600	100.0	95,400	100.0
Төвлөрсөн систем	528,800	96.7	450,400	99.7	78,400	82.3
Дизель станц	300	-	200	-	100	0.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	16,800	3.1	700	0.2	16,100	16.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	800	0.1	200	-	600	0.6
Цахилгааны эх үүсвэргүй	300	0.1	300	0.1	-	0.1


Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, хуудас 170, дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү. <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn>

Цахилгааны эх үүсвэрт холбогдсон болон цахилгааны найдвартай байдлын талаарх статистик мэдээллийг гаргуулахаар Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв болон Эрчим хүчний яамны холбогдох албан тушаалтанд хүсэлт илгээсэн боловч улсын нууцад хамаарах мэдээлэл гэж үзээд тодорхой хариу өгөөгүй болно. Түүнчлэн ямар эрх зүйн үндэслэлээр улсын нууцад хамааруулсан болохыг тодруулах зорилгоор утсаар хандсан боловч

мөн л тодорхой хариулт өгөөгүй билээ. Иймд энэхүү судалгааны хүрээнд цахилгаан эрчим хүчний зарим үзүүлэлтийг аймаг тус бүрээр харьцуулан судлах боломжгүй байлаа. Үндэсний статистикийн хорооноос гаргасан эрчим хүчний статистикийн үзүүлэлтээс харахад Монгол Улсад цахилгааны эх үүсвэрт холбогдсон үзүүлэлт маш өндөр (дунджаар 99.5 хувь), цахилгааны хангамжийн найдвартай байдлын үзүүлэлт харьцангуй сайн гэсэн үр дүн гарч байна.

Цахилгаан эрчим хүчний хангамж малчин өрхөд хүртээмжтэй байгаа эсэхийг судалж үзэхэд 2019 оны байдлаар нийт малчин өрхийн ойролцоогоор 81 хувь нь цахилгаан үүсгүүртэй болсон гэж “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-өөс мэдээлжээ. Энэ нь харьцангуй өндөр үзүүлэлт боловч малчин өрхүүдийн зарим нь цахилгаан эрчим хүч ашиглах боломжгүй хэвээр байгаа юм. Энэ үзүүлэлтийг аймгаар ангилан доорх графикт үзүүлэв.

График 5. Цахилгааны үүсгүүртэй малчин өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувь, 2019 он



Эх сурвалж: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс гаргасан Өрсөлдөх чадварын үзүүлэлт, дэлгэрэнгүйг дараах холбоосоос үзнэ үү: <http://aimagindex.mn/statistics>

Дээрх графикаас харахад, Дархан-Уул (68.9 хувь), Хэнтий (72.3 хувь), Баян-Өлгий (72.9 хувь) аймгуудын малчин өрхийн цахилгааны үүсгүүрт холбогдсон үзүүлэлт хамгийн бага байгаа бол Орхон (97.7 хувь), Сэлэнгэ (89.3 хувь), Сүхбаатар (87.9 хувь) аймгуудын малчин өрхийн цахилгааны эх үүсвэрт холбогдсон үзүүлэлт хамгийн өндөр харагдаж байна.

Цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай байдал

Эрчим хүчний найдвартай байдлыг (i) системийн цахилгаан тасалдлын дундаж хугацааны индекс, (ii) системийн тасалдлын дундаж тохиолдол, (iii) нэг хэрэглэгчид оногдох дундаж тасалдлын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлдог байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан эрчим хүчний салбарын 2019 оны статистик үзүүлэлтүүдээс харахад, цахилгаан хангамжийн найдвартай байдлын эдгээр үзүүлэлт нь манай улсад харьцангуй сайн байдаг ажээ. Үүнийг Хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. Монгол Улсын цахилгаан хангамжийн найдвартай байдлын үзүүлэлт

Бүс	2016 он			2017 он			2018 он			2019 он		
	Исаиди	Исаифи	Икайди	Исаиди	Исаифи	Икайди	Исаиди	Исаифи	Икайди	Исаиди	Исаифи	Икайди
Төвийн бүс	57	9	7	81	10	8	61	16	4	54	9	6
Баруун бүс	35	4	9	11	5	2	126	15	9	103	12	8
Алтай-Улиастайн	87	6	14	54	5	10	26	7	4	22	3	9
Зүүн бүс	3	1	7	4	1	5	3	1	5	10	2	6
Нэгдсэн дүн	54	8	7	73	8	9	62	15	4	54	9	6


Эх сурвалж: Эрчим хүчний яам, Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд, 51-р тал, дараах холбоосоор хандаж үзнэ үү: <http://admin.erc.gov.mn/uploads/files/statistic/statistic-uzuulelt-2019.pdf>

Дээрх хүснэгтээс үзэхэд, Системийн цахилгаан тасалдлын дундаж хугацааны индекс буюу SAIDI (*System Average Interruption Duration Index*) 2016 онд 54, 2017 онд 73, 2018 онд тус тус 62 цаг, харин 2019 онд 54 цаг байсан бол Системийн тасалдлын дундаж тохиолдол буюу SAIFI (*System Average Interruption Frequency Index*) 2016 онд 8, 2017 онд 8, 2018 онд 15 удаа тус бүр, 2019 онд 9 удаа тасарч байжээ. Харин нэг хэрэглэгчид оногдох дундаж тасалдлын хугацаа (CAIDI) 2016 онд 7, 2017 онд 9, 2018 онд 4, 2019 онд 6 цаг тус бүр байжээ. Эдгээр үзүүлэлтээр дүгнэх юм бол Зүүн бүсийн нэгдсэн сүлжээний найдвартай байдал сүүлийн 4 жилд тогтмол бага зэрэг буурсан ч Монгол Улсын хамгийн найдвартай цахилгаан түгээх сүлжээ хэвээр байна. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний найдвартай байдал сүүлийн 4 жилд бага зэрэг муудсан ч улсын хэмжээнд найдвартай байдал харьцангуй сайн байна. Алтай-Улиастайн нэгдсэн сүлжээний найдвартай байдал сүүлийн 4 жилд ерөнхийдөө сайжирсан ч улсын хэмжээнд найдвартай байдал харьцангуй сул байгаа бол Баруун бүсийн нэгдсэн сүлжээний найдвартай байдал сүүлийн 4 жилд тогтмол буурсан бөгөөд найдвартай байдлын хувьд ч хамгийн сул байна.

Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ

Монгол Улс нь нэг хүнд ногдох дотоодын эрчим хүчний хэрэглээгээрээ 2016 оны байдлаар 215 улсаас 101 дүгээрт жагссан нь дундаж үзүүлэлт юм.⁸⁴ Монгол Улсын хувьд нэг хүнд ногдох цахилгаан эрчим хүчний хэмжээ нь ерөнхийдөө нэмэгдэж ирсэн бөгөөд энэ үзүүлэлт нь 2005 оноос хойш 94.0 хувиар өсжээ. Үүнийг Зураг 1-д дүрслэн харуулав.

Зураг 1. Нэг хүнд ногдох дотоодын эрчим хүчний хэрэглээ (ГЖ/хүн), 2005-2016



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын Эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ, Хуудас 9, дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү. http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=LMDI_decomposition_analysis_of_energy-Mongolia.pdf&ln=Mn

Нэг хүнд оногдох эрчим хүчний хэрэглээ нь ихэнх тохиолдолд телевизээр теле-хичээл үзэхэд хангалттай байх боловч зөөврийн цахилгааны эх үүсвэртэй малчин өрхүүдийн хувьд цаг агаар, эх үүсвэрийн эвдрэл гэмтэл, цахилгаан үүсгүүрийн хүчдэлийн хэлбэлзэл зэргээс шалтгаалан теле-хичээл үзэхэд хангалтгүй хэмжээнд хүрэх тохиолдол гарахыг үгүйсгэх аргагүй. Энэ талаар тухайлан авч үзсэн судалгаа байхгүй боловч нэгэнт цахилгааны зөөврийн эх үүсвэр нь цахилгааны наад захын хэрэгцээг хангахад тохирсон байх ёстой тул зарим тохиолдолд л шаардлага хангахгүй буюу 50 хувиас доош үзүүлэлттэй байх боломжгүй гэж үзэж байна.

Түүнчлэн төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдох боломжгүй өрхүүд бага оврын нүүрс, хийн цахилгаан станц, нар, салхи, дизель-ус, дизель-салхи гэх мэт эрчим хүчний бусад эх үүсвэрээр бараг 100 хувь хангагдсан боловч эдгээр

⁸⁴ Our world in data, Per capita energy consumption, <https://ourworldindata.org/grapher/per-capita-energy-use?tab=table&time=2016..latest>

нь зарим орон нутагт шөнийн цагаар ажилладаггүй, өдрийн цагаар заримдаа эвдрэл гэмтлээс шалтгаалан тасалддаг, эсхүл хүчдэл хүрэхгүй болох зэрэг асуудал гардаг болохыг чанарын судалгаанд оролцогчид онцолж байсан. Иймд нэг хүнд оногдох эрчим хүчний хэрэглээ нь орон нутагт бүрэн хангалттай гэж үзэх боломжгүй тул “ер нь хангалттай буюу 75 хувь гэж дүгнэж байна.

Дэд бүлгийн дүгнэлт

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ боловсролын үйлчилгээний чанарт хэрхэн нөлөөлж болохыг төсөөлж гаргах зорилгоор цахилгаан эрчим хүчний хангамжийн хүртээмж, найдвартай байдал болон нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ гэсэн үндсэн гурван үзүүлэлтийг судлав. Энэ гурван үзүүлэлт нь зайн болон цахим хэлбэрээр сургалт явуулж байгаа нөхцөлд боловсролын чанарт нөлөөлөх хүчин зүйлс болно гэж таамагласан болно. Цахилгаан эрчим хүчний статистикийн мэдээг өрхөд суурилсан байдлаар гаргалаа. Харин эдгээр үзүүлэлтийн боловсролын үйлчилгээнд нөлөөлөх байдал нь нийслэл хотын орон сууцны өрх, нийслэлийн гэр хорооллын өрх, нийслэлээс бусад суурин газрын өрх, орон нутгийн малчин өрхөд өөр өөрөөр нөлөөлөхүйц байна.

Үзүүлэлт бүрээр тусгайлан авч үзвэл, Монгол Улсын хувьд цахилгаан эрчим хүчний хүртээмж дунджаар 99.5 хувь байгаа боловч малчин өрхүүдийн хувьд дунджаар 81 хувь нь цахилгааны эх үүсвэртэй байгаа нь өрхийн төрлөөс хамгийн бага үзүүлэлт байв. Дархан-Уул, Хэнтий, Баян-Өлгий аймгуудын малчин өрхүүдийн цахилгааны эх үүсвэрт холбогдсон үзүүлэлт хамгийн бага; Орхон, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудын малчин өрхүүдийн үзүүлэлт хамгийн өндөр хувьтай байгаа нь судалгаанаас харагдлаа.

Цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг авч үзэхэд, Зүүн бүсийн нэгдсэн сүлжээ Монгол Улсын хамгийн найдвартай, Төвийн бүсийнх харьцангуй сайн, Алтай-Улиастайнх харьцангуй сул байгаа бол Баруун бүсийнх хамгийн сул байна. Эрчим хүчний найдвартай байдлын үзүүлэлтээрээ манай улс ерөнхийдөө хангалттай сайн түвшинд байгаа боловч малчин өрхүүдийн зөөврийн цахилгаан үүсгүүрийн найдвартай байдлыг тодорхойлон дүгнэх боломжгүй байв.

Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээний үзүүлэлт ерөнхийдөө өсөж ирсэн боловч дэлхийн улс орнуудын дундаж хэмжээнд л байна. Үүнд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүдийн зөөврийн эх үүсвэр нь өрхийн хэрэглээнд хангалттай хэмжээний цахилгаан үйлдвэрлэж байгаа эсэхийн тодорхойгүй байдал нөлөөлсөн гэж үзэж байна.

Энэхүү дэд бүлгийн судалгааны дүнг Хүснэгт 13-т нэгтгэн харьцуулж харууллаа.

Хүснэгт 13. Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн зарим үзүүлэлт боловсролд нөлөөлөх таамаг (чанарын үр дүн)

№	Өрхийн төрөл	Эрчим хүчний хангамжийн хүртээмж	Эрчим хүчний хангамжийн найдвартай байдал	Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ
1	Нийслэл хотын орон сууцны өрхөд	Эрчим хүчээр хангагдаагүй өрхийн тоо нөлөөлнө	Ер нь хангалттай	Хангалттай
2	Нийслэлийн гэр хорооллын өрхөд	Эрчим хүчээр хангагдаагүй өрхийн тоо нөлөөлнө	Ер нь хангалттай	Хангалттай
3	Бусад хот, суурин газрын өрхөд	Эрчим хүчээр хангагдаагүй өрхийн тоо нөлөөлнө	Зүүн бүс хамгийн найдвартай бол баруун бүс хамгийн муу үзүүлэлттэй	Ер нь хангалттай
4	Малчин өрхөд	Зөөврийн цахилгааны эх үүсвэргүй өрхийн тоо нөлөөлнө	Ихэвчлэн зөөврийн эх үүсвэртэй тул найдвартай байдал муу	Тодорхойгүй

Эх сурвалж: Судлаач боловсруулсан

Дээрх хүснэгтийн зарим үзүүлэлтийг статистик мэдээллээс тоон хэлбэрээр дүгнэн гаргах боломжтой байгаа боловч цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ гэсэн үзүүлэлтүүдийг тоогоор илэрхийлэх боломжгүй байна. Гэвч эдгээрийг “Хангалттай” (100 хувь), “Ер нь хангалттай” (75 хувь), “Ер нь хангалтгүй” (50 хувь), “Хангалтгүй” (25 хувь) гэсэн дөрвөн шатлалаар ангилан хувьд шилжүүлж, тэнцүүлэн дүгнэх боломжтой гэж үзлээ. Ийнхүү тоон хэлбэрт шилжүүлсэн үр дүнг Хүснэгт 14-т харьцуулан харуулав.

Хүснэгт 14. Цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн зарим үзүүлэлт боловсролд нөлөөлөх таамаг (тоон үр дүн)

№	Өрхийн төрөл	Эрчим хүчний хангамжийн хүртээмж	Эрчим хүчний хангамжийн найдвартай байдал	Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ	Өрхийн төрөлд оногдох дундаж үзүүлэлт
1	Нийслэл хотын орон сууцны өрхөд	99.93	75	100	91.6
2	Нийслэлийн гэр хорооллын өрхөд	99.33	75	100	91.4
3	Бусад хот, суурин газрын өрхөд	98.82	75	75*	82.9
4	Малчин өрхөд	81	50**	50**	60.3
	Үзүүлэлтэд хамаарах дундаж дүн	94.8	68.8	81.3	

* Нийслэлээс бусад хот суурин газрын өрхүүдийн цахилгаанд холбогдсон байдал өндөр боловч бага оврын цахилгаан үүсгүүр, сэргээгдэх эрчим хүчний хөдөлгөөнт үүсгүүр ашиглах нь нийтлэг байгаа тул эрчим хүчний хангамжийн хүртээмж болон найдвартай байдал гэсэн үзүүлэлтүүд ер нь хангалттай буюу 75 хувь гэж үзсэн болно.

** Малчин өрхийн нэг хүнд оногдох эрчим хүчний хэрэглээг тодорхойлсон судалгаа байхгүй боловч нэгэнт цахилгааны зөөврийн эх үүсвэр нь хүний хэрэгцээг хангахад тохирсон байх ёстой тул зарим тохиолдолд шаардлага хангахгүй буюу 50 хувиас доош үзүүлэлттэй байх боломжгүй гэж үзсэн болно.

Ийнхүү тоон хэлбэрт хувирган харьцуулж үзвэл, нийслэл хотын орон сууцны болон гэр хорооллын өрхүүдийн эрчим хүчний хангамжийн хүртээмж бараг 100 хувь, эрчим хүчний хангамжийн найдвартай байдал “ер нь хангалттай” буюу 75 хувь, нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ хангалттай буюу 100 хувь байгаа бөгөөд өрхийн төрлийн аль алиных нь хувьд эрчим хүчний дундаж үзүүлэлт 91.5 хувь орчим байна. Нийслэл хотын үзүүлэлтэд цахилгаан эрчим хүчний эх үүсвэргүй 1,300 өрх онцгой нөлөө үзүүлэв. Тэрчлэн бага оврын цахилгаан үүсгүүр болон сэргээгдэх эрчим хүчний хөдөлгөөнт үүсгүүр ашиглаж байгаа 5,800 өрх тодорхой хэмжээнд нөлөөлөв.

Харин нийслэлээс бусад хот суурин газрын өрхүүдэд эрчим хүчний хангамжийн хүртээмж бараг 100 хувь буюу цахилгаанд холбогдсон өрхийн үзүүлэлт маш өндөр байгаа боловч эрчим хүчний хангамжийн найдвартай байдал болон нэг хүнд оногдох эрчим хүчний хэрэглээ тус бүр “ер нь хангалттай” буюу 75 хувь байна. Эрчим хүчний найдвартай байдал Зүүн болон Баруун бүсийн хувьд эрс ялгаатай байгаа нь хангалттай гэж үзэхгүй байх үндэслэл болж байна.

Түүнчлэн, төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдоогүй өрхүүд бага оврын нүүрс, хийн цахилгаан станц, нар, салхи, дизель-ус, дизель-салхи гэх мэт эрчим хүчний бусад эх үүсвэр ашиглаж байгаа бөгөөд эдгээр нь зарим орон нутагт шөнийн цагаар ажилладаггүй байна. Мөн өдрийн зарим цагт эвдрэл гэмтлээс шалтгаалан тасалддаг эсхүл хүчдэл хүрэхгүй болох зэрэг асуудал гардгийг чанарын судалгааны оролцогчид хэлж байсан тул “нэг хүнд оногдох эрчим хүчний хэрэглээ”-ний хувьд 100 хувь хангалттай гэж үзэх боломжгүй байлаа.

Малчин өрхүүдэд эрчим хүчний бүх үзүүлэлт хүчтэй нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна. Цахилгаан эрчим хүчинд холбогдсон өрхийн эзлэх хувь малчин өрхүүдийн 81, холбогдоогүй нь 19 орчим хувь байх боломжтой бөгөөд ихэвчлэн зөөврийн цахилгааны эх үүсвэртэй байх тул цахилгаан эрчим хүчний найдвартай байдал болон нэг хүн ногдох эрчим хүчний хэрэглээ гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох боломжгүй байна. Гэвч нэгэнт гар утас болон интернэт хэрэглэх бодит хэрэгцээ байгаа бөгөөд зөөврийн эрчим хүчний үүсгүүр нь хүний хэрэгцээг хангахад зориулан бүтээсэн тул эдгээр үзүүлэлт ер нь хангалтгүй буюу 50 хувиас доош байх боломжгүй гэж тооцоолсон болно.

Эдгээрээс дүгнэвэл, цахилгаан эрчим хүчний хүртээмж боловсролын үйлчилгээнд сөргөөр нөлөөлөх магадлал хамгийн бага буюу 5.2 хувь байна. Гэсэн хэдий ч малчин өрхүүдэд хамгийн их сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой. Цахилгаан хангамжийн найдвартай байдал ч малчин өрхүүдэд илүү нөлөөтэй бөгөөд бусад өрхийн бүлэгт бага зэрэг нөлөөлөхүйц байна. Нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ малчин өрхөөс бусад өрхөд бараг нөлөөлөхөөргүй гэж үзэж болно. Улмаар боловсролын үйлчилгээг ТВ болон цахимаар хүргэж байгаа нөхцөлд, ялангуяа энэ зохицуулалт нь тодорхой хугацааны туршид үргэлжлэх үед сурагч болон оюутан залуучуудын 5 гаруй хувьд цахилгаан эрчим хүчнээс үл хамаарах хэвлэмэл зэрэг арга хэлбэрээр сургалтыг хүргэх, тэр дундаа малчин өрхийн хүүхэд, залуусыг онцгой авч үзсэн арга хэмжээ шаардлагатай болохоор харагдаж байна. Малчин өрхийн хүүхэд, залуучуудын хувьд нийтлэгээр ТВ хичээл, цахим сургалтад бусдын адил хамрагдах нь үр дүнтэй байх тул цахилгаан эрчим хүч тасалдах магадлалыг тооцон, боломжтой цагтаа орж үзэх, татаж авах хувилбаруудыг нэвтрүүлснээр эрчим хүчний найдвартай бус байдлыг даван туулах боломж нээгдэх юм. Эдгээр арга хэмжээ нь мөн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй хот, хөдөөгийн өрхийн хүүхэд залуучууд, мөн цахилгааны найдвартай байдал нь доголдох магадлалтай бүс нутгийн хэрэглэгчдийг давхар анхаарсан арга хэлбэр болох буй за.

3.2 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц боловсролын үйлчилгээнд нөлөөлөх нь

БШУ-ны Сайд Л.Цэдэвсүрэн "Мэдээллийн технологийн хөгжил бүхнийг өөрчилж байна, ялангуяа хүнийг. Энэхүү өөрчлөлт нь боловсролын салбарт илүү нөлөөлж байгаа юм. Бага, дунд боловсролд нэгдсэн платформ байхгүйн улмаас бэрхшээл хүндрэл гарсан. Гэхдээ энэ нь чанарт нөлөөлөөгүй. Бүх сургууль цахимд холбогдсон ч хурд муу байгаа нь ажиглагдсан. Цаашид сургуулийн орчинд интернэтийн чанар, хурдыг сайжруулах шаардлага бий. Теле-хичээлийн зохион байгуулалтын үед багш нарт хоосон хана хараад хичээл заах нь хүнд байсан ч тэд маань богино хугацаанд хөрвөж, камертай ажиллаж сурлаа. Цаашид багш бэлтгэх хөтөлбөрт цахимаар хичээл заах агуулгыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Дээд боловсролын салбарт нэгдсэн платформ байхгүй тул сургууль бүр өөрийн дотоод сүлжээнд суурилан хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа. Цахим сургалтын бодлого, сургалт, эрх зүйн нээлттэй орчин байхгүй тул эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Цахим шилжилтээр олон улсын жишигт нийцсэн онлайн хичээл, контент боловсруулж, ашиглах шаардлага байна. Түүнчлэн, онлайн сургалтаар иргэдийн насан туршдаа суралцахыг ч дэмжих нь зүйтэй. Цахим боловсролын үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх, оролцогчдын хамтын ажиллагааг өргөтгөх шаардлагатай нь судалгааны явцад ажиглагдлаа. Хэдийгээр сургуулиудад мэдээллийн технологийн анги танхимууд бий ч энэ нь технологийн хөгжлийн хурдыг гүйцэхгүй байна" гэжээ.⁸⁵

Боловсролыг цахим хэлбэрээр хүргэхэд нэг талаас багш буюу сургагч, нөгөө талаас суралцагч интернэтэд холбогдсон, интернэт ашиглан суралцах шаардлага хангахуйц төхөөрөмжтэй, интернэтгүй үед харилцах арга хэрэгсэлтэй байх зэрэг нөхцөл хангагдсан байх шаардлагатай. Энэ бүлэгт юуны өмнө Монгол Улсын харилцаа холбооны салбарын өнөөгийн нөхцөл байдлыг ерөнхийд нь тодорхойлж, дараагийн хэсгүүдэд интернэтийн хүртээмж, интернэтэд холбогдоход шаардагдах төхөөрөмжийн хүртээмж, телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмжийг тус тус нарийвчлан судаллаа. Мөн гар утасны хэрэглээ нь харилцаа холбооны технологид багтах ч ерөнхий боловсрол болон дээд боловсролын бүх үзүүлэлтэд нөлөөлөх нийтлэг шинжтэй үзүүлэлт болох утгаар нь 3 дугаар бүлгийн 3.3 дахь дэд бүлэгт тусад нь судалж дүгнэсэн болно.

⁸⁵ Л.Цэдэвсүрэн: Багш бэлтгэх хөтөлбөрт цахимаар хичээл хэрхэн заах агуулгыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна, <https://ikon.mn/n/1yh0?fbclid=IwAR1-19qPNHXarXRouUkKZmsCureCAvz2Fh2Yrps-WVcfjyJGq4Ufsm4Odf9w>

Харилцаа холбооны салбарын өнөөгийн нөхцөл байдал

Бүлгийн танилцуулгад дурдсанчлан, боловсролын үйлчилгээг зайнаас хүргэж байгаа нөхцөлд гар утасны болон интернэтийн хэрэглээ, телевизийн олон сувгийн үйлчилгээ буюу кабелийн телевизийн хэрэглээ нь боловсролын үйлчилгээ, түүний чанарт нөлөөлнө гэж таамаглав. Эдгээр үзүүлэлтийг аль болох хамгийн сүүлийн үеийн мэдээлэл болох 2020 оны 7 дугаар сарын байдлаар ХХЗХ-оос нийтэд хүргэсэн харилцаа холбооны статистик мэдээлэлд үндэслэн боловсруулж гаргав. Энэхүү статистикийн эх сурвалжид үүрэн утас болон кабелийн телевиз хэрэглэгчдийг Хүснэгт 15-д заасан байдлаар тодорхойлжээ.


Хүснэгт 15. Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид болон кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо

Үзүүлэлт	2018 IV-VI	2019 IV-VI	2020 IV-VI
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мян.хүн	3,905.6	4,360.3	4,22.5
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид	861,268	891,624	900,728

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2020 оны эхний 7 сарын танилцуулга⁸⁶

Зураг 2. Судалгааны өмнөх 3 сард компьютер, гар утас, интернэт хэрэглэсэн 15-19 насны залуучуудын тоон мэдээлэл (хувь, хүйсээр, 2018 он)

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ



Эх сурвалж: 2018 оны цагаан ном, SIS2018

⁸⁶ Дэлгэрэнгүйг <http://www.nso.mn/content/2415#.X0H-3MgzbZs> холбоосоор үзнэ үү.

Улсын хэмжээнд 2020 оны 2 дугаар улиралд 3.8 сая интернэт хэрэглэгч бүртгэгдэж, үүнээс үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч 3.5 сая, гэрээт интернэт хэрэглэгч 347.8 мянга байжээ.⁸⁷

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2018 оны үзүүлэлтээс харахад Монгол Улсад үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 3,886,167-д, ухаалаг утас хэрэглэгчдийн тоо 2,439,236-д хүрч улс хоорондын интернэт багтаамж 120 Gbps, интернэт хэрэглэгчийн тоо 2,910,000 болжээ. Мөн Монгол Улсад 2019 оны 1 дүгээр сарын байдлаар фэйсбүүк идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2.2 сая, үүнээс гар утсаараа нийгмийн сүлжээнд холбогддог хэрэглэгч 2.1 сая байна.⁸⁸

ХХЗХ нь 2020 онд Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ)-аас баталсан *IDI index* тооцох аргачлалын дагуу Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлтүүдийг 21 аймаг болон бүс нутгаар гаргасан байна.⁸⁹ Энэхүү статистик үзүүлэлтүүдээ ерөнхий байдлаар нийтэлсэн боловч дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд хүртээмжтэй хэлбэрээр байршуулаагүй байв. Иймд энэхүү судалгааг гүйцэтгэсэн баг албан бичгээр харилцаа холбооны салбарын 2019 оны зарим статистик үзүүлэлтийг гаргуулан авч, уг судалгааны холбогдох хэсгүүдэд тусган олон нийтэд хүргэж байна.

Интернэтийн хүртээмж

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар интернэт хэрэглэдэг хүн амын 58.7 хувь нь байнга, 41.3 хувь нь шаардлагатай үедээ хэрэглэдэг бөгөөд хотод амьдарч буй хүн амын 72.4 хувь, орон нутагт амьдарч буй хүн амын 49.3 хувь нь интернэт хэрэглэдэг болжээ.⁹⁰ Харин Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүнгээс үзэхэд 6 болон түүнээс дээш настай хүн амын 64.7 хувь нь интернэт хэрэглэдэг болж, өмнөх тооллогоос 34.1 пунктээр өссөн бөгөөд интернэт хэрэглэдэг хүн амын 58.7 хувь нь байнга ашигладаг ажээ.⁹¹ Түүнчлэн 6 болон түүнээс дээш настай интернэт хэрэглэгчдийг аймаг,

⁸⁷ Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2020 оны эхний 7 сарын танилцуулга, <http://www.nso.mn/content/2415#.X0N-3MgzbZs>

⁸⁸ ХХМТГ-ын Нийгмийн сүлжээний бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ариунцэцэг. СУДАЛГАА: Манай улсын нэг иргэн сард дунджаар 5 сэтгэгдэл бичиж, 16 пост дээр like дарж, 3 пост share хийдэг, <https://ikon.mn/n/1jed>


⁸⁹ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны тайлан, <http://crc.gov.mn/contents/raw/5/14/1480/Report2019.pdf>

⁹⁰ Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn> ү.

⁹¹ Интернэтийн байнгын хэрэглэгчид гэж сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернэтийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийг ойлгоно гэж тайлбарлажээ.

нийслэлээр бүлэглэж харвал Архангай, Өвөрхангай, Увс аймагт хамгийн бага хувьтай, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймаг зэрэг хот суурин газрын интернэт хэрэглээ бусад аймагтай харьцуулахад 2 дахин их байна. Үүнийг График 6-д харуулав.


График 6. Зургаа болон түүнээс дээш настай хүн амд интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь, хот, орон нутгаар, 2010, 2020 он



Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү. <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn>

Интернэт хэрэглэгчдийг байршлаар нь авч үзвэл, хотын хүн амын 72.4, орон нутгийн хүн амын 49.3 хувь нь тус тус интернэт хэрэглэж байна. 2010 онтой харьцуулбал, орон нутгийн хүн амын интернэтийн хэрэглээ 42.5, хотын хүн амынх 30.7 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн 6, түүнээс дээш настай эмэгтэйчүүдийн 66.6, эрэгтэйчүүдийн 62.7 хувь нь тус тус интернэтийн хэрэглэгч байна. Насны бүлгээр харахад 6-9 нас, 70 ба түүнээс дээш насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их, харин бусад насны бүлгийн хувьд эмэгтэйчүүд их байгаа ажээ.

График 7. Зургаа болон түүнээс дээш настай хүн амын интернэтийн хэрэглээ, нас, хүйсийн суварга, 2010 болон 2020 он



Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн⁹²

Үүнээс үзэхэд боловсролын байгууллагаар үйлчлүүлдэг суралцагчид болох 6-24 насныхны дотроос 15-24 насны бүлэг нь интернэт хэрэглээгээрээ хамгийн өндөр байгаа нь сайн үзүүлэлт байлаа. Учир нь ерөнхий боловсролын 9-12 анги, их дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцагсад интернэтийн хэрэглээ өндөртэй байна.

Хүснэгт 16. Интернэт хэрэглээний 2018 болон 2019 оны статистик үзүүлэлт

Статистик үзүүлэлт	Аймаг	2018	2019
Интернэтийн байнгын хэрэглэгчид, мян.хүн	Улсын дүн	4,295.4	5,450.61
Суурин интернэт хэрэглэгчид, мян.хүн	Улсын дүн	306.2	303.2
3G хэрэглэгч, мян.хүн	Улсын дүн	2,439.4	3,190.6
LTE хэрэглэгч, мян.хүн	Улсын дүн	1,329.35	1,956.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан⁹³

⁹² <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn>

⁹³ http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_010V6&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1_T2_T3_T8_T4_T5_T6_T7&SOU_M_select_all=1&SOU_MSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019&viewtype=table

Хүснэгт 17. Интернет хэрэглэгчийн тоо, жилээр

Үзүүлэлт	2017	2018	2019
1 Интернет хэрэглэгчийн тоо	3,587.91	4,295.40	5,450.61

Эх сурвалж: http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1300_010V6

Интернет хэрэглэгчийн тоо 2017 онтой харьцуулахад 2019 онд 34.2 хувиар өсөж, суурин болон хөдөлгөөнт 3G, 4G хэрэглэгчдийн давхардсан тоогоор илэрхийлэгдсэн нийт интернет хэрэглэгчдийн тоо ийнхүү 5 саяас илүү гарсан гэж ХХЗХ-ны мэргэжилтэн тайлбарлаж байна. Интернетийн хэрэглээг энэхүү судалгаанд авч үзэхдээ гэрээт буюу суурин, хөдөлгөөнт интернет хэрэглэгч гэсэн хоёр дэд хэсэгт хуваан авч үзлээ.

Гэрээт буюу суурин интернет хэрэглэдэг айл өрхийн үзүүлэлт

Бэлэн байдлын зэрэгт шилжсэн өнөөгийн нөхцөлд суралцагчдын боловсролын үйлчилгээ авах нэг чухал эх сурвалж нь интернетийн сүлжээ бөгөөд үүний дотор гэрээсээ холбогдох боломжтой байх нь чухал үзүүлэлт юм. Иймд өнөөгийн нөхцөл байдалд суурин интернетийн хэрэглээ нь боловсролын үйлчилгээ авах чухал үзүүлэлт гэж үзэж байна.

Манай улсын нийт 897.4 мянган өрхийн 38.2 хувь нь гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдардаг. Хот, орон нутагт амьдарч буй өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байх ба хотод нийт өрхийн 74.5 хувь нь байшинд, 24.7 хувь нь гэрт амьдарч байна.⁹⁴ Улсын хэмжээнд суурин интернеттэй болон интернетгүй өрхийн тоо, тэдгээрийн эзлэх хувийг Хүснэгт 18-д харьцуулан харуулав.

⁹⁴ Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn>

Хүснэгт 18. Суурин интернэттэй, интернэтгүй өрхийн тоо, эзлэх хувь

№	Аймаг, хот	2019 он	Өрхийн тоо	Суурин интернэтгүй өрх, тоогоор	Интернэтгүй өрх/хувиар	Интернэттэй өрх/хувиар
1	Улаанбаатар	244,528.0	411,420.0	166,892.0	40.6	59.4
2	Завхан	794	20,713	19,919	96.2	3.83
3	Хөвсгөл	1,771	37,914	36,143	95.3	4.67
4	Архангай	1,342	27,055	25,713	95.0	4.96
5	Өвөрхангай	1,836	33,062	31,226	94.4	5.55
6	Хэнтий	1,376	23,906	22,530	94.2	5.76
7	Булган	1,122	18,481	17,359	93.9	6.07
8	Говь-Алтай	1,075	16,075	15,000	93.3	6.69
9	Сүхбаатар	1,204	17,725	16,521	93.2	6.79
10	Дундговь	1,081	14,212	13,131	92.4	7.61
11	Увс	1,660	21,646	19,986	92.3	7.67
12	Төв	2,103	27,043	24,940	92.2	7.78
13	Баянхонгор	2,303	25,570	23,267	91.0	9.01
14	Баян-Өлгий	2,227	24,327	22,100	90.8	9.15
15	Ховд	2,614	22,513	19,899	88.4	11.61
16	Өмнөговь	2,679	21,106	18,427	87.3	12.69
17	Сэлэнгэ	5,339	29,004	23,665	81.6	18.41
18	Дорнод	5,060	23,378	18,318	78.4	21.64
19	Дорноговь	6,135	20,115	13,980	69.5	30.50
20	Говьсүмбэр	1,840	4,979	3,139	63.0	36.96
21	Дархан -Уул	13,914	28,797	14,883	51.7	48.32
22	Орхон	15,314	28,386	13,072	46.1	53.95
	Аймгууд нийт	72,789	486,007	413,218	85.0	14.98
	НИЙТ	317,317.0	897,427.0	580,110.0	64.6	35.4

Эх сурвалж: Судалгааны багт ХХЗХ-оос 2020 онд албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

Дээр хүснэгтээс харахад, Улаанбаатар хотын нийт өрхийн 59.4 хувь нь, аймаг орон нутагт амьдарч байгаа өрхийн 3.83-53.95 хувь нь суурин интернэтэд холбогджээ. Интернэтэд холбогдсон аймгуудын өрхийн дундаж үзүүлэлт 15 орчим хувь байгаа бол аймгуудаас Орхон (53.95 хувь), Дархан-Уул (48.32 хувь) аймгууд хамгийн олон өрхийг суурин интернэтэд холбосон байгаа бол Завхан (3.83 хувь), Хөвсгөл (4.67 хувь) аймгуудад суурин ийм төрлийн үйлчилгээнд холбогдсон өрхийн тоо хамгийн бага байна.

Шигтгээ 4. Архангай аймгийн төв, Цэцэрлэг хотын төлөөллийн яриа

Манайх 3 хүүхэдтэй, хоёр хүүхэд сургуульд сурдаг. Хоёр том нь 5 болон 7 дугаар анги, бага нь гэртээ байдаг. Теле-хичээлийг дүүд нь гол төлөв үзүүлдэг. Эгч нь утасны датагаар econtent.mn хаягт хандаж хааяа үздэг. Утсаар хичээл үзэх нь хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж ойлгож байгаа ч хоцрогдолд оруулахгүйн тулд үзүүлдэг. Манай аймгийн төвийн хуучин байранд интернэт болон телевизийн олон сувгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал зарим айл цахилгаан холбооны кабел тавиулсан байдаг. Шинээр баригдсан байранд юнивишн ордог. Хүүхдийнхээ хичээлийг бүрэн үзүүлэх боломж нь айл бүрт харилцан адилгүй байгаа.

Эцэг, эхийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын судалгааны хэсгээс...2020.07.09

Хөдөлгөөнт интернэт хэрэглэгчийн тоо

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн энэ цаг үед гар утас, интернэт нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээ болжээ. Суралцагчид боловсролын үйлчилгээ авахдаа хөдөлгөөнт интернэт ашиглах өргөн боломжтой болж, ялангуяа дээд боловсролын байгууллагад суралцагчдын хөдөлгөөнт интернэтийг ашиглах хэрэгцээ илүү байна.

Манай улсын хувьд 6 болон түүнээс дээш насны хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэгч, 64.7 хувь нь интернэт хэрэглэгч болсон бөгөөд 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад гар утас хэрэглэгчийн тоо 13.8 пунктээр, интернэт хэрэглэгчийн тоо 34.1 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.⁹⁵

⁹⁵ Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn>

Хүснэгт 19. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо

№	Аймаг, хот	mobile	3G	LTE	Хүн амын тоо
		2019 он	2019 он	2019 он	2019 он
1	Улаанбаатар	2,326,354	1,980,440	1,209,186	1,539,810
2	Архангай	97,237	44,674	28,178	94,994
3	Баян-Өлгий	91,968	47,372	31,971	108,530
4	Баянхонгор	97,657	52,019	35,795	88,672
5	Булган	61,619	33,581	19,599	62,089
6	Говь-Алтай	76,690	36,849	21,839	57,748
7	Говьсүмбэр	23,421	15,436	10,826	17,928
8	Дархан-Уул	117,686	81,174	56,016	107,018
9	Дорноговь	117,627	86,241	45,276	71,014
10	Дорнод	97,545	55,513	42,106	82,054
11	Дундговь	56,641	28,874	18,429	47,104
12	Завхан	94,014	46,450	21,463	72,823
13	Орхон	120,836	81,877	54,226	107,634
14	Өвөрхангай	117,656	66,070	38,474	116,732
15	Өмнөговь	154,267	94,664	74,982	69,187
16	Сүхбаатар	80,958	48,876	22,033	63,182
17	Сэлэнгэ	120,049	80,599	49,052	110,110
18	Төв	118,184	75,768	46,663	94,250
19	Увс	85,855	49,191	25,652	83,223
20	Ховд	95,689	48,939	33,811	89,712
21	Хөвсгөл	158,817	73,409	44,870	135,095
22	Хэнтий	108,149	62,579	26,353	77,957
	Нийт	4,418,919	3,190,595	1,956,800	3,296,866

Эх сурвалж: Судалгааны багт ХХЗХ-оос 2020 онд албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

Хэдийгээр энэхүү статистикт 3G болон LTE сүлжээний хэрэглэгчдийг давхардсан тоогоор авсан боловч зарим дүгнэлт гаргах боломжтой гэж үзсэн болно. Хүснэгт 19-өөс харахад, Баян-Өлгий аймаг 108,530 хүнтэй хэр нь 3G болон LTE сүлжээний хэрэглэгчдийн тоо нийлээд 91,968 байгаа нь хөдөлгөөнт интернэт хэрэглэдэггүй 16,562 хүн байгааг илтгэж байгаа бөгөөд улмаар хөдөлгөөнт интернэт хэрэглэх үзүүлэлтээрээ уг аймаг хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Түүнчлэн, Булган аймаг нь 62,089 хүнтэй ч хөдөлгөөнт интернэт хэрэглэгчдийн тоо нь нийт оршин суугчдын тоонд хүрэхгүй (61,619) байгаа үзүүлэлтээрээ хөдөлгөөнт интернэтийн хэрэглээ харьцангуй бага гэж дүгнэхэд хүргэлээ.

Харин Улаанбаатар хотын хөдөлгөөнт интернэт хэрэглэгчдийн тоо оршин суугчдаасаа 51.1 хувиар илүү байгаа бол энэ үзүүлэлт Өмнөговь аймагт хүн амаасаа 123.0 хувиар, Дорноговь аймагт 65.6 хувиар тус тус илүү байгаа нь хөдөлгөөнт интернэтийн хэрэглээ эдгээр аймагт маш өндөр байгааг харуулж байна. Эдгээр аймагт хөдөлгөөнт интернэт ашиглах байдал өндөр байгаа нь түр оршин суугчид олонтой, хүн амын дамжин өнгөрөх хөдөлгөөн их байгаатай шууд холбоотой байх магадлалтай.

Интернэт хэрэглэгчдийн тоог 3G болон LTE сүлжээний хэрэглэгчдийг давхардуулахгүй оновчтой тооцоолж, орон нутгаар ялгаж гаргасан судалгаа байхгүй байгаа нь энэхүү судалгааны хүрээнд илүү нарийвчилсан шинжилгээ хийхэд тулгарсан бэрхшээлтэй асуудлын нэг байлаа. Мөн ХХЗХ-оос 2020 оны хагас жилийн дүнг гаргаагүй байсан тул өмнөх буюу 2019 оны эцсийн тоон мэдээллийг ашиглан тандалтын үр дүнг гаргасныг анхаарна уу.

Дэд бүлгийн дүгнэлт

Интернэтийн хүртээмжийг суурин болон хөдөлгөөнт интернэтийн хувьд ялгаатай авч үзэн энэхүү дэд бүлэгт дурдсан статистик мэдээллийн дагуу дүгнэвэл, суурин интернэтэд хамрагдсан байдал нийслэл хотод 59.4 хувь, аймгуудад дунджаар 15 хувь байна. Нийслэлийн гэр хорооллын өрхөд суурин интернэтийн хүртээмж ямар байгааг тодорхойлох боломжгүй боловч өмнө дурдсан хоёр үзүүлэлтийн дунджаар дүгнэх боломжтой бөгөөд үүнд малчин өрхүүдэд суурин интернэт хүртээмжгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Харин хөдөлгөөнт интернэтийн хувьд Монгол Улсын газар нутагт өөр өөр үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нэвтрэн бүрэн хамруулсан гэж үзсэн тул хөдөлгөөнт интернэтэд хамрагдсан байдлыг 100 хувь гэж үзлээ. Энэхүү хэсгийн холбогдох үзүүлэлтүүдийг Хүснэгт 20-д харьцуулан харуулав.

Хүснэгт 20. Суурин болон хөдөлгөөнт интернэт ашиглах боломж, өрхийн төрлөөр

	Хөдөлгөөнт интернэт		Хөдөлгөөнт интернэт	Дундаж боломж, хувь
	Хамрагдаагүй, хувь	Хамрагдсан, хувь	Хамрагдсан, хувь	
Улсын дүн	64.6	35.4	100	67.7
Нийслэл хотын орон сууцны өрхөд	40.6	59.44	100	79.7
Нийслэлийн гэр хорооллын өрхөд	62.8*	37.21*	100	68.6
Бусад хот, суурин газрын өрхөд	85.0	14.98	100	57.5
Малчин өрхөд	0	0	100	50.0

Эх сурвалж: Судлаач боловсруулсан

* Тайлбар: Нийслэлийн гэр хорооллын өрхүүдийн суурин интернэтийн хүртээмжийг тодорхойлох боломжгүй тул нийслэл хотын орон сууцны өрхүүдийн хамрагдалтын хувь болон бусад хот, суурин газрын өрхүүдийн хамрагдалтын хувийн дунджаар тус үзүүлэлтийг тооцсон болно.

Интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж

Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн 2019 онд хамаарах өгөгдлөөс үзэхэд Монгол Улсад интернэтийн үйлчилгээ үзүүлэгч 64 байгууллага, 338 интернэт кафе байгаа бол 1,000 хүнд оногдох компьютерын тоо 208, нийт компьютерын тоо 663,883 байна. Үүнийг Хүснэгт 21-д харуулав.

Хүснэгт 21. Интернэтийн үйлчилгээ, компьютерын тоо, 2018 болон 2019 он

Статистик үзүүлэлт	Аймаг	2018	2019
Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, улсын дүнгээр	Улсын дүн	72	64
Интернэт кафе, улсын дүнгээр	Улсын дүн	497	338
Компьютерын тоо, улсын дүнгээр	Улсын дүн	639,427	663,883
1000 хүнд ногдох компьютер, улсын дүнгээр	Улсын дүн	202	208

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан⁹⁶

⁹⁶ http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_010V6&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T1_T2_T3_T8_T4_T5_T6_T7&SOUM_select_all=1&SOUMSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019&viewtype=table

Компьютер

Манай улсад 1,000 хүнд оногдох компьютерын тоо жил ирэх тусам нэмэгдэж ирсэн бөгөөд 2019 оны байдлаар энэ үзүүлэлт 208 болсон бөгөөд 16 хүнд дунджаар нэг компьютер оногдож байна.

Хүснэгт 22. 1,000 хүнд ногдох компьютерын улсын дүн, оноор

Статистик үзүүлэлт	Аймаг	2016	2017	2018	2019
1,000 хүнд ногдох компьютер, улсын дүнгээр	Улсын дүн	197	199	202	208

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Интернет хэрэглэгч ба компьютерын тоо, жилээр⁹⁷

Нийт компьютерын тоо 2017 онтой харьцуулахад 2019 онд 7 хувиар өссөн болохыг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 23. Компьютерын тоо, жилээр

Үзүүлэлт	2017	2018	2019
Компьютерын тоо	617,703.	639,427.	663,883.

Эх сурвалж: http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1300_010V6

Нэг хүнд оногдох компьютерын тоог орон нутгаар ангилсан судалгаа бараг байхгүй байгаа бөгөөд зөвхөн Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар компьютертой өрхийн тоо 52.2 хувь байсан гэж Нийслэлийн статистикийн газрын мэдээнд дурдаж байжээ. Тодруулбал, нийслэлийн нийт өрхийн 202.2 мянга (52.2 хувь) нь гэртээ компьютертой бөгөөд эдгээр өрхийн 134.3 мянга (66.4 хувь) нь нийтийн зориулалттай орон сууцанд, 22.2 мянга орчим (11.0 хувь) нь монгол гэрт амьдарч байжээ.⁹⁸

Уг судалгаанд зориулж ХХЗХ-оос гаргуулж авсан статистик мэдээг дүүргээр ялгаагүй тул Нийслэлийн статистикийн газрын албан ёсны вэб хуудаснаас боломжит хамгийн сүүлийн буюу 2018 оны өрхийн мэдээллийг⁹⁹ авч шалгахад

⁹⁷ https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_010V6&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T7&SOU_M_select_all=1&SOUMSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019_2018_2017_2016&viewtype=table

⁹⁸ Нийслэлийн Статистикийн газар, Монгол Улсын нийслэлийн эдийн засаг нийгмийн байдал 2018, 124 дүгээр хуудас, http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=22._ulaanbaatar.pdf&ln=Mn

⁹⁹ Нийслэлийн Статистикийн газар, Мэдээллийн технологи- Гэртээ компьютертой өрхийн тоо, 2018 он, <http://www.ubstat.mn/horoo/detail.aspx?TableID=4c8e65ed-d442-4905-a021-8159f4bcde95&year=2018&view=table>

компьютертой өрхийн тоо нь 386,363 буюу нийт өрхийн тоотой яг тэнцүү байсан тул алдаатай дүн гэж тооцоод энэхүү мэдээллийг оруулаагүй болно. Харин Нийслэлийн статистикийн газрын “Монгол Улсын нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал 2018” тайланд дурдсан мэдээллийг Нийслэлийн статистикийн газрын албан ёсны вэб хуудас дахь 2018 оны өрхийн тоотой харьцуулан шалгахад 2018 онд Улаанбаатар хотод компьютертой өрхийн тоо 202,219 (52.2 хувь) байсан гэсэн үзүүлэлт ерөнхийдөө таарч байгаа бөгөөд харьцуулсан үр дүнг Хүснэгт 24-т харуулав.

Хүснэгт 24. Нийслэлийн компьютертой өрхийн тоо, эзлэх хувь, 2018 он

Дүүрэг	Өрхийн тоо	Компьютертой өрхийн тоо	Компьютертой өрхийн эзлэх хувь (%)
Багануур	8,530	2,763	32.4
Багахангай	1,271	285	22.4
Баянгол	59,469	44,600	75.0
Баянзүрх	95,140	50,711	53.3
Налайх	10,603	2,734	25.8
Сонгинохайрхан	84,151	35,635	42.3
Сүхбаатар	38,477	20,762	54.0
Хан-Уул	48,880	28,650	58.6
Чингэлтэй	39,842	16,079	40.4
Нийт дүн	86,363	202,219	52.3

Эх сурвалж: Судлаач боловсруулсан

Дээрх хүснэгтээс харахад нийслэлд гэртээ компьютертой өрхийн эзлэх хувь Баянгол дүүрэгт хамгийн өндөр (75.0 хувь), Хан-Уул (58.6 хувь) болон Сүхбаатар (54.0 хувь) дүүргүүдэд харьцангуй өндөр, Багахангай (22.4 хувь), Налайх (25.8 хувь) дүүргүүдэд хамгийн бага байна. Харин гэртээ компьютергүй өрхийн тоо нийслэлийн хэмжээнд 184,144 байгаагаас Баянзүрх (44,429 өрх буюу нийслэлийн нийт өрхийн 24.1 хувь), Сонгинохайрхан (48,516 өрх буюу нийслэлийн нийт өрхийн 26.4 хувь) дүүргүүдэд хамгийн олон байгаа нь ажиглагдлаа.

Зөөврийн компьютер

Боловсролын үйлчилгээг цахимжуулах, багш нарын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 3,287 ширхэг зөөврийн компьютерыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БШУЯ-аас багш нарт олгохоор болж “2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажил, анхаарах асуудал” сэдэвт сургалт семинарт оролцсон 21 аймаг, 9 дүүргийн Боловсрол соёл урлагийн газар, Боловсролын хэлтсийн дарга нарт зөөврийн компьютероос эхэлж гардуулсан. Яамны зүгээс багш нарыг компьютероор хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөн, эхний ээлжид ерөнхий боловсролын 658 сургуулийн 1,098 багш, 885 цэцэрлэгийн 2,189 багшид компьютер олгох ажээ.¹⁰⁰ Багшийн зэрэгцээ боловсролын үйлчилгээний хэрэглэгч болох суралцагчдын интернэт ашиглах төхөөрөмжийн хэрэгцээг хангах талаар арга хэмжээ төлөвлөж байгаа эсэх нь одоогоор тодорхойгүй байна.


Боловсролын байгууллагаас хэрэгжүүлсэн суралцагчдын мэдээлэл харилцааны технологи эзэмшиж байгаа байдлыг тодорхойлсон судалгаа мөн л олдсонгүй. Ялангуяа ЕБС-ийн сурагчдын компьютер эзэмшиж, зөөврийн болон суурин компьютер ашиглаж байгаа байдлыг тандан судалсан зүйл байхгүй тул цаашид энэ нөхцөл байдлыг тодруулан судлах шаардлагатай.

Харин их, дээд сургуулийн суралцагчдын талаар хийсэн судалгаа байна. 2014 онд МУБИС-ийн Биеийн тамирын сургууль (БТС)-ийн оюутнуудын интернэт ашиглан суралцах боломжийг тодорхойлох судалгаа хийгдсэн байх бөгөөд оюутнуудын ихэнх нь ямар нэгэн компьютертой ба интернэт кафе болон сургууль, гэрээс интернэтэд холбогдох бүрэн боломжтой гэж дүгнэжээ. БТС-ийн оюутнуудын 75 хувь нь зөөврийн болон суурин компьютертой байна.¹⁰¹ Гэвч оюутнуудын хувьд үлдсэн 25 орчим хувь нь хувийн компьютергүй байгаа бөгөөд тэд гар утсаараа хичээлээ үзэх, судалгаа хийх, судалгааны тайлан бэлтгэж илгээх шаардлагатай тулгардаг байж мэдэхээр байна. Судалгааны дүнг График 8-д харуулав.

¹⁰⁰ Эхний ээлжийн 3,287 багшид олгох зөөврийн компьютерийг орон нутагт хүлээлгэн өглөө <https://www.facebook.com/MinistryofEdu/posts/771931916969258>

¹⁰¹ БТС-ийн оюутнуудын мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний судалгаа, <https://prezi.com/vrgvfgxtafu7/presentation/>

График 8. МУБИС-ын БТС-ийн оюутнуудын мэдээлэл харилцааны технологийн олдоц



Эх сурвалж: <https://prezi.com/vrgvfgxtafu7/presentation/>

Дээрх графикаас үзэхэд, ялангуяа 1 дүгээр курсийн оюутнууд зөөврийн компьютер ашиглах нь бага, компьютергүй оюутнуудын компьютер эзэмших байдал анги ахих тусам нэмэгдэж (дунджаар 11.4 хувь), үүний дотор зөөврийн компьютер ашиглах байдал илүү нэмэгдсэн (дунджаар 15.1 хувиар) нь ажиглагдаж байна. Уг судалгаа нь зөвхөн МУБИС-ын БТС-ийн оюутнуудыг хамарсан боловч оюутнуудын компьютер эзэмшилтийг судалсан өөр судалгаа олдоогүй тул улсын хэмжээнд энэ байдал нийтлэг байгаа гэж үзсэн болохыг анхаарна уу.

Цаашид хөл хорио цуцлагдахгүй, одоогийн нөхцөл байдал үргэлжилбэл Монгол Улсын хэмжээнд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа ерөнхий боловсролын 640.4 мянга, дээд боловсролын 148.4 мянган суралцагч буюу нийт 788.8 мянга орчим суралцагчаас хэдэд нь зөөврийн компьютер ашиглах шаардлагатай, үүнээс хэд нь төхөөрөмжөөр хангагдсан болохыг судлан тогтоох хэрэгтэй байна. Ерөнхий боловсрол болон дээд боловсролын байгууллагад суралцагчдын тоог Хүснэгт 23-т харуулав.

Хүснэгт 25. Ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургууль, коллежид суралцагчид (бүс, аймаг, нийслэлээр, 2019 он)

Аймаг	Суурь боловсрол (мянган суралцагч)	Дээд боловсрол (мянган суралцагч)
УЛСЫН ДҮН	640.4	148.4
Баруун бүс	88.1	3.5
Баян-Өлгий	23.8	0.2
Говь-Алтай	11.7	0.4
Завхан	15.2	0.3
Увс	18	0.1
Ховд	19.4	2.5
Хангайн бүс	117.4	3.0
Архангай	18.2	1.1
Баянхонгор	17.5	0.1
Булган	10.7	0.0
Өвөрхангай	21.6	0.0
Хөвсгөл	27.9	0.1
Орхон	21.5	1.8
Төвийн бүс	98.1	4.4
Дорноговь	14	0.1
Дундговь	8.4	0.0
Өмнөговь	13.4	0.0
Сэлэнгэ	20.3	0.0
Төв	16.5	0.0
Дархан-Уул	21.7	4.3
Говьсүмбэр	3.8	0.0
Зүүн бүс	44.1	1.2
Дорнод	16.6	1.2
Сүхбаатар	12.3	0.0
Хэнтий	15.2	0.0
Улаанбаатар	292.4	136.4
БНСУ дахь монгол сургууль	0.3	0.0

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

Интернэтэд хандаж байгаа төхөөрөмжийн тоог улсын хэмжээнд гар утас хэрэглэгчийн болон улсын компьютерын тооны нийлбэртэй ойролцоо байна гэж үзвэл, Монгол Улсын гар утас хэрэглэгчдийн тоо 2020 онд 2,484,183 байсан¹⁰² бөгөөд компьютерын тоо 2019 онд 663,883 байсан тул интернэтэд хандаж байгаа төхөөрөмжийн тоо ойролцоогоор 3,148,066 (2,484,183+663,883=3,148,066) орчим байсан гэж тооцоолов. Үүнээс интернэтэд холбогдох төхөөрөмжийн тоо нь улсын хүн амын тоо (3,296,866)-той ойролцоо буюу хангалттай гэж дүгнэж болох боловч боловсролын үйлчилгээ авч байгаа 6-24 насны хүн амын хэрэглээг ялгаж харах боломжгүй байгаа ба тэдний дундах төхөөрөмжийн төрөл,

¹⁰² 3.3 Гар утасны хэрэглээ гэсэн дараагийн дэд бүлгээс дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

хүрэлцээг илүү тодорхой судлах шаардлагатай байна. Түүнчлэн интернэтэд холбогдох төхөөрөмжийн дийлэнх хувь нь гар утас байгааг анхаарч, гар утаснаас теле-хичээл, интернэтэд байршуулсан бусад контентыг үзэх нь ЕБС-ийн сурагчдад хэр үр дүнтэй, ямар нөлөөтэй болохыг мөн их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн хичээлийг гар утаснаас уншиж судлах, тодорхой сэдвээр судалгаа хийх, судалгааны тайлан бэлтгэж багшдаа илгээх боломжтой эсэх зэрэг асуудлыг цаашид судлах шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдын компьютерын болон гар утасны хэрэглээ, их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцагчдын гар утсаар хичээл хийх боломж зэрэг зарим статистик тодорхойгүй байгаа тул зөвхөн интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмжийг “Ер нь хангалттай” буюу 75 хувь гэж дүгнэв.

Телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд, 2018 онд телевизортой өрхийн тоо нийслэлд 386.3 мянга (99.7 хувь) байсан бөгөөд тэдгээр өрхийн 88.5 хувь нь нэг телевизортой ажээ. Телевизортой өрхийн 29.2 хувь нь хувийн байшинд, 44.8 хувь нь нийтийн зориулалттай орон сууцанд, 25.9 хувь (99.9 мянган өрх) нь монгол гэрт амьдарч байна. 2018 оны статистикаар нийслэлийн малчин өрхийн 70.3 хувь нь телевизортой байжээ.¹⁰³ Телевизортой өрхийн тоог аймаг, нийслэлээр 2018 оноос хойш гаргасан эх сурвалж олдоогүй бөгөөд энэхүү судалгааны хүрээнд телевизийн олон сувгийн үйлчилгээ авч байгаа өрх бүгд телевизортой гэж үзсэн болно. Мөн боловсролын үйлчилгээг телевизээр авахад буюу теле-хичээлийг үзэхэд телевизийн олон сувгийн үйлчилгээ заавал шаардлагатай гэж үзсэн болно.

Уг судалгаанд зориулж ХХЗХ-оос албан бичгээр авсан мэдээллээр, 2019 оны байдлаар телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо Улаанбаатар хотод нийт өрхийн тооноос 15 хувиар, Орхон аймагт өрхийн тооноос 2.8 хувиар тус тус илүү байгаа бөгөөд энэ нь уг үйлчилгээг тухайн орон нутгийн албан байгууллагууд ашиглаж байгаатай холбоотой юм. Харин Баян-Өлгий аймагт олон сувгийн үйлчилгээний хэрэглэгчийн тоо нь нийт өрхийн 41.5 хувь, Өвөрхангай аймагт нийт өрхийн 48.2 хувь, Булган аймагт нийт өрхийн 53.4 хувь байх боломжтой байгаа нь телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж хамгийн хязгаарлагдмал аймгууд юм.

¹⁰³ Нийслэлийн Статистикийн газар, Монгол Улсын нийслэлийн эдийн засаг нийгмийн байдал 2018, http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=22._ulaanbaatar.pdf&ln=Mn

Хүснэгт 26. Телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж
(аймаг, нийслэл, 2019 он)

№	Аймаг, хот	Catv MMDS	Бага оврын сансрын холбооны систем			Өрхийн тоо	Хэрэглэгчийн эзлэх хувь
			Vsat	IPTV	НИЙТ		
1	УЛААНБААТАР ХОТ	136,214	141,289	195,644	473,147	411,420	115.00
2	АЙМГУУД үүнээс:	40,263	203,451	55,212	298,926	486,007	61.51
2.1	Баян-Өлгий	6,467	2,829	796	10,092	24,327	41.5
2.2	Өвөрхангай	1,094	13,492	1,352	15,938	33,062	48.2
2.3	Булган	410	9,004	447	9,861	18,481	53.4
2.4	Баянхонгор	282	11,732	1,746	13,760	25,570	53.8
2.5	Ховд	1,593	8,499	2,220	12,312	22,513	54.7
2.6	Сэлэнгэ	572	11,774	3,762	16,108	29,004	55.5
2.7	Архангай	1,804	12,396	1,035	15,235	27,055	56.3
2.8	Дорнод	1,920	7,511	3,910	13,341	23,378	57.1
2.9	Хөвсгөл	3,364	17,372	909	21,645	37,914	57.1
2.1	Төв	1,005	13,224	1,309	15,538	27,043	57.5
2.11	Хэнтий	1,557	11,542	893	13,992	23,906	58.5
2.12	Дундговь	146	7,949	610	8,705	14,212	61.3
2.13	Увс	3,683	8,337	1,278	13,298	21,646	61.4
2.14	Сүхбаатар	208	10,001	986	11,195	17,725	63.2
2.15	Говь-Алтай	1,000	8,609	693	10,302	16,075	64.1
2.16	Завхан	1,982	11,705	490	14,177	20,713	68.4
2.17	Өмнөговь	-	12,575	2,033	14,608	21,106	69.2
2.18	Дархан -Уул	2,867	5,656	11,540	20,063	28,797	69.7
2.19	Дорноговь	700	9,153	5,121	14,974	20,115	74.4
2.20	Говьсүмбэр	742	2,085	1,387	4,214	4,979	84.6
2.21	Орхон	8,867	7,611	12,695	29,173	28,386	102.8

Телевизийн олон сувгийн үйлчилгээний төрлүүдээс зөвхөн IPTV үйлчилгээ нь хөтөлбөрийг нөхөн үзэх боломж олгодог бөгөөд ЕБС-д сурдаг хүүхэдтэй өрхүүд теле-хичээл нөхөн үзэх боломж Улаанбаатар хотод 47.6 хувь, орон нутагт дунджаар 11.4 хувь байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Аймгуудын IPTV үйлчилгээнд холбогдсон үзүүлэлтийг дараах байдлаар бүлэглэж харах боломжтой бөгөөд үүнд:

- 5 хувиас доош үзүүлэлттэй 10 аймаг (Завхан 2.4, Хөвсгөл 2.4, Булган 2.4, Баян-Өлгий 3.3, Хэнтий 3.7, Архангай 3.8, Өвөрхангай 4.1, Дундговь 4.3, Говь-Алтай 4.3, Төв аймаг 4.8 хувь тус бүр)

- 5-10 хүртэл хувьтай 5 аймаг (Сүхбаатар 5.6, Увс 5.9, Баянхонгор 6.8, Өмнөговь 9.6, Ховд 9.9 хувь тус бүр)
- өндөр үзүүлэлттэй 3 аймаг (Орхон 44.7, Дархан-Уул 40.1, Говьсүмбэр 27.9 хувь тус бүр) байна.

Үүнээс дүгнэхэд, Улаанбаатар хотод телевизийн олон суваг ашиглах боломж 100 хувь, IPTV ашиглах боломж 47.6 хувь, орон нутагт телевизийн олон суваг ашиглах боломж дунджаар 61.5 хувь, IPTV ашиглах боломж дунджаар 11.4 хувь байна. Малчин өрхүүдийн хувьд телевизийн олон суваг ашиглах боломж нь тухайн орон нутгийн өрхүүдтэй адил гэж тооцвол телевизийн олон суваг ашиглах боломж дунджаар 61.5 хувь, IPTV ашиглах боломж дунджаар 11.4 хувь байх боломжтой гэж тооцлоо.

Гар утасны хэрэглээ боловсролын үйлчилгээнд нөлөөлөх нь

Монгол Улс нь 2016 оны байдлаар нийт газар нутгийн 91.3 хувийг гар утасны сүлжээнд хамруулсан байжээ.¹⁰⁴ Харин 2020 онд гар утас хэрэглэгчийн тоо хүн амын тоог давсан бөгөөд үйлчилгээ үзүүлэгч хэд хэдэн байгууллагын сүлжээгээр улсаа бүрэн хангасан гэж үзэж болохоор байна. Монгол Улсын ХАОСТ-ын дүнгээс үзэхэд 6 болон түүнээс дээш насны хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэж байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид улсын хэмжээнд 2020 оны 2 дугаар улиралд 4.4 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 62.3 (1.4 хувь) мянгаар өссөн байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид Улаанбаатар хотод 57.8 мянга (2.7 хувь), Төв аймагт 8.2 мянга (6.5 хувь), Завхан аймагт 6.0 мянга (5.9 хувь), Хэнтий аймагт 5.8 мянга (5.1 хувь), Хөвсгөл аймагт 5.7 мянгаар (3.4 хувь) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.¹⁰⁵

¹⁰⁴ Global economy, Mobile network coverage - Country rankings, https://www.theglobaleconomy.com/rankings/Mobile_network_coverage/#Mongolia

¹⁰⁵ Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2020 оны эхний 7 сарын танилцуулга, <http://www.nso.mn/content/2415#.X0H-3MgzbZs>

Хүснэгт 27. Гар утас хэрэглэдэг хүн ам (насны бүлэг, хүйс, хувиар, 2010, 2020 он)

Насны бүлэг	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	76.0	72.2	75.9	87.8	86.5	88.9
6-9	22.6	20.7	26.6	37.2	35.6	39.1
10-14	51.5	67.2	55.9	76.7	73.3	76.2
15-19	81.6	77.2	86.1	96.6	95.9	97.2
20-26	88.0	85.9	90.3	98.1	97.7	98.5
25-29	85.9	85.3	86.5	98.2	97.9	98.5
30-36	85.1	86.6	85.8	98.3	98.0	98.5
35-39	86.6	83.3	85.5	97.7	97.2	98.2
60-66	81.8	80.1	83.6	97.5	96.9	98.0
65-69	79.8	77.6	81.9	97.0	96.2	97.7
50-56	77.7	75.6	79.5	96.3	95.0	97.6
55-59	75.5	73.8	77.0	95.8	96.6	96.9
60-66	73.5	73.3	73.7	95.2	93.9	96.3
65-69	65.6	66.6	66.6	96.0	92.7	95.0
70+	66.0	50.7	62.8	81.8	83.0	81.1

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн¹⁰⁶

ХАОСТ-ын тайланд гар утас хэрэглэгчийн тоог дурдаагүй зөвхөн хувиар илэрхийлсэн байх тул энэхүү хувийг ҮСХ-ноос гаргасан хүн амын насны бүлгээр ангилсан тоотой харьцуулан гар утас хэрэглэдэг хүн амын тоог ойролцоо дүнгээр гаргаж Хүснэгт 28-д харуулав.

¹⁰⁶ Дэлгэрэнгүйг <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn> холбоосоос үзнэ үү.

Хүснэгт 28. Монгол Улсын гар утас хэрэглэгчийн тоо, 2020 он (ойролцоо дүнгээр*)

Насны бүлэг	Гар утас хэрэглэдэг хувь, 2020 он, насны бүлгээр (C)	Гар утас хэрэглэдэг хүн амын тоо (B) ($B=C \cdot D/100$)	2020 оны хүн амын тоо, насны бүлгээр (D)
6-9 нас	37.2	108,324	291,193*
10-14 нас	74.7	208,636	279,299
15-19 нас	96.6	215,493	223,078
20-24 нас	98.1	235,052	239,604
25-29 нас	98.2	272,399	277,392
30-34 нас	98.3	299,548	304,728
35-39 нас	97.7	245,895	251,684
40-44 нас	97.5	218,586	224,191
45-49 нас	97	192,178	198,122
50-54 нас	96.3	159,518	165,647
55-59 нас	95.8	136,418	142,399
60-64 нас	95.2	91,804	96,433
65-69 нас	94	51,962	55,279
70 ба түүнээс дээш нас	81.8	65,699	80,317
Нийт	87.8	2,484,183	2,829,366

Эх сурвалж: Судлаач боловсруулав.

Тайлбар 1: ҮСХ-ны 1212.mn вэбсайтаас Монгол Улсын иргэдийг насны бүлгээр ангилсан мэдээллийг авч, 2020 оны ХАОСТ-ын дүнгээс гар утас хэрэглэгчдийн насны бүлгээр ангилан хувиар харуулсан дүнтэй харьцуулан гар утас хэрэглэгчдийн тоог тооцоолсон болно.

Тайлбар 2: ҮСХ-ны 1212.mn вэбсайтаас авсан тоогоор Монгол Улсын иргэдээс 6 настай 80,272, 7 настай 75,012, 8 настай 71,201, 9 настай 64,708 иргэн байх тул 6-9 настай иргэдийн тоог эдгээрийн нийлбэрээр буюу 291,193 гэж тооцоолсон болно.


Энэхүү үр дүнг нягтлах зорилгоор судалгааны эх сурвалжуудад хандахад "ММСГ" компанийн 2017 оны судалгаагаар Монгол Улсын 15-60 насны хүн амын 99.6 хувь буюу 2.1 сая иргэн гар утас ашигладаг¹⁰⁷ гэсэн тооцоо гарсантай ойролцоо байгаа тул бодит байдалд нийцсэн гэж үзэж байна.

¹⁰⁷ Bloomberg TV Mongolia, дэлгэрэнгүй <http://bloombergtv.mn> холбоосоор үзнэ үү.

Хүснэгт 28-аас гар утасны хэрэглээг насаар нь ангилж харвал 6-9 насныхны 37.2, 10-14 насныхны 74.7, 15-19 насныхны 96.6, 20-24 насныхны 98.1 хувь нь тус тус гар утас хэрэглэж байгаа нь насны ангилал өсөх тусам гар утас хэрэглэх хувь нэмэгдэж байгааг харуулж байна. Гэвч гар утасны хэрэглээний хэдэн хувийг боловсролын үйл ажиллагаанд ашиглаж байгааг тооцоолсон судалгаа олдоогүй болно.

Гар утас хэрэглэгчдийг байршлаар нь авч үзвэл төв, суурин газрын хүн амын 90.2 хувь, орон нутгийн хүн амын 82.9 хувь нь гар утасны хэрэглэгч байна. Хүн амын гар утасны хэрэглээ 2010 оны тооллогоор төв, суурин газарт орон нутгаас 28.6 пунктээр илүү байсан бол 2020 онд уг зөрүү багасаж 7.3 пункт болжээ. Энэ нь техник технологийн хөгжлийн хурдацтай өсөлт болон орчин үеийн харилцаа холбооны техник, технологи харьцангуй богино хугацаанд өргөн нэвтэрч, суурьшил хоорондын ялгааг багасгах нөлөө үзүүлж байгаатай холбоотой болно.

График 9. Зургаа болон түүнээс дээш настай хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь (хот, орон нутгаар, 2010 болон 2020 он)




Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны Улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, хуудас 130¹⁰⁸

¹⁰⁸ Дэлгэрэнгүйг <https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Census2020-Main-report%208.06.pdf&ln=Mn> холбоосоор үзнэ үү.

Сургуулийн орчинд нийгмийн сүлжээ, ухаалаг утас хэрэгтэй эсэх талаар 16-18 насны 109 сурагч, мөн 64 багш, 54 эцэг, эхтэй ярилцлага хийхэд судалгаанд оролцогчдын 92.3 хувь нь ухаалаг утастай байв. “Ухаалаг утас ашиглах нь чамд ямар хэрэгтэй вэ?” гэсэн асуултад фэйсбүүк, инстаграмд орох, кино болон видео үзэх, тоглоом тоглох зорилгоор гар утсаа ашигладаг гэжээ (График 10-ыг харна уу.).

График 10. Сургуулийн орчин дахь ухаалаг утасны хэрэглээ



Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо¹⁰⁹

Зарим сурагч сургуулийн орчинд ухаалаг утас хориглох шийдвэрийг дэмжихгүй байна. Ухаалаг утас нь нийгмийн сүлжээ ашиглах боломжийг нээж байгаа бөгөөд эцэг, эх хүүхдээ саатуулах зорилгоор биш хүүхдийн хөгжилд нөлөөлөх программууд суулгаж өгөх хэрэгтэй гэж судлаачид зөвлөжээ.¹¹⁰ Нийгмийн сүлжээг хяналтгүй ашиглах боломжийн хажуугаар гар утас байнга хэрэглэхтэй холбоотой өөр нэг эрсдэл байгаа нь эрүүл мэндэд үзүүлэх хортой нөлөө юм. Гар утас нь хүний биед сөрөг нөлөө үзүүлдэг талаар цөөнгүй судалгаа байгаагаас хавдрын эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай.¹¹¹

¹⁰⁹ Харилцаа холбооны зохицуулах хороо, “Сургуулийн орчинд ухаалаг гар утас хэрэгтэй юу” судалгаа. <http://www.happywebs.mn/blog/post/surguulijn-orchind-uhaalag-gar-utas-heregtej-yuu-sudalgaa>

¹¹⁰ Харилцаа холбооны зохицуулах хороо, “Сургуулийн орчинд ухаалаг гар утас хэрэгтэй юу” судалгаа. <http://www.happywebs.mn/blog/post/surguulijn-orchind-uhaalag-gar-utas-heregtej-yuu-sudalgaa>

¹¹¹ Гар утас хүүхдэд ямар хор нөлөөтэй вэ?, <http://www.buuvei.mn>

Дэд бүлгийн дүгнэлт

Манай улсад суурин интернэтийн үйлчилгээнд нийт өрхийн 35.4 хувь нь хамрагдсан бол суурин интернэтэд хамрагдаагүй өрхийн тоо үүнээс 2 дахин их буюу 64.6 хувь байна. Суурин интернэтийн үйлчилгээний хүртээмж нь хот, орон нутгаар ялгаатай, тэгш бус байгаа бөгөөд суурин интернэтэд нийслэлийн өрхүүдийн 59.4 хувь, аймаг орон нутгийн өрхүүдийн 15 хувь нь хамрагджээ. Гэхдээ энэ нь интернэтийн үйлчилгээний нийт хүртээмжийн үзүүлэлт биш бөгөөд учир нь хөдөлгөөнт интернэт хэрэглэгчийн тоо манай нийт хүн амын тооноос давсан байна. Гэвч зарим орон нутагт интернэтийн хурд муу, цахилгаан тасалдах зэрэг нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байх магадлалтай.

Интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай боловч эдгээр төхөөрөмжийн дийлэнх хувийг гар утас эзэлж байна. Интернэтэд холбогдох төхөөрөмжийн ерөнхий тоо нь улсын нийт хүн амын тоотой ойролцоо боловч боловсролын үйлчилгээ авч байгаа 6-24 насны хүн амын хэрэглэж байгаа төхөөрөмжийн төрөл, хүрэлцээг илүү тодорхой судлах шаардлагатай.

Телевизийн олон сувгийн үйлчилгээ нь теле-хичээл үзэхэд чухал үүрэгтэй гэж үзэх юм бол Улаанбаатар хотод телевизийн олон суваг ашиглах боломж 100 хувь, IPTV ашиглах боломж 47.6 хувь, орон нутаг орон нутагт телевизийн олон суваг ашиглах боломж дунджаар 61.5 хувь, IPTV ашиглах боломж дунджаар 11.4 хувь байна.

Гар утасны хэрэглээний хувьд 2016 онд л Монгол Улс нь нийт газар нутгийнхаа 91.3 хувийг гар утасны сүлжээнд хамруулсан бөгөөд 6 болон түүнээс дээш насны хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэж байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчдийн тоо хүн амын тоог давсан бөгөөд гар утсыг ихэвчлэн харилцаа холбооны зорилгоор ашигладаг. Сургуулийн орчинд нийгмийн сүлжээ ашиглах нь сөрөг үр дагавартай гэж үзэн, гар утас хэрэглэхийг хориглоод байгаа. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд зайн сургалтад шилжээд байгаа өнөөгийн нөхцөл байдалтай холбоотойгоор дүгнэх юм бол, ерөнхий боловсролын болон дээд боловсролын үйлчилгээг гар утас ашиглан бүрэн дүүрэн авах боломжгүй нь энэхүү судалгаанаас ажиглагдлаа. Бага насны хүүхдэд гар утас ашиглуулах нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, нийгмийн харилцааны чадварт сөрөг нөлөөтэй байгаа талаар судалгаанд оролцогчид дурдаж байсан болно.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Дэд бүтцийн хүртээмж нь боловсролын үйлчилгээний хүртээмжид тодорхой хэмжээний нөлөө үзүүлнэ. Ялангуяа коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал шиг хол хорио, сургууль хаах шаардлагыг бий болгосон гамшгийн нөхцөл байдалд танхимын сургалтыг алсын зайнаас зохион байгуулахад дэд бүтцийн хүртээмж, найдвартай хангамж нь сургалтыг тасалдуулахгүй байх үндсэн нэг нөхцөл болох юм. Дэд бүтцийн хүртээмжийг үнэлж дүгнэхдээ дээд боловсролын үйлчилгээ, ерөнхий боловсролын үйлчилгээ гэж ялгаж үзэх нь зүйтэй. Ерөнхий боловсрол болон дээд боловсролын үйлчилгээнд хамааралтай үзүүлэлтүүдийг оноогоор дүгнэн, доорх хүснэгтэд харьцуулан харууллаа.

Ерөнхий боловсролын үйлчилгээнд дэд бүтцийн хөгжил нөлөөлөх нь

Алсын зайн хэлбэрээр хэрэгжиж байгаа ерөнхий боловсролын үйлчилгээг теле-хичээл үзэх, www.econtent.edu.mn-ээс интернэтэд байршуулсан хичээл үзэх, гэрийн даалгавар авах, шалгуулах боломж гэсэн үндсэн гурван үйл ажиллагаанд хуваан авч үзсэн юм.

Нийслэлийн орон сууцны өрхүүд, мөн нийслэлийн гэр хорооллын өрхүүдийн теле-хичээл үзэх боломж ижилхэн сайн түвшинд (84.8 хувь) байгаа бол нийслэлээс бусад хот, суурин газрын өрхүүдийн энэ боломж 20 орчим хувиар бага (64 хувь) байгаа нь телевизийн олон сувгийн үйлчилгээ авах боломж тааруу (61.5 хувь), IPTV үзэх боломж маш бага (11.4 хувь) байгаатай холбоотой. Малчин өрхүүдийн хувьд теле-хичээл үзэх боломж хамгийн бага (58.3 хувь) байгаа нь мөн л телевизийн олон сувгийн үйлчилгээ болон IPTV үзэх боломж хязгаарлагдмал байгаагийн дээр цахилгаан эрчим хүчний чанар, хүртээмж хангалттай байж чаддаггүйтэй холбоотой. ОБЕГ-ын даргын 2020 оны А/94 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн БСШУСЯ-аас өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн теле болон цахим хичээлийн талаарх товч тайлан мэдээлэлд теле-хичээлд хамрагдсан байдлыг Улаанбаатарт 88.4 хувь, аймгуудын дундаж 75 хувь, улсын хэмжээнд теле-хичээлд хамрагдалт 74.7 хувь гэж дүгнэжээ. Энэхүү судалгаагаар айл өрхүүдийн теле-хичээл үзэх боломж Улаанбаатар хотод 84.8 хувь, хөдөө орон нутагт дунджаар 61.2 хувь, улсын хэмжээнд дунджаар 73.0 хувь гэж тооцоолж байгаатай харьцуулахад Ажлын хэсэг нь уг үзүүлэлтийг 84.8 хувь гэж харьцангуй өндөр хувиар дүгнэсэн байх ажээ. Мөн теле-хичээлийн үр дүнг хэрхэн хянаж, ямар аргачлалаар дүгнэснийг Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газраас ирүүлсэн мэдээний нэгтгэлээс дүгнэх боломжгүй байгаа тул боловсролын газрын мэдээллийг үндэслэл муутай гэж үзэж болохоор байна.

Econtent.edu.mn сан нь ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурах бичгүүдийг унших, татаж авах боломж олгохоос гадна СӨБ, ЕБС-ийн теле-хичээлүүдийг үзэх боломжтой аппликейшн бөгөөд хичээлийг онлайнаар шууд үзэх, сурах бичиг татан оффлайн горимд унших, хөгжмийн хичээлийн дуунуудыг аудио хэлбэрээр сонсох давуу талтай.¹¹² Өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр сурагчдад зориулсан теле-хичээлийг илүү хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор БСШУСЯ болон ХХМТГ-аас салбарын үүрэн холбооны оператор компаниудад өгсөн чиглэлийн дагуу www.econtent.edu.mn цахим сайтад байрласан цэцэрлэг, ЕБС-ийн теле-хичээлийг 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн гар утаснаас үнэ төлбөргүй үзэх боломжтой¹¹³ болжээ.

www.econtent.edu.mn-ээс интернэтэд байршуулсан хичээл үзэх боломж нийслэлийн орон сууцны өрхүүдэд хамгийн өндөр (86.6) байгаа бол нийслэлийн гэр хорооллын өрхүүдэд интернэтийн хүртээмж орон сууцны өрхүүдийнхээс харьцангуй бага байгаагаас шалтгаалан 83.8 хувийн боломжтойгоор хоёрдугаарт жагслаа. Нийслэлээс бусад хот, суурин газрын өрхүүдийн интернэтийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний чанар нийслэлийнхээс муу байгаагаас www.econtent.edu.mn-ээс хичээл үзэх боломж 78.9 хувь байгаа бол малчин өрхүүдийн зарим нь интернэтэд холбогдох боломжгүй, цахилгаан эрчим хүчний чанар муу зэргээс шалтгаалан 71.3 хувийн боломжтой гэж үнэлэгдэж байна.

Үүний зэрэгцээ www.econtent.edu.mn вэбсайтын андройд үйлдлийн системтэй гар утсанд зориулсан Econtent аппликэйшний хувилбар нь “Сервистэй холбогдоход алдаа гарлаа”, “*Error. Not Working*” зэрэг алдаа гарч ажиллахгүй байх нь элбэг бөгөөд судлаачид туршиж үзэхэд зарим тохиолдолд мөн л алдаа илэрхийлж байв. Түүнчлэн, тухайн аппликэйшний талаар үлдээсэн сэтгэгдлүүдийг судалж үзэхэд орж болохгүй байна, хичээл дутуу байна, цаг тухайд нь хичээлээ оруулахгүй байна, монгол бичгийн фонт таарахгүй байна гэсэн дутагдлыг дурдсан байгааг анхаарах нь зүйтэй юм. *Apple Store* дахь IOS үйлдлийн системд зориулсан аппликэйшний талаар эерэг сэтгэгдэл тун ховор, хэрэглэхэд хэцүү байна, гар утасны дэлгэцийг хэвтээ байдлаар ашиглах үед зураас гарч байгаа нь хэцүү байна зэрэг сэтгэгдэл бичсэн байв. Econtent аппликэйшний *Google Play* дэх үнэлгээ нь 5 онооноос 4 оноо буюу 80 орчим хувиар үнэлэгдсэн бол *Apple Store* дахь үнэлгээ нь 5 онооноос 2.7 оноо буюу 54 орчим хувиар үнэлэгдсэн байна.

¹¹² Google Play, Econtent аппликэйшний хуудас, дэлгэрэнгүйг <https://play.google.com/store/apps/details?id=esis.econtent> холбоосоор үзнэ үү.

¹¹³ ХХМТГ-ын албан ёсны вэбсайт, дэлгэрэнгүйг <https://www.cita.gov.mn/12604.html> холбоосоор үзнэ үү.

Гэрийн даалгавар авах, шалгуулах боломжийг үнэлэхдээ уг судалгаа нь зам тээврийн дэд бүтцийн хөгжлийг дүгнэснээрээ онцлогтой. Гэрийн даалгавар өгөх, шалгахдаа багш нь суралцагчийнд очих, эсхүл сурагчдыг хуваарийн дагуу дуудан уулзах арга хэлбэрээр ажиллаж байсан ба энэ тохиолдолд ирэх, очих зам тээврийн дэд бүтэц нь чухал үзүүлэлт болох юм. Ерөнхийдөө хот, суурин газруудад зам тээврийн дэд бүтэц нь нэгэн ижил “ер нь хангалттай” үнэлгээтэй байх бол хот суурин газраас дийлэнхдээ алслагдмал амьдрах магадлалтай малчин өрхийн хувьд зам тээврийн дэд бүтэц “ер нь хангалтгүй” гэсэн үнэлгээтэй байна. Ийнхүү дүгнэхэд, нийслэлийн орон сууцны өрхөд гэрийн даалгавар авах, шалгуулах боломж 85.2 хувь, нийслэлийн гэр хорооллын өрхүүдэд 83.5 хувь, нийслэлээс бусад хот, суурин газруудад интернэтийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний чанараас шалтгаалан энэ боломж 78.1 хувь, харин малчин өрхүүдэд багштайгаа гар утсаар ярихаас бусад дэд бүтцийн хөгжил ерөнхийдөө муу тул 67.1 хувийн боломжтой гэж дүгнэж байна.

Боловсролын үйлчилгээнд цахилгаан эрчим хүч болон мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн нөлөөлөх байдлыг ерөнхийд нь дүгнэвэл, дээд боловсролын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж улсын хэмжээнд дунджаар 80.1 хувь байгаа бол ерөнхий боловсролын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж дунджаар 77.0 хувь байна. Улсын хэмжээнд боловсролын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж ерөнхийдөө 78.6 хувь байна. Дэд бүтцийн хөгжил малчин өрхүүдэд илүү сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд орон нутгийн суурин газарт ч IPTV үзэх боломж маш бага (11.4 хувь), суурин интернэтийн хүртээмж муу байгаа нь боловсролын үйлчилгээнд сөргөөр нөлөөлж байна. Мөн малчин өрхийн хүүхдүүд нь цахилгаан эрчим хүчний чанар хүртээмж муутай, багштайгаа биечлэн уулзах боломж тааруу байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдлаа.

Дээд боловсролын үйлчилгээнд дэд бүтцийн хөгжил нөлөөлөх нь

Дээд боловсролын хувьд сургалтын шинэ орчин, цахим технологийг ашиглаж эхэлснээр ихэнх оюутны бие даан суралцах чадавх нэмэгдэж их, дээд сургуулийн удирдлагын мэдээллийн системийн ашиглалт сайжирсан байна. Тулгарсан сорилтыг даван туулж, бага өртгөөр чанартай, хүртээмжтэй боловсрол олгох нэг арга зам бол нээлттэй боловсрол, онлайн сургалт гэдгийг онцолж байлаа. Гэхдээ цахим шилжилтийн бэлэн байдлын үнэлгээг хийж үзэхэд манай улсын 100 хүнд 113 гар утас ногдож, иргэдийн 70 хувь нь интернэтийн үйлчилгээ худалдан авах чадвартай байгаа ч суурин интернэтэд холбогдсон байдал нийслэлд 38, орон нутагт 7 хувьтай байгаа нь хүссэн үр дүнд хүрэхээргүй

байгааг харуулж байна. Тиймээс мэдээлэл, технологийн салбарын хөгжлийг дэмжих, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж зарим төлөөлөл үзэж байна.¹¹⁴

Энэхүү судалгааны хүрээнд дээд боловсролын үйлчилгээнд дэд бүтцийн нөлөөлөх үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо интернэтийн болон интернэт ашиглах төхөөрөмжийн хүртээмж, цахилгаан эрчим хүчний хүртээмж, гар утасны хэрэглээ гэсэн дөрвөн үзүүлэлт нөлөөлнө гэж таамагласан болно. Энэ таамаглалын дагуу үнэлж үзэхэд нийслэлийн орон сууцны өрхүүдийн хувьд интернэтийн хүртээмж болон интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай гэж үнэлж болохоор байна. Мөн цахилгаан эрчим хүчний чанар болон гар утасны хэрэглээ хангалттай бөгөөд эдгээр өрхийн хувьд дээд боловсролын үйлчилгээг цахимаар авах боломж дунджаар 86.6 хувь байна. Нийслэлийн гэр хорооллын өрхүүдэд интернэтийн хүртээмж харьцангуй өндөр, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай, цахилгаан эрчим хүчний чанар болон гар утасны хэрэглээ хангалттай бөгөөд дээд боловсролын үйлчилгээг цахимаар авах боломж дунджаар 83.8 хувь гэж тооцоолж байна. Нийслэлээс бусад суурин газрын өрхүүдэд интернэтийн хүртээмж харьцангуй муу буюу 57.5 хувь, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай боловч цахилгаан эрчим хүчний хэрэглээ харьцангуй муу буюу 82.9 хувь, гар утасны хэрэглээ хангалттай бөгөөд эдгээр өрхийн хувьд дээд боловсролын үйлчилгээг цахимаар авах боломж дунджаар 78.9 хувь байна. Малчин өрхүүдийн хувьд интернэтийн хүртээмж хамгийн бага буюу 50 хувь, цахилгаан эрчим хүчний чанар мөн л хамгийн муу буюу 60.3 хувь байгаагаас шалтгаалан дээд боловсролын үйлчилгээг цахимаар авах боломж дунджаар 71.3 хувь байна гэж дүгнэлээ.

Энэхүү бүлгийг нэгтгэн дүгнэвэл, интернэтийн хүртээмж манай улсад дунджаар 64 хувь, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай буюу 75 хувь байх боловч гар утасны хэрэглээ давамгайл нөлөөлсөн, цахилгаан эрчим хүчний чанар дунджаар 81.6 хувь, гар утасны хэрэглээ нийт өрхүүдэд 100 хувь байгаа бөгөөд дээд боловсролын үйлчилгээг алсын зайнаас цахимаар авах боломж улсын дунджаар 80.1 хувь байна. Гэхдээ энэ дүгнэлтэд гар утасны өргөн хэрэглээ хүчтэй нөлөөлсөн бөгөөд гар утсаар цахим боловсролын чанартай үйлчилгээ авч болох эсэх нь асуулт хэвээр үлдлээ.

¹¹⁴ БСШУСЯ, хичээл эхлүүлэхэд анхаарах асуудлын талаар зөвлөмж, чиглэл өглөө. <https://www.facebook.com/ministryofedu/posts/771931916969258>

Хүснэгт 29. Боловсролын үйлчилгээнд цахилгаан эрчим хүчний болон мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц нөлөөлөх байдал

№	Боловсролын үйлчилгээний төрөл	Д/д	Дэд үзүүлэлтүүд	УБ-ын орон сууцны өрх	УБ-ын гэр хорооллын өрх	Бусад хот, суурин газрын өрх	Малчин өрхөд	Өрхүүдийн дундаж
1	Дээд боловсролын үйлчилгээ	1.1	Интернэтийн хүртээмж	79.7	68.6	57.5	50	64.0
		1.2	Төхөөрөмжийн хүртээмж	75	75	75	75	75.0
		1.3	Цахилгаан эрчим хүчний чанар	91.6	91.4	82.9	60.3	81.6
		1.4	Гар утасны хэрэглээ	100	100	100	100	100.0
		Дээд боловсролын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж			86.6	83.8	78.9	71.3
2	Суурь боловсролын үйлчилгээ							
2.1	Теле-хичээл үзэх боломж	2.1.1	Телевизийн олон сувгийн үйлчилгээний хүртээмж	100	100	61.5	61.5	80.8
			2.1.2	IP TV үзэх боломж	47.6	47.6	11.4	11.4
		2.1.3	Цахилгаан эрчим хүчний чанар	91.6	91.4	82.9	60.3	81.6
		2.1.4	Гар утасны хэрэглээ	100	100	100	100	100.0
		Теле-хичээл үзэх боломж			84.8	84.8	64.0	58.3

Интернэтэд байрлуулсан хичээл үзэх боломж	2.2.1	Интернэтийн хүртээмж	79.7	68.6	57.5	50	64.0
	2.2.2	Төхөөрөмжийн хүртээмж	75	75	75	75	75.0
	2.2.3	Цахилгаан эрчим хүчний чанар	91.6	91.4	82.9	60.3	81.6
	2.2.4	Гар утасны хэрэглээ	100	100	100	100	100.0
	Econtent үзэх боломж		86.6	83.8	78.9	71.3	80.1
Гэрийн даалгавар авах, шалгуулах боломж	2.3.1	Интернэтийн хүртээмж	79.7	68.6	57.5	50	64.0
	2.3.2	Төхөөрөмжийн хүртээмж	75	75	75	75	75.0
	2.3.3	Цахилгаан эрчим хүчний чанар	91.6	91.4	82.9	60.3	81.6
	2.3.4	Гар утасны хэрэглээ	100	100	100	100	100.0
	2.3.5	Замын тээврийн дэд бүтэц	75	75	75	50	68.8
Гэрийн даалгавар авах, шалгуулах боломж			84.3	82.0	78.1	67.1	77.9
Ерөнхий боловсролын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж			85.2	83.5	73.6	65.6	77.0

Эх сурвалж: Судлаач боловсруулсан

Тайлбар 1. Интернэтэд холбогдоход шаардагдах төхөөрөмжийн хүртээмж хангалттай гэсэн дүн гарсан боловч гар утас ихэнх хувийг бүрдүүлж байв. Зарим насны бүлгийн төхөөрөмж эзэмших, ашиглах боломж хязгаарлагдмал зэрэг үндэслэлээр энэ төхөөрөмжийн хүртээмжийг "Ер нь хангалттай" буюу 75 хувь гэж үзсэн.

Тайлбар 2. Гар утасны хэрэглээ насны зарим бүлэгт хязгаарлагдмал боловч шаардлагатай тохиолдолд өрхийн бусад гишүүнээс авч хэрэглэх боломжтой тул хэрэглээний түвшнийг 100 хувь гэж үзсэн.

Нийслэлийн гэр хорооллын өрхүүдийн хувьд интернэтийн хүртээмж харьцангуй өндөр боловч орон сууцны өрхийнхөөс доогуур, мөн интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ерөнхийдөө хангалттай байна. Цахилгаан эрчим хүчний чанар болон гар утасны хэрэглээ хангалттай бөгөөд эдгээр өрхийн хувьд дээд боловсролын үйлчилгээг цахимаар авах дэд бүтцийн боломж дунджаар 83.8 хувь байна гэж тооцоолов. Гэхдээ мөн л гар утасны хэрэглээ нь сургалтын чанартай хэрхэн холбогдож байгааг үнэлээгүй болно.

Нийслэлээс бусад хот, суурин газрын өрхүүдэд интернэтийн хүртээмж ойролцоогоор 57.5 хувь буюу нэлээд доогуур байгаа бөгөөд гар утас хэрэглэх боломж хангалттай, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай боловч цахилгаан эрчим хүчний чанар, хүртээмж харьцангуй муу байна.

Малчин өрхүүд дийлэнхдээ хөдөлгөөнт интернэт ашиглаж байгаа тул интернэтийн хүртээмж ер нь хангалтгүй, гар утасны хэрэглээ сайн, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ерөнхийдөө хангалттай гэж үзэж болох боловч цахилгаан эрчим хүчний чанар, хүртээмжийн хувьд бусад төрлийн өрхүүдээс хамгийн муу байгаа юм.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 7-д заасан Сурч боловсрох эрхийг баталгаатай эдлүүлэх чиглэлээр үүсээд буй онцгой нөхцөл байдлын үед төрөөс боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн ажил үйлчилгээг нэгдсэн байдлаар дүгнэн хүргэж байна.

Монгол Улс Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх арга хэмжээг 2020 оны 1 дүгээр сарын сүүлээс авч хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай" хуулийг 4 дүгээр сарын 29-ний өдөр батлан мөрдөж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон үед боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх арга хэмжээг төрөөс хоёр үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд үүнд 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хууль батлан гарахаас өмнө УОК-ийн шийдвэрээр ЗГ, БСШУСЯ түүний харьяа байгууллагууд тухай бүрт нь тогтоол, тушаал, удирдамж, заавар батлан ажиллаж ирсэн бол хууль батлагдсаны дараах эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтөөр төрийн болон бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг зааглаж өгснөөр хэрэгжүүлэх, харьяалах ажлын зорилго, чиглэл тодорхой болж хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарал хандуулан ажиллах болсон нь тайланд судлагдсан материалаар үнэлэгдэж байна.

Боловсролын салбарын хувьд УОК-ын шийдвэрээр бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс мөн оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаагаар хязгаарлан, хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрхийг хангах үүднээс зайн сургалтад шилжсэн. Үүнтэй холбоотойгоор сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын сургалтыг теле болон цахим хэлбэрээр, их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн сургалтыг цахим хэлбэрээр тус тус зохион байгуулжээ. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай" хууль батлахаас өмнө бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар хойшлуулах шийдвэрийг ЗГ-аас 3 удаа гаргасан бөгөөд тухайн цаг хугацаанд хамаарах үйл ажиллагааг БСШУСЯ, түүний харьяа байгууллагууд тушаал, заавар, чиглэл гарган нарийвчлан зохицуулж ажилласан. Түүнчлэн тухайн хугацаанд зарим цэцэрлэг, ЕБС багш нараа дуудан ажлын байранд ажиллуулах зөрчил гаргаж байсныг БСШУСЯ хянаж ажилласан байна.

ЗГ-ын тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлыг сунгасантай холбоотойгоор БСШУС-ын Сайдын тушаалаар дээрх хугацаанд зайн сургалтыг үргэлжлүүлэх, ЕБС-ийн анги дэвших болон улсын шалгалтыг цуцлан, үүний улмаас ажил цалгардуулахгүй байхыг хариуцсан нэгж, сургалтын байгууллагад анхааруулан чиглэл өгч ажиллажээ.

Хууль батлагдахаас өмнөх эрх зүйн орчны хэрэгжилтийг дүгнэвэл, иргэдийн сурч боловсрох эрхийг баталгаатай эдлүүлэх төрийн үүргийн хүрээнд сургалтыг тасралтгүй, хүртээмжтэй зохион байгуулах зорилтыг хангахад голчлон анхаарч ажилласан. Энэхүү ажлын хүрээнд төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангахад анхаарах, эргэх холбоог сайжруулах, чиг үүргийг зааглан, ажлын зохион байгуулалтыг чанаржуулах шаардлага, хэрэгцээ буйг тодорхойлж өгсөн байна.

“Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдсанаар УИХ болон ЗГ-аас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон зааглаж өгсөн. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулж, цахим эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэхийг тодорхой зааж өгсөн. Уг хуулиар төрийн байгууллагуудын үүрэг, оролцоог тодорхой болгож өгсний үр дүнд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжрах хүлээлт байсан ч үүнийг одоогоор дүгнэхэд хангалттай мэдээлэл болон цаг хугацааны хувьд үргэлжилж буй үйл явц тул эрт байна.

Харин хуульд заасан боловсролын салбарт хамаатай тодорхой 4 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлбэл, бусад салбар, байгууллагын зүгээс боловсролын байгууллагыг өөрийн чиг үүргийн хүрээнд дэмжих, хяналт тавих нь сайжирсан боловч цар тахлын нөхцөл байдлыг харгалзан ажлын үйлчилгээний зохион байгуулалт хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгцээ байгаа нь ажиглагдаж байна. Жишээлбэл, Боловсролын хүрээлэн, аймгийн БСГ нь сургуулиудад гамшгийн үед сэтгэл санааны болон арга зүйн бэлтгэлээ хангах дэмжлэг үзүүлж, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар нь багш, сургуулиудад мэдлэг түгээж, хяналт тавьж ажиллаж байгаа бол эрүүл мэндийн байгууллагууд багш нарыг урьдчилан сэргийлэх үнэгүй үзлэгт хамруулжээ. Гагцхүү багш, сургуулийн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулахдаа дугаар дараалал, бөөгнөрөл үүсгэх нөхцөл бий болгосон бол эцэг эх, асран хамгаалагч, залуучуудад дэмжлэг болгож өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх, БШУЯ-аас их, дээд сургууль,

коллежийн төлбөрийг сар, улирлаар төлүүлэх чиглэл зэрэг хуулийн болон нарийвчилсан зохицуулалт хэрэгжихгүй, улирал, хагас жил, зарим сургууль нь бүтэн жилээр төлүүлсэн байна. Энэ бүхнээс дүгнэхэд “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилт зүйл заалтаасаа хамааран жигд бус, хэрэгжилтийг зохион байгуулахдаа цар тахлын улмаас үүссэн халдвар тарах эрсдэл, хөл хорионы улмаас өрхийн эдийн засагт үүссэн санхүүгийн эрсдэлийг тооцохгүй хэвээр байна.

Уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БСШУСЯ, түүний харьяа байгууллагууд өмнө өгсөн чиг үүрэгт хамаарах ажлаа үргэлжлүүлсэн ба 2020 оны 2-5 дугаар сард 1-12 дугаар анги, тусгай хэрэгцээт болон хос хэлний боловсролын, ЭЕШ, насан туршийн боловсролын, бага ангийн багшийн нийт 4,485 теле хичээл бэлтгэж, телевизийн 18 сувгаар дамжуулан ажилласан байна. 2019-2020 оны хичээлийн жилийн сүүлийн хагас жилд танхимын сургалтыг зайн буюу теле-хичээл, цахимд шилжүүлж сургалтын тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангахыг зорьсон гэж дүгнэж болох юм. Харин теле-хичээлд хамрагдалтыг сайжруулан, эргэх холбоог бэхжүүлэх ажлын хүрээнд теле-хичээлийн хуваарийг мэдээллийн хэрэгслээр урьдчилан зарлах болсон ч теле хичээлийн хамрагдалт жигд бус, зарим сурагч хичээлдээ огт хамрагдахгүй байх явдал судалгаанд авагдсан болно. Үүнийг дэд салбарын хүртээмж, хүн амын суурьшлын бүс, амьжиргааны түвшинтэй холбон нарийвчлан үнэлэх нь зүйтэй.

Зайн сургалтын хүртээмж буюу хамрагдалт. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зорилт болон хэрэгжилтийн үр дүнг харьцуулбал, 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгт 263,3 мянган хүүхэд, ЕБС-д 640,0 мянган хүүхэд хамрагдаж байсныг бүгдийг зайн сургалтад хамруулах томоохон зорилтыг БСШУСЯ дэвшүүлсэн боловч 2020 оны 1-6 дугаар сард хэрэгжсэн зайн сургалт нь бүх нийтийн хүртээмжтэй болж чадаагүй байна. Албан ёсны мэдээгээр, теле-хичээлд хамрагдалтын улсын дундаж 74.8 хувь байгаа бөгөөд аймгийн төв, нийслэлийн 9 дүүргийн сурагчдын оролцоо 88 хувь, аймгуудын дундаж 75 хувь, сумдын дундаж 70 орчим хувь байна. Сэлэнгэ аймаг 95.3 хувийн хамрагдалтаар улсад тэргүүлж байгаа бол Дархан-Уул аймаг 55 хувийн хамрагдалттайгаар сүүл мушгижээ. Улсын хэмжээнд теле-хичээлд огт хамрагдаагүй үлдсэн байх магадлалтай 25.2 хувийн 1-12 дугаар ангийн сурагч байгаад анхаарал хандуулах нь зүйтэй. Мөн 74.8 хувьд теле-хичээлд бүрэн хамрагдсан сурагч хэдэн хувийг эзэлж буйг тус дүнгээс ялгаж дүгнэх боломжгүй байна. Теле хичээлд хамрагдалтын дүнг сургуулиуд өөрсдөө гаргаж, Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газарт нэгтгэсэн болохыг онцолж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол. 2020 оны 4 ба 5 дугаар сард тусгай хэрэгцээт боловсролын 108 теле-хичээл ТВ-ээр цацагдсан нь ЕБС-ийн теле-хичээлээс нэг сарын дараа эхэлж, хэмжээний хувьд ЕБС-ийн 1-12 дугаар ангийн 3,429 теле-хичээл цацагдсантай харьцуулбал 3 орчим хувь нь болж байна. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд ТВ хичээлийг давтаж үзэх хэрэгцээ өндөр байдаг ч ухрааж үзэх боломжтой ТВ үйлчилгээ хүртээмжгүй, Лүүк ТВ үнэгүй хичээл тавихаа больсон, интернэтээр үзэхэд боломждоо тааруулж авсан дата нь хүрдэггүй зэргээс хичээлийг давтаж үзэх боломжгүй байжээ. Тэрчлэн олон хүн www.econtent.edu.mn вэбсайтад хичээл байршуулсан тухай мэддэггүй нь судалгааны явцад тодорхой байв.

Эцэг, эхчүүдийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас ТВ хичээлийн чанар, хүртээмж муу, хүүхдийнхээ багштай холбоо тасалдсан, эцэг, эх нь хүүхдийнхээ хичээлийг давтуулж чадахгүй байгаа зэрэг шалтгаанаар хүүхдүүд нь сурлагаар хоцорсон байх өндөр магадлалтай байна. ЕБС-д тэгш хамрагдан суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эзлэх хувь нийт суралцагчдын 1 хувьд ч хүрэхгүй байгаа тул албан эх сурвалжийн мэдээ, баримтад хөгжлийн бэрхшээлтэй сурагчидтай холбоотой мэдээлэл тун бага байгааг дурдаж байна. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай байгаа хүүхдийн онцлогт нь тохирсон сургалтын үйлчилгээг теле-хичээлээр хүргэж чадаагүй нь судалгаанд авагдсан баримтаар үнэлэгдэж байгаа болно. Хөгжлийн бэрхшээлтэй, алслагдсан орон нутгийн, хотын захын цахилгаанд холбогдоогүй өрхийн хүүхэд, мөн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдэд мөн онцгой анхаарах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалт. Судалгаа эхлэхэд 2020 он болон өмнөх оны ЭЕШ-ын онооны дундаж үзүүлэлтийг харьцуулах замаар зайн сургалт нь сурагчдын сурлагын амжилтад үзүүлсэн нөлөөг тоймлон гаргах боломжтой гэж таамагласан нь батлагдаагүй болно. ЭЕШ нь хэмжээст оноо буюу тодорхой хичээлээр тухайн жилд авсан хамгийн өндөр оноогоор бусад хүүхдийн гүйцэтгэлийг баримжаалах тархаах загвараар оноо өгдөг тул сурагчдын 2019 болон 2020 оны гүйцэтгэлийг хооронд нь харьцуулах, 2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжсэн алсын зайн сургалтын чанарыг хэмжих боломжгүй юм.

Зөвхөн 2020 онд ЭЕШ өгсөн шалгуулагчдын гүйцэтгэлээс дүгнэхэд Улаанбаатар хот, аймгийн төвийн сурагчдын дундаж оноо нь сум, багийн сурагчдын дундаж онооноос тогтмол илүү, харин хувийн сургуулийн сурагчдын дундаж оноо нь төрийн өмчийн сургуулийн сурагчдын дундаж онооноос тогтмол илүү байв. Энэ ерөнхий чиг хандлагыг зөвхөн зайн сургалтын үр дүнгээр тайлбарлах боломжгүй болохыг анхаарна уу. 2020 онд ЭЕШ-д орох сурагчдын бэлтгэлд

дэмжлэг болгож БҮТ нь ЭЕШ-д бэлтгэх 150 теле болон онлайн хичээлээс гадна гарын авлага, DVD гарган, эцэг, эхчүүдийн тодорхой хувиас цахим хэлбэрээр судалгаа авч, холбогдох байгууллагад уламжилсны дагуу 5 дугаар сарын 11-ний өдрөөс нэг сарын хугацаатай танхимын сургалт зохион байгуулах шийдвэр гаргуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллажээ. БҮТ-өөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь сургалтын тасралтгүй байх зарчмыг ханган ЕБС төгсөгч, тэдний эцэг, эхэд сэтгэл санааны дэмжлэг, шалгалтдаа бэлтгэх бодит чиг баримжаа болж чадсан гэж дүгнэж байна. Чухамдаа ЭЕШ-ын үнэлгээ нь зөвхөн шалгуулагчийн хувийн зохион байгуулалт, хичээл зүтгэл, гүйцэтгэлээс хамаарч буйг тэмдэглэх нь зүйтэй.

Их, дээд сургууль, коллежийн цахим сургалт. Монголын дээд боловсролд цахим сургалтын арга зүйг туршин нэвтрүүлэх оролдлого 2002 оноос туршигдаж, хэрэгжих боломж нөхцөлийг судалж ирсний ачаар их, дээд сургуулиуд илүү бэлтгэлтэй байсан нь нэгэнт үүссэн энэ нөхцөл байдалд давуу байдал бий болгожээ. Сургуулиуд сургалтын үйл явц, багшийн ажлын зохион байгуулалтыг зохицуулсан түр журмууд батлан хэрэгжүүлж, багш нарт цахим хичээл боловсруулан хүргэхэд нь дэмжлэг үзүүлж, технологи ашиглахтай холбоотой арга зүйн сургалт зохион байгуулж, цахим сургалтын хяналтын тогтолцоо бүрдүүлж, 2020 оны 1 дүгээр сарын 27-оос мөн оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл цахимаар хичээллэж, улирлын болон төгсөлтийн шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж улирлаа хаасан байна. Мөн 2020 онд анх удаа 100 хувь их, дээд сургуулийн цахим элсэлтийг амжилттай зохион байгуулжээ.

Багшийн ачаалал цахим хичээлийн үеэр 1,5-2 дахин нэмэгдсэн ч суралцагчдад хүргэх сургалтын чанарт энэ нь сөргөөр нөлөөлөөгүй бөгөөд хоёр төрлийн судалгаанд хамрагдсан суралцагчдын 82-90 хувь нь цахим хичээлд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлжээ. Дээд боловсролын үйлчилгээг хүргэхдээ сургуулиуд үнэгүй платформуудыг ашиглаж байгаа нь нийтлэгээр хэрэглэгчийн аюулгүй байдлыг хамгаалдаггүй, суралцагчийн бие даан судлах материалыг цахимжуулахтай холбоотой зохиогчийн эрхийн асуудал үүссэн зэрэг нь дээд боловсролыг зайн болон цахимаар хүргэх асуудлаар эрх зүйн орчин бий болгох тулгамдсан хэрэгцээ байгааг тодорхой харуулж байна.

Дээд боловсролын байгууллагуудын цахим хичээлийн чанар муу байгаа талаар суралцагчдаас гомдол, санал ирснийг БСШУСЯ-аас сургуулиудын удирдлагуудад нь мэдэгдэж, дотоод чанарын хяналт тавьж ажиллах чиглэл өгсөн нь боловсролын чанар хүртээмжид анхаарал хандуулсны илрэл юм. Дээд боловсролын байгууллага бол чанарт өрсөлддөг байгууллага тул энэхүү үүрэг чиглэлд онцгой анхаарч ажилласан нь судалгаанд авагдсан мэдээ тайлангаар

үнэлэгдэж байгаа болно. Түүнчлэн БСШУСЯ-аас төрийн өмчит 20 их, дээд сургуулийн суралцагчдыг цахим хуудаст хандах дата хэрэглээг төлбөргүй болгох хүсэлтийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч компаниудад тавьжээ. Энэ цаг үед төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудад ижил шаардлага шалгуур тавьж буй ч үйлчилгээ хөнгөлөлтийг ялгамжтай санал болгож буй нь судалгааны явцад анхаарал татсан баримт болохыг дурдаж болох юм.

Монгол Улсад алсын зайн боловсролын үйлчилгээг хүргэхэд шаардлагатай дэд бүтцийн хүртээмж чухал нөлөө үзүүлж байна. Дээд боловсролын үйлчилгээг цахим сургалтаар авахад шаардлагатай дэд бүтцийн хүртээмж манай улсад дунджаар 80.1 хувь байгаа бол ерөнхий боловсролын үйлчилгээг алсын зайнаас авах боломж улсын хэмжээнд дунджаар 77.0 хувь байх бөгөөд бүхэлдээ боловсролын алсын зайн үйлчилгээ авах дэд бүтцийн боломж дунджаар 78.6 хувь байна гэж дүгнэж байна. Интернэтийн хүртээмж манай улсад дунджаар 64 хувь, интернэтэд холбогдох төхөөрөмжийн хүртээмж ер нь хангалттай (75 хувь) байх боловч гар утасны хэрэглээ нийт өрхүүдэд 100 хувь байгаа нь үүнд нөлөөлжээ.

Гар утсаар сургалтад хамрагдахад дэлгэцийн хэмжээ, интернэтийн хурд, цахилгаан эрчим хүчний хангамж зэрэг олон зүйл нөлөөлнө. Манай улсад цахилгаан эрчим хүчний чанар дунджаар 81.6 хувь байна. Тэгш байдал талаас нь нарийвчилж харах юм бол нийслэлийн орон сууцны өрхүүд алсын зайн сургалтад хамрагдах хамгийн тогтвортой бөгөөд чанартай боломж нь бүрдсэн, аймгийн төвийн өрхүүд мөн ижил боломж сайтай байгаа ч теле хичээлийг ухрааж үзэх боломжийн хувьд хязгаарлагдмал байна. Сум, багийн болон нийслэлийн гэр хорооллын өрхүүд цахилгаан эрчим хүчний чанар, интернэтийн найдвартай байдлаараа суурин газрын өрхүүдийг гүйцэхгүй, цахилгаанд холбогдоогүй алслагдсан орон нутгийн болон хотын захын хорооллын цахилгаанд холбогдоогүй өрхүүд үндсэндээ зайн сургалтад хамрагдах хамгийн бага боломжтой байгаа нь харагдлаа. Улмаар зайн сургалтыг зохион байгуулахдаа нэгдсэн арга хандлагын зэрэгцээ өрхүүдийн дэд бүтцийн хүртээмжийг харгалзсан нэмэлт арга хэмжээг уян хатан авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед боловсролын тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангахын тулд зайн болон холимог аргыг ашиглаж байгаа бөгөөд нөөц боломж, чадавхаас хамаарч сургалтын загварууд харилцан адилгүй байгаа нь ажиглагдлаа. Зайн сургалтын хувьд эцэг, эх, асран хамгаалагч нар хүүхдийг гэрээр суралцахад нь туслах үндсэн чиг үүргээ гүйцэтгэж, урьд өмнөхөөсөө илүүтэйгээр сургалтын орчныг бүрдүүлж байна.

Зайн сургалтын агуулга, бүх өрхийн дижитал болон бусад технологийн хүртээмж, боловсролын технологийг хэрэглэх багш, сурагч, эцэг эхийн туршлага гэх мэт олон бэрхшээл тулгарч байгааг үгүйсгэх аргагүй юм. Нөгөө талаас, сургалтыг танхимаас виртуал хэлбэрт шилжүүлэхэд эдгээр сургалтын хэрэгслийг хэрэглэх чадвартай болон чадваргүй хүмүүс хоорондын зөрүү улам бүр тодорхой болж байна. Зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй зохион байгуулахад олон талын оролцоо, дэмжлэг чухал.

Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хамтын ажиллагааны үр дүнд эргэх холбоо сайжирч, чанар тодорхой түвшинд ахих боломжтойг нийслэл болон аймгийн төвийн сургуулиудын теле-хичээлийн хамрагдалтын судалгаанаас урьдчилсан байдлаар бид харж дүгнэсэн. Эдгээр нөхцөл байдал нь өнөөдрийн зайн сургалтыг боловсролын бүх түвшинд хэрэгжүүлэх үнэ цэнтэй сургамж болох төдийгүй Ковид-19 цар тахлын дараа илүү нээлттэй, тэгш хамруулсан, уян хатан боловсролын тогтолцоог бий болгох урт хугацааны зорилтын үндэс суурийг бүрдүүлэхэд давуу тал болно гэдэгт илтгэлтэй байна.

Иймд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, хүртээмжтэй зохион байгуулахад чиглэсэн доорх зөвлөмжүүдийг боловсруулан толилуулж байна. Үүнд: Зайн сургалтын цогц стратегийг төлөвлөхдөө яаралтай хэрэгцээ болон урт хугацааны зорилтын аль алиныг хамруулах шаардлагатай.

Сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын сургуулийн теле болон бусад хэлбэрийн сургалтын талаар:

- Сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын сургуулийн теле болон бусад хэлбэрийн сургалтын агуулгыг зөвхөн хичээлийн агуулгад баригдахгүйгээр хүүхдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн тодорхой хэсгийг нэмж боловсруулж байх;

- Econtent аппликейшн болон www.econtent.edu.mn вэбсайтад байршуулсан хичээл, номын талаарх мэдээллийг эцэг эх, суралцагчдад тухай бүр сурталчлан таниулах;
- Econtent аппликейшн болон www.econtent.edu.mn вэбсайтын хөгжүүлэлтийг тогтмол хийж, хэрэглэгчдийн санал гомдлыг шуурхай шийдвэрлэж байх;
- Теле-хичээлийн чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийх, гарсан алдаа дутагдлыг цаг алдахгүй залруулж байх;
- Сургуулийн насны олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл өрхүүдэд теле-хичээл болон зайны сургалтын бусад агуулгыг нөхөж үзэх боломжийг нэмэгдүүлэх;
- Теле-хичээлийг нөхөж үзэх боломжтой интернэт протоколд суурилсан телевизийн үйлчилгээний хүртээмжийг ялангуяа орон нутагт нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа харааны бэрхшээлтэй хүүхдийг гар утаснаас илүү том дэлгэцтэй интернэтэд холбогдох төхөөрөмжөөр хангах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан алсын зайн сургалтыг тусгайлан боловсруулах, ингэхдээ хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрд тохирсон сурган хүмүүжүүлэх тусгай арга, аргачлалыг ашигласан тусдаа (харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан зэрэг) хичээлүүдийг бэлтгэх, ийм төрлийн хичээлийг илүү удаан хугацаанд, бага хурдтайгаар, илүү ойлгомжтой заах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг тусгайлан үнэлэх;
- Элсэлтийн ерөнхий шалгалтын өмнө давтлага авах болон ЭЕШ-ын талаарх төрөл бүрийн мэдээллийг олж авах боломжийг алслагдсан орон нутагт нэмэгдүүлэх.

Их, дээд сургууль, коллежийн цахим сургалтын талаар:

- Алсын зайны сургалтын явцад үнэгүй хэрэглэх боломжтой программ хангамжуудын аюулгүй байдалд үнэлгээ хийх байдлаар суралцагчийн мэдээлэл алдагдах, цахим хэлбэрээр байршуулсан лекц, семинарын материал устгах, зохион байгуулсан хурал, хэлэлцүүлгийн материалд алдаа гарах зэрэг сөрөг хүчин зүйлсийг багасгах;
- Их, дээд сургуулийн сургалтын үндсэн программ хооронд интеграци хийх, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх;
- Цахим хичээлийн сэтгэл ханамжийн болон агуулгын чанарын талаар судалгааг их, дээд сургуулиас тодорхой аргачлалын дагуу тогтмол авч дүгнэдэг байх;

- Цахим хичээлийн сэтгэл ханамжийн болон агуулгын чанарын судалгаагаар дамжуулан багш нарын идэвх, санаачилга болон ачааллыг тооцоолох аргачлалыг боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлийг дээд боловсролын байгууллагуудад даалгах;
- Цахим эх сурвалжийг ашиглахдаа багш нар оюуны өмчийн эрх зөрчихгүй байх асуудлыг шийдвэрлэх зорилгоор олон улсын томоохон цахим номын сангуудтай гэрээ байгуулж багш нарт үнэ төлбөргүй ашиглуулах боломжийг нэмэгдүүлэх;
- Цахим дотоод эх сурвалжийн сан бүрдүүлж, төлбөртэй болон хөнгөлөлттэй нөхцөлөөр их, дээд сургуульд санал болгох;
- Цахим сургалтад оролцогч талуудын технологийн мэдлэг, чадварыг сайжруулахад чиглэсэн сургалтын агуулгыг бэлтгэж суралцаж буй төвшинд нь илүү тохиромжтой хэлбэрээр хүргэх.

Дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаар:

- Нийслэл Улаанбаатар хотын цахилгааны эх үүсвэргүй айл өрхүүдийг төвийн эрчим хүчинд бүрэн холбох;
- Нийслэлээс бусад хот суурин газрыг төвийн эрчим хүчинд холбох;
- Малчин өрхүүд цахилгааны чанартай эх үүсвэрээр хангагдах боломжийг нэмэгдүүлэх;
- Эрчим хүчний статистик мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Улс орон даяар интернэт протоколд суурилсан телевизийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Гар утаснаас теле-хичээл, интернэтэд байршуулсан бусад контентыг үзэх нь ЕБС-ийн сурагчдад эрүүл мэндийн хувьд ямар сөрөг нөлөө үзүүлж буйг тусгайлан судлах;
- Гар утаснаас их, дээд сургуулийн хичээлийг уншиж судлах, тодорхой сэдвээр судалгаа хийх, судалгааны тайлан бэлтгэж багшдаа илгээх боломжийг судлан дүгнэх;
- Боловсролын үйлчилгээ авч байгаа 6-24 насны хүн амын хэрэглэж байгаа интернэтэд холбогдох төхөөрөмжийн төрөл, хүрэлцээг илүү тодорхой судлан дүгнэх;
- Их, дээд сургуульд суралцагчдын хэдэн хувьд нь зөөврийн компьютер шаардлагатай байгааг, үүнээс хэд нь шаардлагатай төхөөрөмжөөр хангагдсан болохыг судлан тогтоох;
- Малчин өрхийн суралцагчдад алсын зайн сургалтын үр дүн маш сул байгаа тул тусгайлан бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй.

ISBN 991996459-X



9 789919 964597